



МОНГОЛЫН АЖИЛ ОЛГОГЧ ЭЗДИЙН
НЭГДСЭН ХОЛБОО
MONGOLIAN EMPLOYERS' FEDERATION



ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS
RESEARCH CENTER

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ
ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ



International
Labour
Organization

МОНГОЛ УЛС; “Аж ахуй эрхлэлт дэх албан бус хэвшлийг албан хэвшилд шилжүүлэх нь: өнөөгийн байдал, дүгнэлт, сорилт, шинэчлэлийн бодлогын зөвлөмж (чиглэл)”

Улаанбаатар хот
2015 он

Зохиогчийн эрх © Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага 2015
Анхны хэвлэл 2015 он

Олон Улсын хөдөлмөрийн Товчооны бүтээлүүд Зохиогчийн эрхийн тухай Түгээмэл Конвенцийн 2 дугаар Протоколд заасны дагуу зохиогчийн эрхийг эдэлнэ. Гэвч эх сурвалжийг дурьдсан тохиолдолд зөвшөөрөл авалгүйгээр тэдгээрээс иш татан ашиглаж болно. Дахин хэвлэх буюу орчуулах эрхийг авахын тулд Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны нийтлэлийн албанд (Эрх, Зөвшөөрөл) International Labour Office, CH-1211 Geneva 22, Switzerland гэсэн хаягаар, эсвэл дараах и-мэйлээр хандана уу: pubdroit@ilo.org. Олон Улсын Хөдөлмөрийн Товчоо ийм хүсэлтийг таатай хүлээн авах болно.

Хуулбарлах эрхийн байгууллагуудад бүртгэлтэй номын сан, байгууллага болон бусад хэрэглэгчид тэдэнд олгогдсон зөвшөөрлийн дагуу номыг олшруулж болно. Танай улсад буй хуулбарлах эрхийн байгууллагын талаар www.iflro.org хаягаар мэдээлэл авна уу.

“Аж ахуй эрхлэлт дэх албан бус хэвшлийг албан хэвшилд шилжүүлэх нь: өнөөгийн байдал, дүгнэлт, сорилт, шинэчлэлийн бодлогын зөвлөмж (чиглэл)”/ ОУХБ Зүүн ба Зүүн өмнөд Ази, Номхон далайн Зохистой Хөдөлмөрийн техникийн дэмжэг үзүүлэх баг – Улаанбаатар : ОУХБ , 2015 он

ISBN: 9789221295365 ; 9789221295372 (вэб pdf)

ОУХБ Зүүн ба Зүүн өмнөд Ази, Номхон далайн ЗХТДҮБ

Аж ахуй нэгж/ албан бус эдийн засаг / Монгол Улс

03.04.5

Монгол хэл дээр авах боломжтой: ISBN 9789228295368 ; 9789228295375 (вэб pdf),
Улаанбаатар хот, 2015 он

ILO Cataloguing in Publication Data

Нэгдсэн Үндэстний Байгууллагын журмын дагуу ОУХБ-аас хэвлэн нийтэлж буй бүтээлийг зохиоход ажиллуулсан хүмүүс болон түүнд дурьдсан материалууд нь аль нэг улс, газар нутаг, тэдгээрийн захиргааны эрх зүйн байдал болон хил хязгаарын талаар Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын зүгээс ямар нэгэн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

Зохиогчийн нэрээр хэвлэгдсэн аливаа нийтлэл, судалгаа, бусад бүтээлүүдэд илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн зохиогчийн өөрийнх бөгөөд хэвлэн нийтэлсэн нь түүнд илэрхийлсэн үзэл бодлыг ОУХБ-аас дэмжиж сайшаасан гэсэн утгыг агуулахгүй.

Бүтээлд пүүс, компани, арилжааны бүтээгдэхүүн, үйл явцыг дурьдсанаар тэдгээрийг ОУХБ-аас хүлээн зөвшөөрсөн хэрэг биш бөгөөд аливаа пүүс компани, арилжааны бүтээгдэхүүн, үйл явцыг дурьдахгүй өнгөрснөөр тэдгээрийг үл зөвшөөрснийг илтгэхгүй.

ОУХБ-аас хэвлэн нийтэлсэн материалуудыг томоохон номын дэлгүүрүүд, дижитал салбаруудаас мөн ilo@turpin-distribution.com хаягаар шууд захиалж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг манай Www.ilo.org/publns вэб хуудас буюу ilopubs@ilo.org мэйл хаягаар авна уу.

Монгол Улсад хэвлэв.

Гарчиг

Зураг.....	4
График.....	4
Хүснэгт.....	5
Товчилсон үг.....	6
Талархал.....	7
Өмнөх үг.....	8
Хураангуй.....	9
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ТААМАГЛАЛ, АРГА ЗҮЙ...	17
1.1. Судалгааны зорилго, таамаглал.....	18
1.2. Судалгааны арга зүй.....	21
ХОЁРДУГААР БҮЛЭГ: МОНГОЛ УЛСЫН БОЛОН УЛААНБААТАР ХОТЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	29
2.1. Монгол Улсын болон УБ хотын ДНБ-ий үйлдвэрлэл.....	30
2.2. Хүн ам ба ажиллах хүч.....	31
2.3. Бизнесийн бүртгэл.....	33
2.4. Санхүү.....	34
2.5. Албан бус хэвшил дэх хөдөлмөр эрхлэлт.....	37
ГУРАВДУГААР БҮЛЭГ: “АЛБАН ЁСНЫ АЖ АХУЙ ЭРХЛЭЛТ БОЛОН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГАА”-НЫ ҮР ДҮН.....	39
3.1. Бизнесийн бүртгэл буюу албан ёсны аж ахуй эрхлэлт.....	40
3.2. Бизнесийн орчин.....	45
3.3. Бизнесийн үйлчилгээний хүртээмж ба чанар.....	50
3.4. Хөдөлмөр эрхлэлтийн асуудлууд ба сургалт.....	52
3.5. Санхүү.....	55
3.6. Үл хөдлөх хөрөнгө болон газар ашиглалт.....	57
3.7. Гадаад худалдааны харилцаа.....	58
3.8. Бизнесийн хөгжил (инноваци, хөрөнгө оруулалт).....	59
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: СУДАЛГАА ХИЙХИЙН ӨМНӨ ДЭВШҮҮЛСЭН ТААМАГЛАЛУУД БАТЛАГДСАН ЭСЭХ.....	61
4.1. Ерөнхий таамаглал.....	62
4.2. Бизнесийн орчны хүчин зүйлүүд ба аж ахуй эрхлэлтийг албан хэлбэрт шилжүүлэх үйл явцын хоорондох хамаарлын талаар дэвшүүлсэн таамаглалууд...64	
4.3. ААН-ийн өрсөлдөх чадвар ба аж ахуй эрхлэлтийг албан хэлбэрт шилжүүлэх үйл явцын хоорондох хамаарлын талаар дэвшүүлсэн таамаглалууд...65	
4.4. Албан хэлбэрээр үйл ажиллагаа явуулахад бизнесийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ хэр хамааралтай байгаа тухай таамаглал.....	68
ТАВДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ ҮР ДҮНД ҮНДЭСЛЭН ГАРГАСАН БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ.....	69
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ.....	74
ХАВСРАЛТ А: НЭМЭЛТ ХҮСНЭГТҮҮД.....	76
ХАВСРАЛТ Б: САНАЛ АСУУЛГЫН ХУУДАС.....	78

Зураг

Зураг 1. Судалгааны зурагласан төлөвлөгөө.....	19
--	----

График

График 2.1 ДНБ-ний үйлдвэрлэл ба эдийн засгийн өсөлт.....	31
График 2.2 Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн түвшин, хувиар.....	32
График 2.3 Улаанбаатар хотод бүртгэгдсэн идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо, ажиллагчдын тооны бүлгээр.....	34
График 2.4 Улаанбаатар хот, хөдөө нутаг дахь чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл, сая төгрөг.....	35
График 2.5 Арилжааны банкнуудаас жижиг, дунд ААН-үүдэд олгосон зээл, тэрбум төгрөг	35
График 2.6 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон зээл, тэрбум төгрөг.....	35
График 2.7 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон зээлийн хуваарилалт, зээлдэгчдийн төрөл, тоогоор.....	36
График 2.8 Улаанбаатар хот, хөдөө нутгийн ААН-үүдийн төлсөн нийт албан татвар, тэрбум төгрөг.....	36
График 2.9 Улаанбаатар хот дахь ААН-ийн орлогын албан татвар төлөлт, компанийн хэмжээгээр.....	37
График 2.10 Нийт ажиллагчдын тоо, ХАА-н бус салбарт болон албан бус салбарт ажиллагчдын тоо, хүн.....	37
График 3.1 Бүртгэлийн гэрчилгээ авахын тулд хэдэн өдөр зарцуулдаг вэ гэсэн асуултад хариулсан байдал, судалгаанд хамрагдсан хүмүүст эзлэх хувиар.....	41
График 3.2 Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргах үед тулгардаг нийтлэг асуудлууд, хариултын тоогоор.....	45
График 3.3 Улаанбаатар хотын ААН-үүдийн үйл ажиллагаанд тулгардаг голлох хүндрэл, судалгаанд хамрагдсан хүмүүсийн давхардсан тоогоор өгсөн хариултад эзлэх хувиар	46
График 3.4 Таны бодлоор ямар нөхцөлд албан бус урамшуулал (гар цайлгах мөнгө) төлөх хэрэгтэй болдог вэ?.....	48
График 3.5 Улсын бүртгэлд бүртгүүлж албан ёсны үйл ажиллагаа явуулахад ААН-д ямар үйлчилгээ чухал вэ?.....	51
График 3.6 Хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулснаар ажилтны хүртэх ашиг тус.....	52
График 3.7 Ажиллагчдаа нийгмийн даатгалд хамруулсан байдал, нийгмийн даатгалд хамрагдсан ажиллагчдын эзлэх хувиар.....	54
График 3.8 Газрын гэрчилгээ авсан байдал (Бүртгэлтэй ба бүртгэлгүй ААН-үүд).....	57
График 3.9 Засгийн газрын худалдан авах ажиллагаанд оролцох үед ААН-ээс шаардагдах зүйл, хувиар.....	59
График 3.11 ААН-үүд сүүлийн 2 жилд нийт ашигаа зарцуулсан байдал.....	60

Хүснэгт

Хүснэгт 2.1 ДНБ-ний өсөлт ба бүтэц.....	30
Хүснэгт 2.2 Монгол Улсын болон Улаанбаатар хотын хүн амын өсөлтийн хувь.....	31
Хүснэгт 2.3 Бүртгэгдсэн ба үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн байршил, хувиар.....	33
Хүснэгт 3.1 Бизнесийн бүртгэлийн явцад тулгарч байсан асуудал*	41
Хүснэгт 3.2 ААН бүртгүүлсний дараа гарсан үр дагавар, хариултын тоогоор.....	43
Хүснэгт 3.3 ААН бүртгүүлснээр илүү боломж бүрдсэн, нөөцөөс хүртэх бололцоотой болсон эсэх, хариултын тоогоор.....	44
Хүснэгт 3.4 ААН-ийн үйл ажиллагаа, өргөжилтөд саад учруулдаг хууль тогтоомж, зохицуулалт, нийт санал өгсөн хүмүүсийн тоонд эзлэх хувиар.....	47
Хүснэгт 3.5 Засгийн газрын дэмжлэг, татаас авч байсан эсэх.....	49
Хүснэгт 3.6 БДҮҮ-дийн санал болгодог бизнесийн үйлчилгээний төрөл, үйлчилгээ авсан ААН-ийн тоогоор.....	50
Хүснэгт 3.7 Бичгээр байгуулсан хөдөлмөрийн гэрээтэй ажиллагчид, нийт ажиллагчдад эзлэх хувиар.....	52
Хүснэгт 3.8 ААН-д ажиллагчидтай холбоотой үүсдэг гол хүндрэл, судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн тоонд эзлэх хувиар.....	53
Хүснэгт 3.9 Ажилтнууддаа ажлын байран дээрх сургалтаас гадна албан ёсны сургалт санал болгодог эсэх, хувиар.....	53
Хүснэгт 3.10 Гадаад худалдааны нөхцөл байдлын талаарх үнэлгээ, судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн тоонд эзлэх хувиар.....	58
Хүснэгт 3.11 Аж ахуй эрхлэлт дэх албан бус байдлыг даван туулахын тулд хамгийн түрүүнд сайжруулах ёстой гэж бизнесийн орчин тодорхойлогч, бизнесийг дэмжих үйлчилгээ үзүүлэгчдээс санал болгосон асуудлууд.....	60

Товчилсон үг

ААН	Аж ахуйн нэгж
АХС	Ажиллах хүчний судалгаа
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
БДҮҮ	Бизнесийг дэмжих үйлчилгээ үзүүлэгч
БОТ	Бизнесийн орчин тодорхойлогч
БЭО	Бизнес ээлтэй орчин
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
МонАОЭНХ	Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
МХТ	Мэдээлэл, харилцааны технологи
НӨТ	Нэмэгдсэн өртгийн татвар
ОУХБХ	Олон Улсын Хөдөлмөрийн Бага хурал
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
₮	Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн албан ёсны нэгж, төгрөг
ТББ	Төрийн Бус Байгууллага
ТЗ	Төлөгдөөгүй зээл
ТМБС	Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УИХ	Монгол Улсын Их Хурал
ҮНБ	Үндэсний нийт бүтээгдэхүүн
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ЭЗХӨЧСТ	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Талархал

Энэхүү илтгэл нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо (МонАОЭНХ), Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (ЭЗБӨЧСТ), хийгээд “Мезопартнер” зөвлөх компанийн зөвлөх түнш Кристиан Шоны урт хугацааны, нягт хамтын ажиллагааны үр дүнд боловсруулсан хамтын бүтээл юм.

Судалгааны ажлыг газар дээр нь гүйцэтгэх, уулзалт, ярилцлагыг зохион байгуулах, турших, шалгах, энэхүү судалгааны тайлангийн төслийг боловсруулахад болон эцэслэн засаж бэлтгэхэд хамтран ажилласан МонАОЭНХ-ны Гүйцэтгэх захирал Хуягийн Ганбаатар, МонАОЭНХ-ны Ерөнхийлөгчийн зөвлөх Дамдинжавын Нармандах, МонАОЭНХ-ны Орлогч захирал, Бодлого, ерөнхий зохицуулалтын газрын дарга Цэнд-Аюушийн Эрдэнэбаатар, МонАОЭНХ-ны Бизнесийн харилцаа, гишүүнчлэлийн хэлтсийн дарга Чимэдцэрэнгийн Нанжидсамбуу, МонАОЭНХ-ны гадаад харилцааны хэлтсийн дарга Ганзоригийн Цацрал, ЭЗБӨЧСТ-ийн Ерөнхий захирал Боожоогийн Лакшми, ЭЗБӨЧСТ-ийн менежер Ихбаярын Одончимэг, судалгааны мэргэжилтэн Хандаагийн Отгон-Эрдэнэ, “Мезопартнер” компанийн зөвлөх түнш Кристиан Шон, ОУХБ-ын Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн Сандра Ю, ОУХБ-ын Ажил олгогч эздийн асуудал эрхэлсэн ахлах мэргэжилтэн Гэри Райнхарт нарт онцгойлон талархал илэрхийлье.

Мөн Улаанбаатар хотод 2014 оны 9 дүгээр сард судалгааны үр дүнг танилцуулах семинар зохион байгуулахад хувь нэмэр оруулсан ОУХБ-ын хамтран зүтгэгч Аж ахуйн нэгжийн тогтвортой хөгжлийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн Чарльз Бодвелл, ОУХБ-ын Ази, Номхон Далайн Бүсийн Захирал асан Ёшиэ Урамото, түүнчлэн энэхүү илтгэлийг бэлтгэхэд санал, зөвлөгөө өгч, зохих хувь нэмэр оруулсан ОУХБ-ын Монгол Улс болон БНХАУ-ыг хариуцсан Товчооны захирал Тим Дэ Мейер болон Монгол дахь ОУХБ-ын үндэсний зохицуулагч Пүрэвсүрэнгийн Болормаа нарт баярласнаа илэрхийлж гүн хүндэтгэл үзүүлж байна. Эцэст нь энэхүү үйл явцыг эхнээс нь дуустал захиргааны олон талт дэмжлэг үзүүлсэн ОУХБ-ын мэргэжилтэн Супапорн Рунтасэвээ, судалгааны илтгэлийг хянан тохиолдуулсан Колин Пипрэлл нарт талархал илэрхийлье.

Өмнөх үг

Энэхүү илтгэлийг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ), Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо (МонАОЭНХ), Эдийн Засгийн Бодлого, Өрсөлдөх Чадварын Судалгааны Төв (ЭЗБӨЧСТ)-өөс 2014 онд хамтран хэрэгжүүлсэн албан ёсны аж ахуй эрхлэлт болон өрсөлдөх чадварын судалгааны төсөлд тулгуурлан бэлтгэв. Төслийн хүрээнд хийсэн тойм ба нэмэлт судалгаа, бэлтгэсэн тайлан нь бизнес эрхлэгч ажил олгогч эзэд, төрийн албан хаагчид, санхүүгийн болон санхүүгийн бус чиглэлээр бизнесийг дэмжих үйлчилгээ үзүүлдэг Улаанбаатар хотын зарим байгууллагаас цуглуулсан дэлгэрэнгүй мэдээлэлд суурилагдсан бөгөөд албан бус салбарын асуудал, тэдгээрийг шийдвэрлэх стратегийн талаарх үндэсний бодлогын хэлэлцүүлгийг дэмжихэд чиглэгдсэн юм.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газар нь эдийн засгийн хөгжлийн талаар зарим бодлогын үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж ирсэн бөгөөд, тухайлбал “Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих хөтөлбөр” (2011), Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, “Эзэн-100” хөтөлбөр, “Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногийн төлөвлөгөө” (2014)-г санаачилжээ. Эдгээр нь эдийн засгийн хөгжлийг хурдасгах нааштай санаачлагууд юм. Гэхдээ бидний энэхүү судалгааны үр дүн нь албан бус салбарын асуудлыг шийдвэрлэхэд төр болон хувийн хэвшлийн байгууллагуудаас цаашид илүү их зүйл хийх шаардлагатай байгааг тодорхой харууллаа.

Үндэсний эдийн засаг, нийгэм, улс төрийн хөгжлийн харилцан бие биеэ нөхсөн арга хэрэгсэлд: (а) аж ахуйн нэгж албан ёсоор хөгжих ээлтэй орчин бүрдүүлэх; (б) аж ахуй эрхлэлтийг хөхиүлэн дэмжих (в) хөрөнгө оруулалтыг дэмжих зэрэг бодлого хамрагдана. Аж ахуй эрхлэх ажиллагаа нь шинэчлэлийг дэмжиж, өрсөлдөөнт эдийн засгийг бүрдүүлэн, орлого бий болгох боломжийг өргөжүүлж улмаар эдийн засгийн өргөн цар хүрээтэй хөгжлийн суурийг тавьж өгдөг.

Албан татвар, зохицуулалт, бүртгэл, тусгай зөвшөөрөл гэх мэт эдийн засгийн сайн засаглал нь биснест ээлтэй орчин бүрдүүлэх тулгын чулуу мөн. Иймээс, нэн ялангуяа өмчлөх эрхийг хангахын тулд хуулийн засаглалд шууд суурилсан бөгөөд нээлттэй, ил тод, аль болох бага хүнд суртал учруулдаг зохицуулалтын орчинтой болоход илүү их хүч чармайлт шаардагдана. Ерөнхийдөө захиргааны хэт их дарамт, зардлыг эрс бууруулах нь бизнесээ нээх, өргөжүүлэхийг хөхиүлэн дэмжих чухал арга билээ.

Жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ)-ийг албан ёсны болгож хөгжүүлэх стратегийн талаар ОУХБ-аас баримталж буй хандлага нь нэг талаас, аж ахуйн нэгжийн түвшинд бүтээмж, өрсөлдөх чадварыг ахиулахад, нөгөө талаас ажиллах нөхцөл, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгаа болно.

ОУХБ-аас Монгол Улсын Засгийн газар, нийгмийн түншүүдтэй энэ

хүрээнд нягт хамтран ажиллаж байгаа цаг үед МонАОЭНХ нь албан бус, бүх аж ахуйн нэгжийг албан ёсны болгож хөгжүүлэх таатай орчин бүрдүүлэх зорилгоор төрийн холбогдох яам, агентлаг, бусад гол байгууллагатай хамтран энэхүү илтгэлд тусгагдсан бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд илүү их хүчин чармайлт гарган ажиллах болно.



Хуягийн Ганбаатар

Монголын Ажил Олгогч Эздийн
Нэгдсэн Холбоо (МонАОЭНХ)-ны
Гүйцэтгэх захирал



Томоко Нишимото

ОУХБ-ын Ази, Номхон Далайн Бүс
(АНДБ)-ийн Захирал



Боожоогийн Лакшми

Эдийн Засгийн Бодлого, Өрсөлдөх
Чадварын Судалгааны Төв
(ЭЗБӨЧСТ)-ийн Ерөнхий захирал



Дебора Франсэ-Массин

ОУХБ-ын Ажил Олгогч Эздийн
Үйл ажиллагаа Эрхэлсэн Товчоо
(АОЭҮАЭТ)-ны Захирал

Хураангуй

Сүүлийн жилүүдэд Монгол Улс дэлхий дээр хамгийн хурдан өсөж буй эдийн засагтай орны нэг болоод байна. Монгол Улс байгалийн арвин нөөцтэй, мөн Орос, Хятад, АНУ зэрэг улстай эдийн засгийн өргөн харилцаатай байдгийн хувьд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас либеральчлагдсан зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг 1992 оноос эрчимтэй хийж, улс орныхоо баялгийг ихээхэн арвижуулжээ.

Ийм ахиц ололт байгаа ч Монголын ажиллах хүчийг шинэчлэх, эрх мэдэл шилжүүлж чадавхижуулах зорилт шийдвэрлэгдээгүй байна. Эдийн засгийн гол салбарууд нь мал аж ахуй, хөдөө аж ахуй гэх мэт уламжлалт ажиллагаанд эсвэл Монгол Улсын байгалийн баялгийн олборлолт, үйлдвэрлэлд суурилсан хэвээр байна. Аж үйлдвэрийн шинэ салбар, үйлдвэрлэл, үйлчилгээ нь гол төлөв дэд бүтцийн сул дорой хөгжил, хуучирсан технологи, түүхий эд материалын хомсдол, хөрш зэргэлдээ орнуудад байгуулагдсан салбарын хүчтэй өрсөлдөөнтэй тулгарч байна.

Эдийн засгийн төрөлжилт сул байгаа нь Монгол Улсын олон салбарт шинэ ажлын байр бий болгох, бизнесээ өргөжүүлж хөгжүүлэх, эдийн засгийн зарим ахиц гаргахад ихээхэн саад бэрхшээл учруулсаар байна. Энэ нь залуу хүн амтай, түргэн хотжиж буй энэ орны давамгайлах эдийн засгийн тогтолцоо нь томоохон албан бус эдийн засаг гэж тодорхойлж болох юм.

“Албан бус эдийн засаг” гэж хуулиар зохицуулагдаагүй эсвэл албан ёсны арга хэмжээ, зохицуулалтад хамрагдаагүй буюу хангалтгүй хамрагдсан иргэдийн болон аж ахуй, үйлчилгээ эрхэлж буй нэгжүүдийн эдийн засгийн бүх үйл ажиллагааг хэлнэ. Тэдний үйл ажиллагаа холбогдох хуулиар зохицуулагдаагүй, өөрөөр хэлбэл тэд хуулийн албан ёсны үйлчлэлийн гадуур үйл ажиллагаа явуулдаг. Харин албан ёсны арга хэмжээ, зохицуулалтад хамрагдаагүй гэдэг нь тэд хуулийн албан ёсны үйлчлэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч хууль хэрэглэдэггүй буюу зохих ёсоор хэрэглэхгүй байгаа, эсвэл хууль нь хэтэрхий дарамт учруулах буюу их зардал шаарддаг учраас хэрэгжүүлэхэд хүндрэл гардаг гэсэн үг.

Олон Улсын Хөдөлмөрийн Бага хурал, 90 дүгээр чуулган (2002)

Албан бус хэвшил дэх үйлдвэрлэлийн хэмжээ Монгол Улсын албан ёсны дотоодын нийт бүтээгдэхүүний 35 хувьд хүрнэ гэсэн тооцоо судалгаа байдаг. Аж ахуй эрхлэлт дэх албан бус ийм үйл ажиллагаа өргөжсөн нь Монгол Улсын эдийн засгийн хүчин чадлыг бодитойгоор тооцоолоход хүндрэл үүсгэж байна. Нөгөө талаас энэ нь компани, бизнес эрхлэгчдийн төрөөс дэмжлэг авах бололцоог нь хязгаарлаж, илүү найдвартай, бизнест ээлтэй орчин бүрдүүлэхэд саад учруулж байна. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид өнөөгийн хууль тогтоомж, журам, норм дүрмийг дагаж мөрдөх зайлшгүй шаардлагатай юм. Гэсэн хэдий ч олон аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчийг албан бус байдлаас урьдчилан сэргийлэх нь ихээхэн чухал ач холбогдолтой хүчин зүйл болж байна. Энэхүү судалгаа нь чухамдаа тэдгээр хүчин зүйлийг тодорхойлж, хэлэлцэх зорилготой юм.

Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо (МОНАОЭНХ), Эдийн Засгийн Бодлого, Өрсөлдөх Чадварын Судалгааны Төв (ЭЗБӨЧСТ) нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагатай хамтран “Албан ёсны аж ахуй эрхлэлт ба өрсөлдөх чадварын судалгаа” буюу энэхүү илтгэл бэлтгэхэд шаардагдах анхдагч судалгаа шинжилгээг 2013 оны 11 дүгээр сараас 2014 оны 10 дугаар сарын хооронд хийлээ. Илтгэлийн гол зорилт нь “албан бус” буюу бүртгэлгүй аж ахуйн нэгжүүдэд тулгарч буй асуудал, мөн бизнесээ албан ёсоор буюу хуулийн дагуу эрхлэхэд учирч буй саад тогторыг тодорхойлоход оршино. Анхдагч мэдээллийг 100 аж ахуйн нэгж, бизнесийн орчин тодорхойлогч (17 хүн), бизнесийг дэмжих үйлчилгээ үзүүлэгч (11 хүн)-ээс авсан судалгаа, асуулга, ярилцлагын үр дүнд цуглуулсан юм.

Энэхүү судалгааны гол үр дүн болон үүссэн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор боловсруулсан нэн даруй хэрэгжүүлэх бодлогын зөвлөмжүүд зэргийг дор танилцуулж байна.

Судалгааны гол үр дүн

- Нийслэл хот нь ДНБ-ийг хөдөө нутгаас илүү хурдацтай үйлдвэрлэж байна.

Монгол Улсын болон Улаанбаатар хотын ДНБ-ний өсөлт сүүлийн хэдэн жилүүдэд өндөр байна. 2013 онд Монгол Улсын ДНБ-ний 63,4 хувийг буюу 11,1 их наяд төгрөгийг Улаанбаатар хотод үйлдвэрлэжээ. Өнгөрсөн 3 жилд Улаанбаатар хотын ДНБ-ний жилийн дундаж өсөлт 25-37 хувь байсан бол хөдөө орон нутгийн ДНБ-нийх 22-25 хувь байснаас харахад хөдөө орон нутагтай харьцуулахад Улаанбаатар хотын ДНБ-ний үйлдвэрлэл илүү хурдацтайгаар өсөж байна.

- Монгол Улсын эдийн засгийн өсөлт нь шинэ ажлын байрыг бий болгож, ажилгүйдлийг бууруулж байна.

Тухайлбал Улаанбаатар хотын ажилгүйдлийн түвшин 2008 онд 10,9 хувь байсан бол 2013 онд 4,6 хувь болж буурсан. Мөн энэ хооронд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 89,1 хувиас 95,4 хувь болж өссөн.

- Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо нэмэгдэж байгаа бөгөөд ийм хөдөлмөр эрхлэлт нь нилээдгүй өрхийн орлогын эх үүсвэр болжээ.

2013 оны байдлаар албан бус хөдөлмөр эрхлэгч 199 мянган хүн байсан бөгөөд тэдгээрийн 97 хувь нь үндсэн ажлаараа албан бус хөдөлмөр эрхэлж байжээ. Өмнөх жилтэй харьцуулахад албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо 14,6 хувиар өссөн байна.

- Монгол Улсын эдийн засагт бичил ба жижиг үйлдвэр зонхилж байна.

ААН-үүдийн дийлэнх нь 9-өөс цөөн ажилтантай байна. 2013 онд нийт бүртгэгдсэн ААН-үүдийн 90270 нь буюу 90,6 хувь нь 1-9 ажилтантай, 4300 буюу 4,3 хувь нь 10-19 ажилтантай, 3192 нь буюу 3,2 хувь нь 20-49 ажилтантай, 1841 нь буюу 1,8 хувь нь 50 ба түүнээс дээш тооны ажилтантай байжээ.

- Монгол Улсын банк санхүүгийн салбар улам өргөжин бэхжиж байна.

2013 оны байдлаар арилжааны 13 банк, банк бус санхүүгийн 2263 байгууллага, хадгаламж зээлийн 141 хоршоо, даатгалын 17 компани, хөрөнгийн 1 бирж үйл ажиллагаа явуулж байна. Санхүүгийн зах зээлийн нийт активын 97 хувийг банкны салбар бүрдүүлдэг.

- Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 68 хувь нь бүртгэгдсэн ААН байсан.

“Бүртгэлийн гэрчилгээ авах хүсэлтээ хэрхэн гаргасан бэ?” гэсэн асуултад 72 хувь нь шууд бүртгэлийн албанд хандсан, 5 хувь нь цахим бүртгэлээр дамжуулсан, 5 хувь нь зуучлагчаар дамжуулсан, 3 хувь нь нээлттэй хаалганы өдрөөр бүртгэлийн гэрчилгээгээ авсан гэж хариулсан.

- Бүртгэлийн албаны үйл ажиллагаатай холбоотой бэрхшээлүүд байдаг хэдий ч ААН-үүдийн дийлэнх нь бүртгэлийн үйлчилгээнд сэтгэл хангалуун байна.

ААН-ийг бүртгүүлэхэд дунджаар 6,5 өдөр (албан ёсоор бол 3 өдөр) шаардагддаг гэж хариулав. Гэхдээ ААН-үүд бүртгэлийн албаны үйлчилгээний чанарт сэтгэл хангалуун байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 60 хувь нь сайн гэж үнэлжээ. Бүртгэлийн албаны үйлчилгээний чанарыг үнэлэх зорилгоор сэтгэл ханамжийн индексийг тооцвол (4 байх ёстойгоос) ААН-ийнх 2,65, БДҮҮ-дийнх 1,3, БОТ-дынх 1,65 байлаа.

- ААН-үүд болон БОТ-дод бүртгэлийн үйл явцад хамааралтай дүрэм журмын талаарх мэдээлэл дутагдалтай байдаг.

ААН-үүд бүртгэлийн гэрчилгээ авах үед тулгардаг гол бэрхшээлүүдэд гэрчилгээ бэлэн болох хугацаа нь тодорхойгүй, мөн холбогдох албаны ажилтнуудын үйлчилгээ сул байдгийг дурьдсан. Харин БОТ-ид дүрэм журам тодорхой бус, мөн төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа сул зэргийг нэрлэжээ.

- Албан ёсоор бүртгүүлснээр хүртэх ашиг.

ААН-ээ бүртгүүлснээр банкнаас зээл авах (судалгаанд хамрагдсан ААН, БДҮҮ болон БОТ-ид ингэж хариулсан), мөн зах зээл болон хэрэглэгчдэд нэвтрэх боломж бүрддэг (судалгаанд хамрагдсан ААН-үүд ингэж хариулсан) байна.

- Тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргаж зөвшөөрөл авах үед нилээн хүндрэлтэй байдаг.

БОТ-дын 65 хувь нь, ААН-үүдийн 78 хувь нь ААН-үүд тусгай зөвшөөрөл авах үед ямар нэгэн бэрхшээлтэй тулгардаг гэж хариулсан бол БОТ-дын 6 хувь нь, ААН-ийн 22 хувь нь ямар нэгэн хүндрэл тулгардаггүй гэж хариулсан.

- Улаанбаатар хотын бизнесийн орчин 2 жилийн өмнөхөөс муудаагүй байна.

Улаанбаатар хотын бизнесийн орчныг 2 жилийн өмнөхтэй харьцуулахад “сайжирсан” гэж судалгаанд оролцогчдын 46 хувь, “хэвэндээ байна” гэж 33 хувь нь хариулсан.

- Улаанбаатар хотод бизнесийн үйл ажиллагаа явуулахад тулгардаг гол бэрхшээл.

ААН-үүдийн хариултыг давтагдсан тоогоор нь эрэмбэлсэн байдлаас харахад:

- Санхүүжилтийн олдоц (44%);
- Татвар (40,7%);
- Бизнесийн өрсөлдөөн (37,4%);
- Чадварлаг ажиллах хүчний олдоц (37,4%);
- Авлига, хээл хахууль (31,9%);
- Шаардлагад нийцсэн газар (30,8%).

- ААН-ийг өргөжүүлэхэд тулгардаг гол хүндрэл.

Санал асуулгад оролцсон ААН-үүдийн 55 хувь нь татварын хууль, дүрэм ихээхэн саад бэрхшээл болдог гэсэн бол, 35 хувь нь зарим дэд салбарт үйл ажиллагаа явуулахад шаарддаг тусгай зөвшөөрөл гэжээ. Харин БОТ-дын 47 хувь нь зарим салбарын тусгай зөвшөөрөл болон хөрөнгө оруулалтын тухай хууль ААН-ийг өргөжүүлэхэд ихээхэн саад болдог гэсэн байна.

- Албан ёсны бүртгэлтэй эсэхээс үл хамааран заримдаа ААН-үүд албан бус урамшуулал төлдөг.

ААН-ийн 45 хувь нь “Тийм” гэж хариулснаас үзэхэд төрийн албан хаагчаас ямар нэгэн үйлчилгээ авахын тулд албан бус төлбөр төлөх нь энгийн үзэгдэл болжээ. Гэтэл БОТ-дын зөвхөн 18 хувь нь энэ асуулгад “Тийм” гэж хариулсан байв.

- Засгийн газрын дэмжлэг нь ААН-ийн өргөжилт болон өрсөлдөх чадварт хэрхэн нөлөөлдгийг мэдэхгүй байна.

БОТ-дын дийлэнх буюу 82 хувь нь Засгийн газрын дэмжлэг ААН-ийн

өргөжилтөд хэрхэн нөлөөлдгийг мэдэхгүй гэж хариулсан бол дөнгөж 18 хувь нь ямар нэгэн эерэг нөлөө үзүүлдэг гэжээ. Харин нааштай хариулт өгсөн ААН-үүдийн 8 хувь нь өндөр ач холбогдолтой, 42 хувь нь эерэг нөлөө үзүүлсэн, 33 хувь нь мэдэхгүй гэж хариулсан.

- Бүртгүүлэх үед хамгийн их хэрэгцээтэй болдог үйлчилгээ.

Судалгаанд оролцогчид ААН-ээ бүртгүүлж албан ёсны болгоход хамгийн их хэрэгцээтэй болдог үйлчилгээг дараах дэс дарааллаар дурьдсан:

- Нягтлан бодох бүртгэл;
- Хуулийн зөвлөгөө;
- Бизнес хөгжлийн төлөвлөгөө болон зах зээлийн судалгаа;
- Ажиллагчдын техникийн сургалт;
- Мэдээллийн технологийн сургалт.
- Ажиллагчидтай холбоотойгоор ААН-үүдэд хамгийн түгээмэл тулгардаг хүндрэл.

Дараах хүндрэлийг нийтлэг гэж дурьдсан:

- Ажиллагчдын мэргэжлийн ур чадвар;
- Ажиллах хүчний олдоц;
- Удаа дараагийн өвчлөл, ажил таслалт, ажилтны ёс зүй, ажиллагчдын сахилга гэх мэт ажиллах хүчтэй шууд холбоотой асуудлууд.
- Бизнес эрхлэгчийн хувьд чадварлаг ажилтан олох нь хамгийн бэрхшээлтэй асуудал болжээ.

ААН-үүдийн 57 хувь, БОТ-дын 59 хувь, БДҮҮ-ийн 60 хувь нь чадварлаг ажилтан олох нь бизнес эрхлэгчид тулгарч буй хамгийн бэрхшээлтэй асуудал гэсэн.

- ААН-үүд ихэвчлэн арилжааны банкнаас зээл авч байна.

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 54 хувь нь зээл авах хүсэлт гаргаж байсан бөгөөд тэдгээрийн 76 хувь нь хүссэн зээлээ авч чаджээ. Зээл авсан ААН-үүдийн 88 хувь нь арилжааны банкаар дамжуулан зээл авсан байна.

- Хүссэн зээлээ авч чадаагүй шалтгаан.

Дараах шалтгааныг нийтлэг гэж дурьдсан:

- Барьцаа хангалтгүй (32 ААН ийм хариулт өгснөөс 27 нь бүртгэгдсэн, 5 нь бүртгэгдээгүй);
- Арилжааны банкны ажилтнуудын хүнд суртал, чадваргүй байдлаас (14

ААН ийм хариулт өгснөөс 11 нь бүртгэгдсэн, 3 нь бүртгэгдээгүй);

- Банкинд таньдаг хүн байхгүй (9 ААН ийм хариулт өгснөөс 6 нь бүртгэгдсэн, 3 нь бүртгэгдээгүй);
- Бизнесийн үйл ажиллагаа бүртгэгдээгүй (8 ААН ийм хариулт өгснөөс 3 нь бүртгэгдсэн, 5 нь бүртгэгдээгүй);
- Бизнесийн төлөвлөгөө муу (4 ААН ийм хариулт өгснөөс 2 нь бүртгэгдсэн, 2 нь бүртгэгдээгүй).

- ААН-үүд зээл авах хүсэлт гаргаагүй шалтгаан.

Зээл авах хүсэлт гаргаагүй шалтгаанаа ААН-үүд дор дурьдсан дарааллаар нэрлэсэн:

- Арилжааны банкны зээлийн хүү өндөр;
- Зээл авахад дэмжих үйлчилгээ байхгүй;
- ААН-ээ бүртгүүлээгүй;
- Хэрхэн зээл авах талаар мэдээлэл дутмаг;
- Санхүүгийн байгууллагын талаар мэдээлэл дутмаг;
- Санхүүгийн өөр эх үүсвэр хайж байгаа.

Энэхүү судалгааны төсөл хэрэгжүүлэхэд дэвшүүлсэн гол таамаглал.

Бизнесийн орчны шинж байдал нь бизнес эрхлэх үйл ажиллагаагаа албан ёсны болгох эсэх талаар аж ахуйн нэгжээс гаргах шийдвэрт шууд нөлөөлдөг. Энэ талаар аж ахуйн нэгжүүдээс гаргах шийдвэр нь эргээд тэдний өрсөлдөх чадварт ч, дагалдан бий болох хөдөлмөр эрхлэлт, баялагт ч хамааралтай.

Судалгааны ажлын дээр дурьдсан гол үр дүн энэ таамаглалыг хэсэгчлэн нотолж байна.

Дараах аж ахуйн нэгжүүдийн хувьд бизнесээ бүртгүүлж, албан ёсны болгохыг зохистой алхам гэж үзэх хандлага байна:

(а) Засгийн газрын санхүүжилттэй томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх шалгуурыг хангахын тулд тусгай зөвшөөрөл шаардлагатай гэж үзэж байгаа;

(б) Олон улсын зах зээлээс нэмэлт санхүүгийн эх үүсвэр татах хүсэлтэй, гадаад худалдаа хийхээр бэлтгэж байгаа, улс төрийн хэлхээ холбоогоо өргөжүүлэх зорилготой, мөн ажил хэргийн нэр хүндээ нэмэгдүүлэх сонирхолтой байгаа.

Бүртгүүлсний дараа дээр дурьдсан бүх арга хэмжээ эсвэл зарим нь тэдний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд ихээхэн нөлөөлсөн, эерэг үр дагавар гарсан гэж судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 25 орчим хувь нь хариулсан юм. Нөгөө талаас том зорилт тавиагүй олон ААН-ийн хувьд бизнесээ бүртгүүлэх нь тодорхой, эерэг үр дагавартай биш ажээ.

Илтгэлд тусгагдсан гол зөвлөмж

- Жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ) болон бичил бизнес эрхлэгчдэд ээлтэй татварын орчныг дэмжих.
- ЖДҮ-үүд санхүүгийн сонголт хийх боломжийг өргөжүүлэх.
- Засгийн газрын худалдан авах ажиллагаанд оролцох бололцоог жижиг үйлдвэрүүдэд олгох.
- Ижил төстэй үйлдвэртэй туршлагаасаа хуваалцах замаар суралцах, сургалтад хамрагдах зардал багатай сонголт хийх өргөн боломжоор ЖДҮ-үүдийг хангах.
- Хөдөлмөрийн холбогдолтой бүх хуулийг компаниудад ойлгомжтой, дагаж мөрдөх бололцоотой болгож шинэчлэх.
- Экспортын зах зээлд гарах чадвараа нэмэгдүүлэхэд жижиг компаниудад туслалцаа үзүүлэх.
- Төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, харилцан зохицуулалтыг сайжруулах.
- Төрийн үйлчилгээний ил тод байдал, үр ашгийг нэмэгдүүлэх.

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ ЗОРИЛГО,
ТААМАГЛАЛ, АРГА ЗҮЙ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ТААМАГЛАЛ, АРГА ЗҮЙ

1.1. Судалгааны зорилго, таамаглал


Монгол Улсад бүртгэлтэй нийт аж ахуйн нэгж (ААН)-ийн 70 орчим хувь нь Улаанбаатар хотынх байв. Энэхүү мэдээлэлд тулгуурлан, мөн үндэсний хэмжээнд нийт хэдэн бизнес эрхлэгч ААН бүртгэлгүй болон албан бусаар үйл ажиллагаа явуулж байгааг тодорхойлоход хүндрэлтэй байгааг харгалзан үзээд энэхүү судалгааны хамрах хүрээг Улаанбаатар хотоор хязгаарласан. Судалгаанд нийслэлийн ААН-үүд бүртгүүлж албан хэлбэрээр үйл ажиллагаа явуулахад тулгарч буй саад бэрхшээл, ийм шийдвэр гаргахад нөлөөлж буй бизнес эрхлэх орчны нөхцөл байдлыг тодорхойлох зорилго тавилаа.

Энэхүү зорилгын хүрээнд хариулт авахаар дараах асуултуудыг томъёолсон болно:

- Бизнесээ бүхэлд нь эсвэл үйл ажиллагааныхаа зарим хэсгийг нь албан хэлбэрээр явуулах шийдвэр гаргахад бизнес эрхлэгчдэд нөлөөлж буй хамгийн чухал хүчин зүйл нь юу вэ?
- Албан бус хэлбэрээр үйл ажиллагаа явуулах нь бизнес эрхлэгчид болон ААН-үүдийн ажлын гүйцэтгэл, өрсөлдөх чадварт шууд, шууд бус ямар нөлөөлөл үзүүлдэг вэ?
- Бизнесийг дэмжих үйлчилгээний хүртээмж, чанар нь ААН-үүд бүртгүүлж албан хэлбэрээр үйл ажиллагаа явуулахад хэр зэрэг тус дөхөм үзүүлж байна вэ?

Бизнесийн орчин ба бизнес дэмжих бүтэц дэх ямар хүчин зүйлүүд нь албан хэлбэрээр үйл ажиллагаа явуулахад нөлөөлж болохыг, мөн албан хэлбэрт шилжсэнээр ААН-үүдийн өрсөлдөх чадвар хэрхэн сайжирч болохыг тодорхойлох зорилгоор судалгааны зурагласан төлөвлөгөөг дараах байдлаар гаргасан.

Зураг 1. Судалгааны зурагласан төлөвлөгөө



Судалгааны баг дээрх хандлагад суурилан дараах ерөнхий таамаглал дэвшүүлсэн:

- Монгол Улсын албан бус хэвшил албан хэвшлээс илүү хурдтайгаар хүрээгээ тэлж байна.
- Албан бус хэлбэрээр бизнесийн үйл ажиллагаагаа эхлэх нь албан хэлбэрээр эхэлснээс илүү хялбар.
- Монгол Улсад зарим ААН бүртгэлгүй, холбогдох хуулийн дагуу олгодог зөвшөөрөл буюу тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаагаа явуулдаг, мөн татвар төлдөггүй, ажиллагчидтайгаа хөдөлмөр эрхлэлтийн аман гэрээ хийдэг.
- Албан ёсны бүртгэлтэй зарим ААН албан татвар ноогдох орлогоо бүрэн мэдүүлдэггүй тул үйл ажиллагаа нь хагас албан хэлбэртэй байдаг.
- ААН-ийг албан хэлбэрээр бизнес эрхлэх талаар гаргах шийдвэрт бизнесийн орчны нөхцөл байдал нь нөлөөлдөг.

Албан хэлбэрээр бизнес эрхлэх шийдвэр гаргахад нөлөөлж болохуйц бизнесийн орчны хүчин зүйлүүд:

- ААН-ийн бүртгэлийн үйл явц (үйлчилгээний төлбөр, цаг хугацаа болон албан бус төлбөр);
- Татварын дүрэм журам, татварын болзошгүй дарамт;
- Засгийн газрын санхүүгийн туслалцаа, татаас байгаа эсэх, тэдгээрийн хэмжээ, хамрагдах боломж;
- Ажиллагчдын нийгмийн даатгал (зардал, зохицуулалт);
- Яам, агентлаг хоорондын хамтын ажиллагааны байдал;
- Хууль эрх зүйн зохицуулалт;
- Хяналт шалгалт (давтамж, төлбөр);

- Засгийн газар дэмжлэг үзүүлдэг эсэх, дэмжлэгийн төрөл, хамрагдах боломж;
- Төр-хувийн хэвшлийн түншлэл байгаа эсэх, оролцох боломж.

Албан хэлбэрээр бизнес эрхлэх болсноор ААН-үүдийн өрсөлдөх чадварт үзүүлж болох нөлөөлөл.

Албан хэлбэрээр бизнес эрхлэх нь дараах үр дагавартай байж болно:

- Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар нэмэгдэж үнэ өснө;
- Зах зээл дээр үйл ажиллагаа явуулах бололцоог өргөжүүлнэ (үйлдвэрлэл-борлуулалтын цуваанд оролцох, зах зээлд нэвтрэх боломжоор хангагдана);
- Бараа, бүтээгдэхүүн экспортолж, импортлох бололцоотой болно;
- Засгийн газрын туслалцаа авах эсвэл тендерт оролцох боломжтой;
- Гадаадын хөрөнгө оруулалт татах бололцоо өргөжинө;
- Даатгалд хамрагдах чадавхи сайжирна;
- Давуу үзүүлэлт бүхий газар авах өргөдөл гаргах чадвар эзэмшинэ;
- Илүү мэргэшсэн ажилтан хөлсөлж тогтвортой ажиллуулдаг болно;
- Засгийн газрын дэмжлэгт хамрагдах бололцоогоор хангагдана;
- Нэр хүндээ өсгөнө;
- Бизнесээ цаашид өргөжүүлэх боломжтой болно.

Албан хэлбэрээр үйл ажиллагаа явуулах тухай шийдвэрийг ААН-ээс гаргахад бизнесийг дэмжих үйлчилгээний үзүүлж болох нөлөөлөл.

Бизнесийг дэмжих дараах үйлчилгээ нь албан бус хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй ААН-ийг албан ёсны болгох үйл явцад нөлөөлдөг:

- Нягтлан бодох бүртгэл (сургалт, үйлчилгээ);
- Хууль зүйн зөвлөгөө;
- Бизнесийн төлөвлөгөө боловсруулах (стратегийн, бизнесийн загвараа сонгох, эдийн засгийн үнэлгээ хийх г.м);
- Зах зээлийн судалгаа;
- Инкубатор, сургалт, дадлагажуулалт;
- Бизнесийн удирдлагын сургалт;
- Бизнесийн талаарх ерөнхий зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;
- Мэдээллийн технологийн сургалт, компьютерийн анхан шатны сургалт;
- Техникийн ажилтны сургалт;
- Шаардагдах технологийг тодорхойлох, хайж эрэлхийлэх.

1.2 Судалгааны арга зүй

Албан бус эдийн засаг гэдгийг тодорхойлж, дүгнэлт хийхийн тулд энэхүү судалгаанд нэр томъёоны албан ёсны тодорхойлолтуудыг ашиглав. Хэдийгээр албан бус эдийн засгийн үйл ажиллагааны талаар олон улсын судалгааны материалуудад янз бүрийн нэр томъёо байгаа ч энэхүү судалгаанд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-аас гаргасан тодорхойлолтуудыг ашигласан болно.

Тодорхойлолт. БИЗНЕСИЙН ОРЧИН

Олон Улсын Хөдөлмөрийн Бага хурал (ОУХБХ)-ын 2007 оны чуулганаар “Тогтвортой аж ахуйн нэгж”-ийн өсөлт хөгжил нь баялаг үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлт, зохист хөдөлмөрийн зарчмын эх сурвалж хэмээн үзэж, тогтвортой ААН-ийн тухай үзэл баримтлалыг баталсан. Тогтвортой ААН-ийг дэмжинэ гэдэг нь ААН-үүдийг тэтгэх институци, засаглалын тогтолцоог бэхжүүлэхэд уриалан дуудаж байгаа хэрэг мөн гэж ОУХБХ-аас онцлон тэмдэглэжээ¹.

Бизнест ээлтэй орчин гэдэг нь эдийн засаг, нийгэм, улс төрийн болон байгаль орчны асуудлуудаар ангилж бүлэглэсэн, харилцан хамаарал уялдаатай нөхцөл бүрдүүлэхийг хэлнэ.

Нийтдээ 17 нөхцлийг тодорхойлсон байдаг:

Эдийн засгийн нөхцөл:

- Макро эдийн засгийн зөв, тогтвортой бодлого, эдийн засгийн сайн засаглал;
- Худалдаа, эдийн засгийн тогтвортой интеграци;
- Хууль, зохицуулалтын ээлтэй орчин;
- Хууль сахин мөрдөх, өмчлөх эрхийг хамгаалах;
- Шударга өрсөлдөөн;
- Мэдээлэл, харилцаа холбооны технологи;
- Санхүүгийн үйлчилгээнд хамрагдах боломж;
- Дэд бүтэц.

Нийгмийн нөхцөл:

- Бизнес эрхлэх соёл;
- Боловсрол, сургалт, насан туршид суралцах боломж;
- Нийгмийн шударга ёс, нийгэмшил;
- Нийгмийн зохих ёсны хамгаалал.

¹ ОУХБ: Тогтвортой аж ахуйн нэгжийг дэмжих тухай дүгнэлт (ОУХБХ, 96 дугаар чуулган, Женев, 2007). Тогтвортой аж ахуйн нэгжид Ээлтэй Орчин бүрдүүлэх талаарх ОУХБ-ын хөтөлбөр (EUSE)-ийг дараах вэб-сайтаас үзнэ үү: http://eese-toolkit.itsilo.org/index.php?option=com_content&view=article&id=94&Itemid=240&lang=en.

Улс төрийн нөхцөл:

- Эв найрамдал, улс төрийн тогтвортой байдал;
- Сайн засаглал;
- Нийгмийн яриа хэлэлцээ;
- Хүний түгээмэл эрхийг дээдлэн хүндлэх, олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг дэмжих.

Байгаль орчин хамгаалах нөхцөл:

- Байгаль орчныг хариуцлагатайгаар хамгаалах, ашиглах.

Тодорхойлолт. АЖ АХУЙ ЭРХЛЭЛТ ДЭХ АЛБАН БУС БАЙДАЛ

ОУХБ нь “албан бус байдал” гэдгийг “албан бус хэвшил” болон “албан бус хөдөлмөр эрхлэлт” гэх хосмог байдлаар хэрэглэж болно хэмээн ялгаж үздэг. Албан бус байдал гэдгийг өмнө нь үйлдвэрлэлийн нэгж (өөрөөр хэлбэл “албан бус компани”)-ийн төлөв байдлаас хамааруулан тодорхойлж байсан бол сүүлийн үед ажил (албан ч бай, албан бус ч бай ялгаагүй үйлдвэр дэх албан бус ажил)-ын төлөв байдлаас хамааруулан тодорхойлох болсон. Албан бус хэвшил болон албан бус хөдөлмөр эрхлэлт нь хоёулаа албан бус эдийн засагт хамаарагдана.

ОУХБ-ын Олон Улсын Хөдөлмөрийн Статистикчдийн Бага хурал тоо бүртгэлийн хэмжил зүйд ашиглах зорилгоор дээр дурьдсан ялгааг харуулсан статистикийн тодорхойлолтыг батлан гаргажээ².

1993 онд Олон Улсын Хөдөлмөрийн 15 дугаар Бага хурлаас “Албан бус хэвшил”-ийг бүртгэлгүй эсхүл (үндэсний хэмжээнд тогтоосон ажиллагчдын тооны хувьд) жижиг гэгдэх хувьцаат бус, хувийн ААН-үүд хэмээн тодорхойлсон байдаг.

Хэрвээ өмчийн эзэн (эзэд)-ээс хараат бус, тусгаар хуулийн этгээд байдлаар үүсэн байгуулагдаж чадаагүй, иж бүрэн данс хөтөлдөггүй бол аж ахуйн нэгжийг хувьцаат бус гэнэ. Зөвхөн өрхийн хэрэгцээнд эцэстээ ашиглах зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа эсхүл үйлчилгээ үзүүлж буй нэгжүүдийг хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, загас агнуурын салбарын ААН хэмээн үзэж хасна.

2003 онд Олон Улсын Хөдөлмөрийн 17 дугаар Бага хурлаас “Албан бус хөдөлмөр эрхлэлт”-ийг албан бус ААН-дээ ажилладаг хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил олгогч хэмээн тодорхойлсон байдаг. Үүнд албан эсхүл албан бус ААН-ийн ажиллагчид болон өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогчид мөн хамрагдана. Үүний зэрэгцээ өрхийн аж ахуйд цалин хөлстэй ажиллагч, өөрийн хэрэгцээнд эцэстээ ашиглах зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа хувиараа хөдөлмөр эрхлэгчийг хамруулдаг.

2 ОУХБ: Албан бус байдлыг хэмжихүй: Албан бус хэвшил ба албан хөдөлмөр эрхлэлтийн талаарх статистикийн шинэ гарын авлага (Олон Улсын Хөдөлмөрийн Товчоо, Женев, 2013).

Албан бус гэдгийг тухайн улсын хууль эрх зүй, институцийн хүрээнд авч үзнэ³. Дараах гурван төрлийн хууль эрх зүй, зохицуулалт шууд хамааралтай байдаг:

(а) худалдаа арилжааны болон бизнесийн бүртгэлийг хамарсан бизнесийн холбогдолтой хуулиуд;

(б) хөдөлмөр эрхлэлт, ажиллагчдын эрх, нийгмийн хамгааллын асуудлыг зохицуулсан хөдөлмөрийн тухай хуулиуд;

(в) эд хөрөнгийг бүтээгч капитал болгох ур чадварт нөлөөлөх өмчлөх эрх (газар, санхүүгийн үнэт цаас зэрэг).

Эдгээр хууль, зохицуулалт болон тэдгээрийг хэрэгжүүлж, хүчин төгөлдөр болгох үүрэгтэй институциуд нь дараах нөхцөл байдлаас хамааран сайтар эсвэл тааруухан үйл ажиллагаа хэрэгжүүлж болно:

(а) ААН болон ажиллагчдын хувьд ямар өртөг зардал, үр өгөөжтэй байгаа;

(б) хууль, зохицуулалт болон институциуд нь ААН албан бус байдлаасаа гарч албан ёсных болохыг дэмжих хандлагатай эсхүл албан бус хэвээр үлдэхийг дэмжих хандлагатай байгаа.

Энэхүү илтгэлд бизнес эрхлэгчид болон ААН-ийн төлөв байдлаас хамаарах албан бус байдал гэдэгт анхаарал төвлөрүүлсэн бөгөөд бизнесийн орчны нөхцлүүд ААН албан бус байдлаасаа гарахыг хэрхэн хөнгөвчилж байгаа эсвэл саад учруулж байгааг судалсан.

Иймээс дээр дурьдсан хууль эрх зүйн хүрээнд энэхүү судалгаа нь худалдаа арилжааны болон бизнесийн бүртгэлийг хамарсан бизнесийн холбогдолтой хуулиуд, бизнесийн орчны нэг хэсэг болох хөдөлмөрийн тухай хуулиудын талаар зарим төсөөлөл өгнө.

Тодорхойлолт. АЖ АХУЙН НЭГЖИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР

Эцэст нь, дээр дурьдсанчлан энэхүү судалгааны төсөл нь албан ёсны аж ахуй эрхлэлт ба өрсөлдөх чадвар хоорондын харилцааг судалсан. Өрсөлдөх чадварыг үндэсний, бүс нутгийн, аж үйлдвэрийн салбарын эсвэл тухайн ААН-ийн гэх мэт янз бүрийн түвшинд тодорхойлж болно. Энэхүү судалгаанд ААН-ийн түвшин дэх өрсөлдөх чадварыг судалсан. ААН-ийн өрсөлдөх чадвар нь аль нэг компанийн зах зээлд бараа, бүтээгдэхүүн борлуулж нийлүүлэх боломж, хүч чадал тухайн зах зээл дэх бусад ААН-ийн хүчин чадал, гүйцэтгэлтэй харьцуулахад ямар байхаас хамаарна.

Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд ААН-үүд холбогдох давуу тал бий болгох замаар өөрсдийн өрсөлдөх чадварыг тордон сайжруулахын тулд ажилладаг билээ.

3 ОУХБ: Зохист хөдөлмөр ба албан бус эдийн засаг. Олон Улсын Хөдөлмөрийн Бага хуралд тавьсан Ерөнхий захирлын илтгэл. (Олон Улсын Хөдөлмөрийн Товчоо, Женев, 2002).

ААН-ийн түвшинд өрсөлдөх чадвар нэмэгдсэнийг хэмжих үзүүлэлтүүдэд мэдлэг, технологи худалдан авалт, бүтээмж, зах зээлийн өргөжилт, бүтээгдэхүүний нэр төрлийн олшруулалт, инноваци, ашгийн өсөлт, хүчин чадал өргөтгөхөд оруулсан хөрөнгө оруулалт, ААН-ийн дээшилсэн нэр хүнд хамрагдана.

Олон Улсын Хөдөлмөрийн Бага хурлын “Тогтвортой ААН-ийн тухай” 2007 оны тайланд өрсөлдөх чадвар нь ААН-ийн гадаад, дотоод нөхцөл байдлаас шалтгаална гэж заасан. Гадаад нөхцөл байдлыг өмнө дурьдсан бол дотоод нөхцөлд дараах зүйлийг хамруулна:

- Сайн менежмент, аж ахуй эрхлэлт;
- ААН-ийн түвшин дэх ажиллагчид менежерүүд хоорондын тогтвортой харилцаа болон нийгмийн яриа хэлэлцээ;
- Шилдэг технологи, тоног төхөөрөмж;
- Эрүүл, ур чадвартай ажилтан, санхүү (зээл, хөрөнгө оруулалт) гэх мэт нөөц болон эрчим хүч, газар, мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ) зэрэг материаллаг болон байгалийн баялаг ашиглах боломж.

Тайлангийн дүгнэлтэд өрсөлдөх чадвар үнэт зүйл дээр тулгуурласан байх ёстойг онцлон тэмдэглэсэн. Хүний эрх, хөдөлмөрийн суурь хэм хэмжээг хүндэлж, ажиллагчиддаа зохих ур чадвар, чадамж эзэмшүүлж, тэдгээрийг үр дүнтэй ашиглан, зохист хөдөлмөрт тавигдаж буй шаардлагыг хангах нь тогтвортой ААН-ийн шинж бөгөөд эдгээр нь ААН-ийн өрсөлдөх чадварыг дээшлүүлдэг⁴.

Тодорхойлолт. ЗОХИСТ ХӨДӨЛМӨР⁵

“Зохист хөдөлмөр” нь ажиллаж амь зуухдаа хүмүүсийн хүрэхийг хүсэж буй эрмэлзлийн товч илэрхийлэл юм. Зохист хөдөлмөрийн үзэл баримтлал нь: үр бүтээлтэй, шударга орлогоор хангахуйц ажил эрхлэх боломжийг; ажлын байран дахь аюулгүй байдал, гэр бүлийн нийгмийн хамгааллыг; хувь хүний хөгжил, нийгмийн интеграцийн илүү сайн хэтийн төлөвийг; хүмүүс үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэх, зохион байгуулах, амьдралд нь нөлөөлөх шийдвэр гаргахад оролцох эрх чөлөөг; эрэгтэй, эмэгтэй бүх хүний боломж, нөхцөл адил тэгш байх зарчмуудыг хамардаг.

Тодорхойлолт. ХӨДӨӨ НУТАГ/АЙМАГ

Хөдөө нутаг/аймаг гэдэгт Улаанбаатар хотоос бусад Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамруулсан.

Энэхүү илтгэлийг бэлтгэхэд бизнес эрхлэгчид, төрийн байгууллагын

4 ОУХБ: Тогтвортой аж ахуйн нэгжийг дэмжих тухай дүгнэлт (Олон Улсын Хөдөлмөрийн Товчоо, Женев, 2007).

5 ОУХБ: Орон нутгийн засгийн хөгжил ба зохист хөдөлмөрийн судалгааны эмхтгэл (Олон Улсын Хөдөлмөрийн Товчоо, Манила, 2006).

ажилтнууд, бизнесийг дэмжих санхүүгийн ба санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэгчдээс авсан санал асуулгын үр дүнг ашигласан.

Төрийн байгууллагын ажилтнууд, бизнесийг дэмжих санхүүгийн ба санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэгчдээс тусдаа санал асуулгын хуудсаар мэдээлэл цуглуулав. Эдгээр хуудсанд тусгасан зарим асуулт нь ААН-үүдээс авсантай адил байсан.

Судалгаагаар албан хэлбэрт шилжих үйл явц, түүнчлэн ААН-д хуримтлагдсан туршлагын талаар санал асуулгад оролцогчдоос мэдээлэл олж авахыг хичээсэн юм. Мөн санал асуулгад оролцсон ААН-үүдийн төлөөлөл, бизнесийг дэмжих үйлчилгээ үзүүлэгчид, төрийн байгууллагын зарим хүмүүсийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж судалгааны урьдчилсан үр дүнгийн талаарх санал зөвлөмжийг сонслоо.

ААН-үүд, бизнесийн орчин тодорхойлогчид (БОТ) болон бизнесийг дэмжих үйлчилгээ үзүүлэгчид (БДҮҮ)-тэй урьдчилан цаг товлож, санал асуулгын хуудсыг (Хавсралт Б-гээс үзнэ үү) ашиглан тухайн байгууллагын ажилтнуудтай ярилцлага хийх замаар судалгааг хийсэн. Судалгаанд хамрагдсан болон семинарт оролцсон бүлгийн тухай тодорхой мэдээллийг дараах хүснэгтүүдэд орууллаа.

а) 100 компани (ААН)-ийн дээд түвшний удирдах ажилтнууд

ААН-ийн хэмжээ, ажиллагчдын тооны бүлгээр	Барилга			Тавилга үйлдвэрлэл		Нэхмэл сүлжмэл			Барилгын материал үйлдвэрлэл		Худалдаа борлуулалт			Тээвэр		Оёдол			Нийт
	Бүртгэлтэй	Бүртгүүлээгүй	Хариулах боломжгүй	Бүртгэлтэй	Бүртгүүлээгүй	Бүртгэлтэй	Бүртгүүлээгүй	Хариулах боломжгүй	Бүртгэлтэй	Бүртгүүлээгүй	Бүртгэлтэй	Бүртгүүлээгүй	Хариулах боломжгүй	Бүртгэлтэй	Бүртгүүлээгүй	Бүртгэлтэй	Бүртгүүлээгүй	Хариулах боломжгүй	
1-4 ажилтантай	7	2	2	2	1	2	2		2	1	11	4		1	1	1	3	2	44
5-9 ажилтантай	3	1					1		2	1	6	4	1	2	1		1		23
10-19 ажилтантай	1							1			3	1		1					7
20 ба түүнээс дээш ажилтантай	6	1		1		1			3		8			4		1	1		26
Нийт	17	4	2	3	1	3	3	1	7	2	28	9	1	8	2	2	5	2	100

Албан болон албан бус хэлбэрээр бизнес эрхэлж байгаа 100 ААН-ийн удирдах ажилтан судалгаанд хамрагдсан бөгөөд эдгээр ААН-ийн 68 нь бүртгэлтэй, 26 нь огт бүртгүүлээгүй байсан.

б) Бизнесийн орчин тодорхойлогчид (БОТ): ААН-үүдэд төрийн үйлчилгээг хүргэдэг, бизнесийн орчинд шууд ба шууд бусаар нөлөөлдөг төрийн бодлого боловсруулж хэрэгжүүлдэг төрийн 17 байгууллагын удирдах ажилтан.

Бодлого боловсруулагч яамд, тохируулагч ба хэрэгжүүлэгч агентлагууд

- 1 Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар
- 2 Нийслэлийн эдийн засгийн хөгжлийн газар
- 3 Албан бус эдийн засгийн холбоо
- 4 Улаанбаатар хотын хөдөлмөрийн газар
- 5 Хөдөлмөрийн судалгааны институт
- 6 Барилга, хот байгуулалтын яам
- 7 Эдийн засгийн хөгжлийн яам
- 8 Сангийн яам
- 9 Хөдөлмөрийн яам
- 10 Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
- 11 Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
- 12 Зам, тээврийн яам
- 13 Сонгино хайрхан дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс
- 14 Нийслэлийн мэргэжлийн хяналтын ерөнхий газар
- 15 Улсын бүртгэлийн ерөнхий газар
- 16 Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
- 17 Сонгино хайрхан дүүргийн татварын хэлтэс

в) Бизнесийг дэмжих үйлчилгээ үзүүлэгчид (БДҮҮ): ААН-үүдэд санхүүгийн ба санхүүгийн бус үйлчилгээ үзүүлдэг 11 байгууллагын төлөөлөл.

Бизнесийг дэмжих үйлчилгээ үзүүлэгчид

- 1 Аудитын компани
- 2 Нягтлан бодох бүртгэлийн холбоо
- 3 Бизнесийн хөгжлийг дэмжих төв
- 4 Бизнес инкубатор төв (хувийн)
- 5 Бизнес инкубатор төв (төрийн)
- 6 Ажил олгогчийн сургалтын төв
- 7 Төрийн банк
- 8 “Хас” банк
- 9 “Эко капитал” банк
- 10 “Кредит монгол” банк бус санхүүгийн байгууллага
- 11 “Монгол даатгал” компани

Дээр дурьдсан 3 бүлэг оролцогчдоос нийт 8 бүлэгт хуваасан 80 гаруй асуулт⁶ асуусан болно. Нийт асуултын 70 орчим хувь нь адил буюу ойролцоо агуулгатай асуулт байсан бөгөөд энэ нь 3 бүлэг оролцогчид нэг төрлийн асуудлыг хэрхэн дүгнэж байгааг харьцуулан судлах бололцоо олгосон юм. Ялангуяа ААН-үүд болон БОТ-ид төрийн үйлчилгээний чанарыг хэрхэн дүгнэсэн нь сонирхол татахуйц байлаа.

6 ААН-ээс авах санал асуулгад 73, БОТ-доос авах санал асуулгад 83, БДҮҮ-дээс авах санал асуулгад 80 асуулт тус тус оруулсан.

Судалгааны дүгнэлтийг статистик мэдээлэл болон санал асуулгын дүнд үндэслэн гаргав. Судалгааны багийг Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо (МОНАОЭНХ), Эдийн Засгийн Бодлого, Өрсөлдөх Чадварын Судалгааны Төв (ЭЗБӨЧСТ)-ийн ажилтнуудаас бүрдүүлсэн.

Бангкокк дахь ОУХБ-ын Бүсийн Товчоо техникийн дэмжлэг үзүүлж ажилласны зэрэгцээ ОУХБ-ын хамт олон, олон улсын зөвлөхийн зүгээс судалгааны явцад гурван удаа хамтарсан арга хэмжээ хэрэгжүүлж судалгааны багийг дэмжиж байлаа. Олон улсын зөвлөх нь бэлтгэл хангах, техникийн шийдэл боловсруулах ажлын үе шатны туршид буюу 2013 оны 10 дугаар сард судалгааны зорилго, арга хэрэгсэл, үе шатны талаар чиг баримжаа олгох болон арга зүй боловсруулж загварчлах, судалгааны таамаглал томъёолох ажилд туслах зорилгоор судалгааны багтай хамтран ажилласан. Санал болгож буй судалгааны аргачлал, таамаглалыг Улаанбаатар хотод 2013 оны 10 дугаар сарын 29-нд болсон семинар дээр гол оролцогч талуудад танилцуулж, тэдний санал хүсэлтийг сонссон.

Цуглуулсан мэдээлэл, материалд боловсруулалт хийж дүн шинжилгээ хийх үе шатанд 2014 оны 2 дугаар сард судалгааны эхний үр дүн танилцуулах семинарыг Улаанбаатар хотод зохион байгууллаа. Семинарт оролцогчид нь барилга, нэхмэл эдлэл, барилгын материал үйлдвэрлэлийн салбарын албан ба албан бус жижиг үйлдвэрүүдийн холимог төлөөлөл байв. Эдгээр үйлдвэр дунджаар 5 ажиллагчтай байсан бөгөөд хамгийн том компани нь 20 ажилтантай байв. Албан бус эдийн засгийн холбооны төлөөлөл мөн оролцлоо.

Судалгааны үр дүнг танилцуулах үе шатыг 2014 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан юм. Энэхүү семинарт яамд, ОУХБ-ын удирдах албан тушаалтнууд, ААН-үүд, мэргэжлийн холбоод, төрөл бүрийн салбар дахь албан бус эдийн засгийн холбоодын төлөөлөл, ЭЗБӨЧСТ, МОНАОЭНХ-ны ажилтнууд оролцов. Семинарт Монгол Улсын Хөдөлмөрийн дэд сайд, ноён Ж. Батхуяг, МОНАОЭНХ-ны Гүйцэтгэх захирал, ноён Х.Ганбаатар, ОУХБ-ын Ази, Номхон Далайн Бүсийн захирал, ноён Ёшиэ Урамото нар оролцож шууд хувь нэмэр оруулсан болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: МОНГОЛ УЛСЫН БОЛОН УЛААНБААТАР ХОТЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

ХОЁРДУГААР БҮЛЭГ: МОНГОЛ УЛСЫН БОЛОН УЛААНБААТАР ХОТЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1. Монгол Улсын болон УБ хотын ДНБ-ний үйлдвэрлэл

Монгол Улсын эдийн засаг 2013 онд өмнөх оноос 11,7 хувиар өссөн. 2005 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ний хэмжээ 6,1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оныхоос 0,64 их наяд төгрөгөөр нэмэгдсэн. Оны үнээр тооцсон ДНБ 18,4 их наяд төгрөгт хүрч өмнөх оныхоос 3,79 их наяд төгрөгөөр өсчээ⁷.

2013 онд Улаанбаатар хотод ДНБ-ний 63,4 хувь буюу оны үнээр тооцсон 11,1 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгджээ. Сүүлийн 3 жилд оны үнээр тооцсон ДНБ-ний жилийн дундаж өсөлт Улаанбаатар хотод 24,72-оос 36,54 хүртэл хувьд хүрч байсан бол хөдөө нутагт 22,48-аас 25,49 хүртэл хувьтай байсан. Энэ нь Улаанбаатар хотын эдийн засгийн өсөлт нь хөдөө орон нутгийн өсөлтөөс илүү хурдацтай байгааг илтгэж байна.

Хүснэгт 2.1 ДНБ-ний өсөлт ба бүтэц

Он	ДНБ-ний өсөлт, хувь		ДНБ-ний бүтэц, хувь	
	Улаанбаатар хот	Хөдөө нутаг	Улаанбаатар хот	Хөдөө нутаг
2009	11,43	10,34	60	40
2010	33,33	19,23	62,7	37,3
2011	36,54	22,58	65,1	34,9
2012	25,35	34,21	63,6	36,4
2013	24,72	25,49	63,4	36,6

Эх сурвалж: ҮСХ, Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2013, Хуудас 211,212


2013 онд Монгол Улсын ДНБ-ний 51,6 хувийг үйлчилгээ, 33,9 хувийг аж үйлдвэр, барилга угсралт, 14,5 хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлж байсан бол Улаанбаатар хотын ДНБ-ний 63,3 хувийг үйлчилгээ, 36,2 хувийг аж үйлдвэр, барилга угсралтын салбарууд эзэлж байв.

Сүүлийн 5 жилд Улаанбаатар, хөдөө орон нутгийн ДНБ-ний бүтцэд огцом өөрчлөлт гараагүй.

Монгол Улсын Засгийн газраас ирэх 3 жилд ДНБ-ний жилийн дундаж өсөлт “14,6 хувь” байна гэж таамаглажээ.

⁷ Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2014 оны 1 дүгээр сар, хуудас 13

График 2.1 ДНБ-ний үйлдвэрлэл ба эдийн засгийн өсөлт⁸



Эх сурвалж: Монгол Улсын 2013 оны макро эдийн засгийн төлөв байдал, Илтгэл <http://www.parliament.mn/files/download/45734/>

2.2. Хүн ам ба ажиллах хүч

Монгол Улсын хүн амын тоо 2013 оны эцэст урьдчилсан байдлаар 2930,3 мянга болж өмнөх оноос 62,6 мянган хүнээр буюу 2,18 хувиар өссөн. Нийт хүн амын 46,8 хувь буюу 1372 мянга нь Улаанбаатар хотод амьдарч байна.

Хүснэгт 2.2 Монгол Улсын болон Улаанбаатар хотын хүн амын өсөлтийн хувь

Он	Монгол Улсын нийт хүн амын өсөлт	Улаанбаатар хотын хүн амын өсөлт	Монгол Улсын нийт хүн амын дунд Улаанбаатар хотын хүн амын эзлэх хувь
2008	2,2	4,1	39,9
2009	2,0	2,4	40,7
2010	1,8	3,4	45,1
2011	1,0	11,9	45,8
2012	1,9	3,8	46,0
2013	2,2	4,1	46,8

Эх сурвалж: УСХ, Монгол Улсын статистикийн эмхтгэл, 2013

Монгол Улсын хүн амын өсөлтөд дараахь хүчин зүйлүүд нөлөөлж байна:

1. Хүн амын дундаж наслалт уртассан. Тухайлбал, 2009-2013 оны хооронд эрэгтэйчүүдийн дундаж наслалт 64,33-аас 65,42-д хүрсэн бол эмэгтэйчүүдийнх 71,79-өөс 75,01-д хүрчээ.
2. Хүн амын төрөлт нэмэгдсэн. 1000 хүнд ногдох төрөлтийн тоо 2010 онд 23,1 байсан бол 2013 онд 27,5 болж нэмэгдсэн. 2013 онд 79780 орчим төрөлт бүртгэгдсэн нь 2010 оныхоос даруй 16510-аар илүү байжээ.

2014 оны эхний улирлын байдлаар Монгол Улсын нийт хүн амын 40 орчим хувь буюу 1160,3 мянга нь эдийн засгийн идэвхитэй хүн ам байгаа бөгөөд эдгээрээс 1051,6 мянга буюу 90,6 хувь нь ажиллагчид, 108,7 мянга буюу 9,4 хувь нь ажилгүй иргэд байв.

⁸ Монгол Улсын Их Хурал: Монгол Улсын 2013 оны макро эдийн засгийн хүлээгдэж буй гүйцэтгэл, 2014 оны хандлага, Илтгэл (Монгол хэл дээр), <http://www.parliament.mn/files/download/45734/>

ҮСХ-ны албан ёсны тодорхойлолтоор бол “ажилгүй иргэн” гэж “тухайн цаг хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ”⁹.

Монгол Улсын цаг уурын нөхцөл нь хөдөлмөр эрхлэлтэд хүчтэй нөлөөлдөг. Өвлийн улиралд зарим салбарын ажлыг үргэлжлүүлэх боломжгүй байдаг.

2014 оны эхний улирлын байдлаар Монгол улсын нийт ажиллагчдын 269,1 мянга буюу 25,6 хувь нь мал аж ахуйн салбарт, 285,4 мянга буюу 27,1 хувь нь хувийн ААН, байгууллагад, 235,4 мянга буюу 22,4 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 194,5 мянга буюу 18,5 хувь нь төсөвт байгууллагад¹⁰, 43,0 мянга буюу 4,1 хувь нь төрийн өмчит үйлдвэрийн газарт, 17,4 мянга буюу 1,6 хувь нь ТББ-д, 6,8 мянга буюу 0,6 хувь нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт тус тус ажиллаж байв.

Нийт ажиллагчдыг байршлаар авч үзвэл 426,6 мянга буюу 40,6 хувь нь Улаанбаатар хотод, 230,8 мянга буюу 21,9 хувь нь Хангайн бүсэд, 169,1 мянга буюу 16,3 хувь нь Төвийн бүсэд, 147,1 мянга буюу 14,0 хувь нь Баруун бүсэд, 77,9 мянга буюу 7,4 хувь нь Зүүн бүсэд ногдож байна.

Ойрын жилүүдэд Монгол Улсын эдийн засгийн өсөлт нь ажлын байрыг шинээр бий болгож, ажил эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх хандлагатай байна. Тухайлбал, Улаанбаатар хотын ажилгүйдлийн түвшин 2008 онд 10,9 хувь байсан бол 2013 онд 4,6 хувь болж буурсан бол хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2008 онд 89,1 хувь байсан бол 2013 онд 95,4 хувь болж өссөн (график 2.2).

График 2.2 Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн түвшин, хувиар



Эх сурвалж: ҮСХ, Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2013 он, Хуудас 57-59

Эдийн засгийн өсөлт нь хот, хөдөөгөөр ялгаатай байгаа учраас хөдөө нутагт ажлын байр хангалттай нэмэгдэхгүй байна. Хөдөө нутаг дахь ажилгүйдлийн түвшин 2008 онд 7,8 хувь байсан бол 2013 онд 9,87 хувь болж 2 орчим хувиар өсчээ. Харин ажил эрхлэлтийн түвшин 2008 онд 92,2 хувь байсан бол 2012 онд 90,9 хувь болж 1,3 хувиар буурсан байна.

Монгол Улсын эмэгтэй, эрэгтэй ажиллагчдын тооны харьцааны хувьд сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин нэмэгдэх хандлага

9 Ажиллах хүчний судалгаа, ҮСХ

10 Төсөвт байгууллага гэж төрийн захиргааны болон орон нутгийн засаг захиргааны өмчлөлд ажилладаг, бүртгэлтэй, ашгийн төлөө бус байгууллагыг хэлнэ.

ажиглагдаж байна. Жишээлбэл, 2008-2013 онд нийт ажиллагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 51,5-аас 52-т хүрсэн бол эрэгтэйчүүдийн эзлэх хувь 48,5-аас 48 болж буурчээ.

2.3. Бизнесийн бүртгэл

Монгол Улсад 2013 онд 99603 ААН бүртгэгдсэн¹¹ бөгөөд эдгээр ААН-ийг хариуцлагын хэлбэрийн хувьд авч үзвэл компани 82904, төрийн өмчит үйлдвэрийн газар 308, хоршоо 3227, нөхөрлөл 2537, төсөвт байгууллага 3938, төрийн бус байгууллага (ТББ) 6468, бусад ААН (хувийн цэцэрлэг, сургууль г.м) 221 бүртгэгджээ. 2013 онд шинээр 9076 ААН бүртгүүлсэн.

2013 оны байдлаар нийт бүртгэгдсэн ААН-ийг хариуцлагын хэлбэрээр нь 2009 оныхтой харьцуулахад компанийн хэлбэрээр бүртгэгдсэн ААН-үүдийн тоо 48 хувиар, бусад ААН (хувийн цэцэрлэг, сургууль г.м)-үүдийн тоо 183,3 хувиар нэмэгджээ. Харин ТББ, төрийн өмчит үйлдвэрийн газар, төсөвт байгууллага, нөхөрлөлийн хэлбэрээр бүртгүүлсэн ААН-үүдийн тоо 6,5, 44,7, 10,7, 23,2 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 2. 3 Бүртгэгдсэн ба үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн байршил, хувиар

Он	Нийт бүртгэгдсэн ААН-ийн тоонд Улаанбаатар хотод бүртгэлтэй ААН-ийн эзлэх хувь	Улаанбаатар хотод бүртгэлтэй ААН-үүдээс идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа	Нийт бүртгэгдсэн ААН-ийн тоонд хөдөө нутагт бүртгэлтэй	Хөдөө нутагт бүртгэлтэй ААН-үүдээс идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй
2009	70,2	50,8	29,8	72,1
2010	72,7	50,1	27,3	69,8
2011	70,0	65,4	30,0	85,2
2012	72,6	50,5	27,4	75,6
2013	71,9	48,5	28,1	72,1

Эх сурвалж: *ҮСХ, Монгол Улсын статистикийн эмхтгэл, 2013, хуудас 379-380*


2013 онд нийт 99603 ААН бүртгэгдсэний 71,9 хувь нь Улаанбаатар хотод, 28,1 хувь нь хөдөө нутагт бүртгэлтэй байв. Харин Улаанбаатар хотод бүртгэлтэй ААН-үүдийн 34777 нь буюу 48,5 хувь нь, хөдөө нутагт бүртгэлтэй ААН-үүдийн 20152 нь буюу 72,1 хувь нь идэвхитэй үйл ажиллагаагаа явуулдаг аж¹².

2013 онд Улаанбаатар хотод идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдээс 30269 нь 1-9 ажилтантай, 1897 нь 10-19 ажилтантай, 1466 нь 20-49 ажилтантай, 1145 нь 50-иас дээш тооны ажилтантай байна. 10-аас дээш ажилтантай ААН-үүдийн тоо 2011 оноос өссөн бөгөөд идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийн эзлэх хувь ч гэсэн өссөөр иржээ.

11 Энэ тохиолдолд “бүртгэгдсэн” гэдэг нь татвар төлөх үүрэг бүхий бизнес нэгж / ААН-ийн хувьд Улсын Бүртгэлийн Газарт албан ёсоор бүртгүүлснийг хэлнэ. Албан бус ААН-ийг ийнхүү тодорхойлсны дагуу ажиллагчдынх нь тооноос үл хамааруулан судалгаандхамруулсан.

12 Татварын албанд улирал тутам гаргаж өгдөг ААН-ийн орлогын албан татвар (ААНОАТ)-ын тайлангаа дараалсан 18 сарын дотор ирүүлээгүй бол ҮСХ нь тухайн компанийг идэвхигүй гэж бүртгэдэг.

График 2.3 Улаанбаатар хотод бүртгэгдсэн идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн тоо, ажиллагчдын тооны бүлгээр



Эх сурвалж: ҮСХ, Монгол Улсын статистикийн эмхтгэл, 2013, хуудас 382

Монгол Улсад бүртгэгдсэн 99603 ААН-ийн 90 орчим хувь нь 1-9 ажилтантай бичил, жижиг бизнес эрхлэгчид байдаг. Энэ нь жижиг бизнес эрхлэгчид нилээдгүй ажлын байрыг бий болгож, олон айл өрхийн орлогын эх үүсвэр болдгийн нотолгоо юм. Тиймээс жижиг, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих нь ядуурал, ажилгүйдэл зэрэг нийгмийн хөгжлөөс чангаасан асуудлуудтай тэмцэх гол хэрэгсэл юм.


2.4. Санхүү

Монгол Улсад 2013 оны байдлаар арилжааны банк 13, банк бус санхүүгийн байгууллага 2263, хадгаламж, зээлийн хоршоо 141, даатгалын компани 17, хөрөнгийн бирж 1 тус тус үйл ажиллагаа явуулж байв. Монгол Улсын санхүүгийн системийн 97 хувийг банкны салбар дангаар бүрдүүлж буй. Тус салбарын нийт активын хэмжээ 16,4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеээс 64,2 хувиар буюу 6,4 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөн банкны салбарын нийт эх үүсвэр 14,9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 6,2 их наяд төгрөгөөр буюу 70 хувиар өссөн нь ДНБ-ний 80 гаруй хувьтай тэнцэж байгаа юм¹³.

Монгол Улсын хэмжээнд 2013 онд 10769,3 тэрбум төгрөгийн зээл олгосны 78,6 хувийг Улаанбаатар хотод, 21,4 хувийг хөдөө нутагт олгосон. Нийт зээлийн хэмжээ өмнөх оноос 3778,8 тэрбум төгрөгөөр буюу 54,1 хувиар өссөн. Харин өнгөрсөн оныхтой харьцуулахад чанаргүй зээлийн хэмжээ бараг 2 дахин өсөж, 565,9 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 5,3 хувь болжээ. Улаанбаатар хотод 556,5 тэрбум төгрөгийн, хөдөө нутагт 9,4 тэрбум төгрөгийн чанаргүй зээл байна (график 2.4).

13 Дараах вэб-сайтаас үзнэ үү: <http://economy.news.mn/content/161000.shtml>.

График 2. 4 Улаанбаатар хот, хөдөө нутаг дахь чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл, сая төгрөг



Эх сурвалж: ҮСХ, Монгол Улсын статистикийн эмхтгэл, 2013, хуудас 244

Арилжааны банкуудаас 52900 жижиг дунд үйлдвэр эрхлэгч болон ААН-д 2013 онд 1,05 их наяд төгрөгийн зээл олгосон нь 2009 оныхоос 570,1 тэрбум төгрөгөөр буюу 118,3 хувиар нэмэгдсэн байна (график 2.5).


График 2. 5 Арилжааны банкнуудаас жижиг, дунд ААН-үүдэд олгосон зээл, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монгол Банк

Ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-гаас 2012 онд 19 тэрбум төгрөгийн жижиг зээл олгосон нь 2011 онтой харьцуулахад 12 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм (график 2.6).


График 2. 6 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон зээл, тэрбум төгрөг



Эх сурвалж: ХЭДС

ХЭДС-гаас зарцуулсан хөрөнгийг 2012 онд 4701 хувиараа хөдөлмөр эрхлэгч, 2584 малчин, 198 нөхөрлөл хоршоо байгуулах иргэн, 53 албан бус хөдөлмөр эрхлэгч, 71 ажилгүй иргэн, 23 ААН-д банк болон банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан олгосон байна (график 2.7).


График 2. 7 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон зээлийн хуваарилалт, зээлдэгчдийн төрөл, тоогоор



Эх сурвалж: ХЭДС

ААН-ийн орлогын татвар төлөлтийг байршлаар нь ялгаж үзвэл 2012 онд Улаанбаатар хотод бүртгэлтэй ААН-үүд 1863 тэрбум төгрөг, хөдөө нутагт бүртгэлтэй ААН-үүд 356 тэрбум төгрөгийн татвар төлжээ. Улаанбаатар хотод бүртгэлтэй ААН-үүдийн 2012 онд төлсөн татварыг 2009 онд төлсөн татвартай нь харьцуулбал 137 хувиар өссөн байна (график 2.8).

График 2. 8 Улаанбаатар хот, хөдөө нутгийн ААН-үүдийн төлсөн нийт албан татвар, тэрбум төгрөг




Эх сурвалж: Татварын Ерөнхий Газар (ТЕГ)

2012 онд Улаанбаатар хотод бүртгэлтэй ААН-үүд 1863 тэрбум төгрөгийн татвар төлснөөс 252 тэрбум төгрөг буюу 13,6 хувийг нь 1,5 тэрбум хүртэлх борлуулалтын орлоготой ААН-үүд, 1610 тэрбум төгрөг буюу 86,4 хувийг нь 1,5 тэрбумаас дээш борлуулалтын орлоготой ААН-үүд тус тус төлжээ¹⁴. Монгол Улсын ААН-үүдээс авч буй татварын 15 хувийг нь албан татвар ногдуулах жилийн орлого нь 1,5 тэрбум төгрөгнөөс доош ААН-үүдийн татвар бүрдүүлж байна (график 2.9).

14 Монгол Улс ААН-ийн орлогын албан татварын хоёр шатлалт тогтолцоотой. Хэрвээ компани албан татвар ногдуулах жилийн орлого нь 3 хүртэл тэрбум төгрөг бол 10 хувийн, үүнээс их бол 25 хувийн татварыг тус тус төлнө. Энэхүү судалгаанд өмнө нь дагаж мөрдөж байсан босго болох 1,5 тэрбум төгрөгт тулгуурлан тооцоолсон.

График 2.9 Улаанбаатар хот дахь ААН-үүдийн орлогын албан татвар төлөлт, компанийн хэмжээгээр



Эх сурвалж: Татварын Ерөнхий Газар (ТЕГ)

Дээрх графикаас харахад албан татвар ногдуулах жилийн орлого нь 1,5 тэрбумаас дээш ААН-үүд татварын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг байна.

2.5. Албан бус хэвшил дэх хөдөлмөр эрхлэлт

Албан бус хэвшил дэх хөдөлмөр эрхлэлт нь олон өрхийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлдэг. Монгол Улсын Засгийн Газраас албан бус хөдөлмөр эрхлэлтийг “албан ёсны бүртгэл, нийгмийн хамгаалалд бүрэн хамрагдаагүй, хөдөө аж ахуйн бус, аж ахуй эрхлэх зохион байгуулалтын хэлбэрт ороогүй, бөгөөд хуулиар хориглоогүй ажил, үйлчилгээ эрхэлж буй иргэдийг хамруулна”¹⁵ гэж тодорхойлжээ.

Хөгжиж буй орнуудын хувьд хөдөө аж ахуйн салбар их цар хүрээтэй, мөн хөдөө аж ахуй дахь өөрийн хэрэгцээнд зориулсан бүтээгдэхүүнийг зах зээлд зориулсан бүтээгдэхүүнээс нь ялгаж салгахад бэрхшээлтэй байдгийг харгалзан үзээд ОУХБ нь хөдөө аж ахуйг албан бус хэвшилд хамруулахгүй байхаар тогтжээ¹⁶. 370 мянган ажилтан буюу нийт ажиллагчдын 35 хувь нь ажилладаг хөдөө аж ахуйн салбар Монгол Улсын албан бус эдийн засгийн судалгаанд маш чухал юм.

График 2.10 Нийт ажиллагчдын тоо, ХАА-н бус салбарт болон албан бус салбарт ажиллагчдын тоо, хүн



Эх сурвалж: ҮСХ, Ажиллах Хүчний Судалгаа

15 УИХ-ын 2006 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 1 дүгээр тогтоолын хавсралт, “Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ын 1.3 дахь заалт.

16 Хөдөө аж ахуйн үйл ажиллагааг албан бус хэвшлийн статистикийнхаа хамрах хүрээнд оруулаагүй улс орнуудад хөдөө аж ахуйн салбар дахь албан бус ажлын байрны тодорхойлолтыг зохих ёсоор боловсруулж гаргахыг зөвлөдөг. Жишээлбэл, “ОУХБ: Албан бус хэвшил, албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаарх статистикийн гарын авлага, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, Женев, 2013”-ыг үзнэ үү.

Албан бус хэвшилд ажиллагсдыг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь үндсэн үйл ажиллагаагаараа болон давхар үйл ажиллагаагаараа албан бус хөдөлмөр эрхлэгч гэж бүлэглэвэл 2013 оны байдлаар 199,9 мянган хүн албан бус хөдөлмөр эрхэлж байгаагийн 97 хувь нь үндсэн үйл ажиллагаагаараа албан бус хөдөлмөр эрхэлж байна.¹⁷ Албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулах зорилгоор 2006 онд “Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ыг 2006-2015 оны хооронд 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр баталсан. Уг хөтөлбөрийн үр дүн, хэрэгжилт нь тодорхойгүй байгаа, гэтэл албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо нэмэгдсээр байгаа бөгөөд тэр дундаа албан бус хөдөлмөр эрхлэгч залуучуудын тоо эрс өсч байна (хавсралт А, хүснэгт 3-ыг үзнэ үү).

2012-2013 онд нийт ажиллагчдын тоо 4,4 хувиар өссөн байхад албан бус хэвшилд ажиллагчдын тоо 14,6 хувиар өссөн.

Үндсэн ажлаараа албан бус салбарт ажиллагч 15-34 насны залуучуудын тоо 2009 онд 49,5 мянга байсан бол 2013 онд 60,7 мянга болж 22,6 хувиар нэмэгдсэн бол давхар үйл ажиллагаагаараа албан бус хөдөлмөр эрхлэгч залуучуудын тоо 2009 онд 3373 байсан нь 2013 онд 1451 болж буурчээ¹⁸.

Монгол Улсын нийт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 42,2 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбарт ажиллагчид эзэлдэг. Энэ салбарт ажиллагсдын тоо жилээс жилд өссөөр байна (хавсралт А, хүснэгт 3-ыг үзнэ үү).

17 ҮСХ, Ажиллах хүчний судалгаа, 2013 он

Энэхүү судалгаанд ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтүүдийг дор дурьдсан тодорхойлолт ашиглан тооцоолов:

“Албан бус хөдөлмөр эрхлэгч”-д албан ёсны бүртгэл, нийгмийн хамгаалалд бүрэн хамрагдаагүй, аж ахуй эрхлэх зохион байгуулалтын хэлбэртороогүй, хөдөө аж ахуйн бус бөгөөд хуулиар хориглоогүй ажил, үйлчилгээ эрхэлж буй иргэдийг хамруулна.

“Нийгмийн хамгаалалд бүрэн хамрагдаагүй” гэдэгт “Нийгмийн даатгалын тухай” Монгол Улсын хуулийн холбогдох заалтын дагуу тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэнд, ажилгүйдэл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалд хамрагдаагүй хүн ам багтана.

“Албан ёсны хөдөлмөр эрхлэлтийн бүртгэлд бүрэн хамрагдаагүй иргэн” гэж хөдөлмөр эрхлэлтийн статистик болон захиргааны бүртгэл, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн орлогын албан татварын талаарх мэдээлэлд хамрагдаагүй иргэнийг хэлнэ.

“Аж ахуй эрхлэх зохион байгуулалтын хэлбэрт ороогүй” гэж холбогдох хуулийн дагуу хоршоо, нөхөрлөл, компанийн хэлбэрээр аж ахуй эрхэлдэггүй, өрхийн нэг гишүүн эсвэл түүнээс дээш тооны өрхийн гишүүний эзэмшилд байдаг, тухайн өрх дангаараа эсвэл бусад өрхтэй хамтран эзэмшдэг үйлдвэрлэлийнхээ зарим хэсгийг зах зээлд борлуулдаг (бараа солилцоо хийдэг), аж ахуйн зохион байгуулалтад ороогүй өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний нэгжийг хэлнэ.

“Хөдөө аж ахуйн бус ажил, үйлчилгээ”-нд газар тариалан, ойн аж ахуй, мал аж ахуй, шавьж үржүүлгийн ажил, хөдөө аж ахуйн бүтээгдхүүний анхан шатны боловсруулалт, хадгалалт, үйлдвэрлэлт, тээвэрлэлт, хөдөө аж ахуйн машин, техникийн ашиглалт, засвар үйлчилгээнээс бусад ажил үйлчилгээг хамруулна.

Дараах вэб-сайтаас үзнэ үү <http://web.nso.mn/AAZMS/web/detail/29>

18 ҮСХ, Ажиллах хүчний судалгаа, 2013. Дараах вэб-сайтаас үзнэ үү: www.nso.mn.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ: “АЛБАН ЁСНЫ
АЖ АХУЙ ЭРХЛЭЛТ БОЛОН ӨРСӨЛДӨХ
ЧАДВАРЫН СУДАЛГАА”-НЫ ҮР ДҮН**

ГУРАВДУГААР БҮЛЭГ: “АЛБАН ЁСНЫ АЖ АХУЙ ЭРХЛЭЛТ БОЛОН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГАА”-НЫ ҮР ДҮН

3.1. Бизнесийн бүртгэл буюу албан ёсны аж ахуй эрхлэлт

Монгол Улсын олон салбарт аж ахуйн үйл ажиллагаа явуулахад тусгай зөвшөөрөл шаарддаггүй. Бүртгэлийн үйл явцын дагуу Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт хандаж бүртгүүлнэ. Бүртгэлийн хураамж нь 22 мянган төгрөг.


Тусгай зөвшөөрөл шаардлагатай үйлдвэрлэл салбаруудад ийм зөвшөөрлийн тоо, төрөл харилцан адилгүй. Жишээлбэл, барилга угсралтын үйл ажиллагаа явуулахад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу 80 гаруй тусгай зөвшөөрөл шаарддаг байв.

Монгол Улсын бүх ААН тухайн улирлын дараах сарын 20-ны дотор санхүүгийн улирлын тайланг цахимаар гаргаж ирүүлсэн байх шаардлагатай байдаг. Цаасан дээрх хувилбарыг ч компанийн захирал, ерөнхий нягтлан бодогч аль аль нь гарын үсэг зурж баталгаажуулах ёстой. Тайланг хугацаанд нь гаргаж өгөөгүй бол 960 мянган төгрөгийн торгууль ногдуулна.

ААН-үүд нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл, ААН-ийн орлогын албан татвар, бусад татварыг сар бүр төлнө. Эдгээр татвар, шимтгэлийн төлбөрийг дараа сарын 26-ны дотор хийсэн байна. Цахимаар болон цаасаар гаргаж өгөх (Компанийн захирал, ерөнхий нягтлан бодогч аль аль нь гарын үсэг зурсан) санхүүгийн тайланг дараа сарын 5-ны дотор багтаан ирүүлэх үүрэгтэй.

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 68 нь бүртгэлтэй, 26 нь бүртгэлгүй байсан бөгөөд 6 ААН бүртгэлийн хэлбэрээ дурьдаагүй байсан. Бүртгэлийн гэрчилгээ авсан ААН-үүдийн 72 хувь нь бүртгэлийн албанд шууд хандсан, 9 хувь нь зуучлагчаар дамжуулан, 3 хувь нь нээлттэй хаалганы өдрөөр бүртгэлийн гэрчилгээгээ авсан гэж хариулсан бол 16 хувь нь бүртгэлийн гэрчилгээ хэрхэн авсныг мэдэхгүй гэж хариулсан. ААН-ийн бүртгэлийн гэрчилгээг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар 2008-2012 оны хооронд ажлын таван өдөрт багтаан олгодог байсан бол 2013 оноос эхлэн ажлын гурван өдөрт багтаан олгох шийдвэр гаргасан байна.

График 3. 1 Бүртгэлийн гэрчилгээ авахын тулд хэдэн өдөр зарцуулдаг вэ гэсэн асуултад хариулсан байдал, судалгаанд хамрагдсан хүмүүст эзлэх хувиар



Эх сурвалж: Санал асуулгад оролцогчдын хариултаас

Дээрх графикаас харахад ААН-үүдийн 26 хувь нь, БОТ-дын 18 хувь нь, БДҮҮ-дийн 20 хувь нь л бүртгэлийн гэрчилгээгээ ажлын 3 өдөрт багтаан авдаг болсон гэжээ. Мөн ААН-үүд бүртгэлийн гэрчилгээ авахад дунджаар 6,5 өдөр зарцуулдаг гэж хариулжээ.

Хэдий ийм боловч бүртгэлийн албаны үйл ажиллагааг ААН-үүдийн 60 орчим хувь нь “Сайн” буюу “Онц сайн” гэж дүгнэсэн байв. Санал асуулгаар бүртгэлийн албаны үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай байгааг илэрхийлэх индексийг 1-4 гэсэн шатлалаар тооцоход ААН-үүдийн сэтгэл ханамжийн индекс 2,65, БДҮҮ-дийнх 1,3, БОТ-дынх 1,65 гарсан. Эндээс дүгнэхэд бүртгэл хэдийгээр албан ёсны хугацаанаасаа урт үргэлжилж байгаа ч гэсэн бүртгэлийн албаны үйл ажиллагааг ААН-үүд боломжийн гэж үздэг байна.

Хүснэгт 3. 1 Бизнесийн бүртгэлийн явцад тулгарч байсан асуудал*

№	Тулгарч байсан асуудал	ААН-үүд			БДҮҮ-ид			БОТ-ид			Нийт дүн		
		I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III
1	Бүртгэлийн журмын талаар мэдээлэл дутмаг	27	9	-	5	5	-	18	4	1	50	18	1
2	Дүрэм журам болон тавих шаардлагууд нь ойлгомжгүй	1	13	18	5	5	-	6	8	1	12	26	19
3	Банкин данс нээлгэх нь түвэгтэй	1	1	29	2	9	-	3	-	-	6	10	29
4	Өөрийн хөрөнгийн доод хэмжээ хэтэрхий өндөр	1	6	23	-	-	-	3	0	1	4	6	24
5	Бүртгэлийн хураамж өндөр	1	3	26	-	-	-	-	-	-	1	3	26
6	Албан бус урамшуулал /гар цайлгах/ өндөр	1	7	24	-	-	-	3	0	1	4	7	25
7	Бүртгэлийн албанд таньдаг хүн байхгүй	9	21	2	1	9	-	0	2	1	10	32	3
8	Гэрчилгээ бэлэн болгох хугацаа тодорхойгүй	9	21	3	3	7	-	3	4	1	15	32	4
9	Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа, уялдаа муу	18	13	1	8	2	-	6	4	4	32	19	5
10	Цаг хугацаа их шаарддаг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	Мэдэхгүй	-	-	-	-	-	-	6	2	-	6	2	10
	Дүн	68	94	126	24	37	-	48	24	10	140	155	146

* Санал асуулгад оролцсон хүмүүс гурван хариулт сонгосноос: 1-хамгийн эхний, 2-хоёр дахь, 3-гурав дахь эрэмбийн.

Хүснэгт 3.1-д бизнесийн бүртгэлийн явцад тулгардаг гол бэрхшээлийг санал асуулгад оролцогчид хэрхэн тодорхойлсныг харуулав.

ААН-үүдийн хувьд дараах бэрхшээлийг онцолсон байна:

- Бүртгэлийн дүрэм журмын талаархи мэдээлэл дутмаг байдал (Хамгийн эхэнд тулгардаг бэрхшээл);
- Бүртгэлийн албанд таньдаг хүн байхгүй (Хоёр дахь эрэмбийн бэрхшээл);
- Гэрчилгээ бэлэн болгох хугацаа нь тодорхойгүй (Хоёр дахь эрэмбийн бэрхшээл);
- Банкинд данс нээлгэх (Гурав дахь эрэмбийн бэрхшээл).

БОТ-чид харин дараах бэрхшээлүүд тулгардаг гэсэн:

- Төрийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоо сул (Хамгийн эхэнд тулгардаг бэрхшээл);
- Банкинд данс нээлгэх (Хоёр дахь эрэмбийн бэрхшээл);
- Бүртгэлийн албанд таньдаг хүн байхгүй (Хоёр дахь эрэмбийн бэрхшээл).

БДҮҮ-чид дараах бэрхшээл тулгардаг гэсэн:

- Бүртгэлийн дүрэм журмын талаархи мэдээлэл дутмаг байдал (Хамгийн эхэнд тулгардаг бэрхшээл);
- Бүртгэлийн дүрэм журам болон тавигдах шаардлагууд нь ойлгомжгүй (Хоёр дахь эрэмбийн бэрхшээл).

Судалгаанд хамрагдсан гурван бүлэг тодорхой асуудлаар ялгаатай хандлага, дүгнэлттэй байгаа хэдий ч тэд бүгд бүртгэлийн дүрэм журмыг дурьдсан байлаа. Цаашилбал БОТ-ид аж ахуй эрхлэлтийн асуудлаар хангалтгүй мэдлэгтэй гэдэгт ААН болон БДҮҮ-чидтэй санал нэг байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 3.2 ААН бүртгүүлсний дараа гарсан үр дагавар, хариултын тоогоор

№	Үзүүлж буй нөлөө	ААН		БДҮҮ-ид		Нийт дүн	
		тийм	үгүй	тийм	үгүй	тийм	үгүй
1	Бизнесийн үйл ажиллагаа найдвартай болсон мэт санагддаг	42	22	5	5	47	27
2	Төрийн албаныханд төлдөг албан бус урамшуулал буурсан	12	51	-	10	12	61
3	Төрийн албаныхан шалгалт болон бусад шалтгаанаар ирэх нь ихэссэн /мэргэжлийн хяналт, шалгалт/	17	46	1	9	18	55
4	Илүү өндөр татвар төлөх шаардлагатай болсон	30	33	3	7	33	40
5	Хандивын хүсэлт илүү олон ирэх болсон	12	52	2	8	14	60
6	Ажиллагчдын нийгмийн даатгал төлөх үүрэг хүлээсэн	27	36	5	5	32	41
7	Хүмүүсийн итгэл хүлээсэн	1	-	-	-	1	0
Хариултын нийт тоо		88	240	16	44	104	284

ААН-үүдийн туршлагаас үзэхэд албан ёсны бүртгэлтэй болсноор “Бизнесийн үйл ажиллагаа найдвартай болсон мэт санагддаг” гэж дийлэнх нь хариулсан. Гэхдээ ихээхэн нийтлэг байсан дараах хоёр хариулт (“Илүү өндөр татвар төлөх шаардлагатай болсон”, “Ажиллагчдын нийгмийн даатгал төлөх үүрэг хүлээсэн”) нь аж ахуй эрхлэлтийг албан ёсны болгоход сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг илэрхийлж байна. Магадгүй эдгээр хүчин зүйл нь албан бусаар үйл ажиллагаа явуулдаг маш олон бизнес эрхлэгчид албан ёсны болгох үйл явцад яагаад эргэлздэг болохыг зарим талаар тайлбарлаж байгаа хэрэг юм.

Албан ёсны болсноор татвар, нийгмийн даатгалын төлбөр төлөх болно хэмээх сөрөг үр нөлөөний талаар арай олон ААН хариу ирүүлээд байгаа ч судалгааны үр дүн нь тийм ч тодорхой биш байна. Өөр өөр ААН-үүд бизнесийн орчин дахь хийдлийн үр дагавар, болзошгүй нөлөөллийн талаар янз бүрийн бодолтой байх нь тодорхой.

Хамгийн сонирхолтой нь санал асуулгад оролцогчдын бараг гуравны хоёр нь албан хэвшилд шилжсэнээр төрийн байгууллагын албан тушаалтнуудад төлөх шаардлагатай болдог албан бус урамшуулал буурахгүй гэсэн байна.

Хэдийгээр хүснэгт 3.2-т нэгтгэгдээгүй ч гэсэн БОТ-дын хувьд хамгийн их давтагдсан хариулт нь ААН-үүдийнхтэй төстэй буюу “Ажиллагчдын нийгмийн даатгалын төлбөр төлөх шаардлагатай болсон”, “Илүү өндөр татвар төлөх шаардлагатай болсон”, “Бизнесийн үйл ажиллагаа илүү найдвартай болсон” зэрэг хариултауд байлаа.

Үүний дараа бүртгэлгүй байсан үетэй харьцуулахад ААН-ээ бүртгүүлснээр ямар боломж, бололцоо бүрддэгийг тодруулах зорилготой асуулт тавьсан. ААН-ээ

бүртгүүлснээр бүрдэж болох 9 төрлийн нийтлэг боломж, бололцоог санал асуулгад оролцогчдод танилцуулж, тэдний хувийн туршлага нь ижил төстэй байсан эсэхийг асуусан юм.

Хүснэгт 3. 3 ААН бүртгүүлснээр илүү боломж бүрдсэн, нөөцөөс хүртэх бололцоотой болсон эсэх, хариултын тоогоор

№	Бүрдэж болох нийтлэг боломж, бололцоо	ААН		БДҮҮ-ид		БОТ-ид		Нийт дүн	
		тийм	үгүй	тийм	үгүй	тийм	үгүй	тийм	үгүй
1	Төрөөс дэмжиж байгаа хөтөлбөрт хамрагдах	27	39	4	8	6	11	37	58
2	Банкнаас зээл авах	49	18	5	5	13	4	67	27
3	ААН-ээ даатгалд хамруулах	20	46	-	10	8	9	28	65
4	Мэргэшсэн чадварлаг ажилтан ажилд авах	20	46	-	10	1	16	21	72
5	Өөрийн хэрэгцээнд тохирсон газар ашиглах боломж	12	54	4	6	1	16	17	76
6	Зах зээл, хэрэглэгчдэд нэвтрэх	37	30	3	7	4	13	44	50
7	Бараа, бүтээгдэхүүн экспортлох, импортлох боломж	16	51	2	8	3	14	21	73
8	Үзэсгэлэн худалдаанд оролцож өрсөлдөх	-	-	-	-	2	15	2	15
9	Бодлогын хэлэлцүүлэгт өөрийн ашиг сонирхлыг илэрхийлэх	11	55	1	9	3	14	15	78
	Нийт хариултын тоо	192	339	19	63	41	112	252	514

Санал асуулгад оролцсон гурван бүлгийнхэн бизнесээ бүртгүүлсний дараа бий болох боломж, бололцоо гэдэгт “Банкнаас зээл авах” тодорхой хэмжээгээр “Зах зээл, хэрэглэгчдэд нэвтрэх боломж нэмэгддэг” гэснийг илүүтэй нэрлэжээ. Бүрдэж болох нийтлэг бусад боломж, бололцоог санал асуулгад оролцсон гурван бүлгийнхэн бараг бүхэлдээ санал нэгтгэйгээр ихэнхидээ сөрөг байдлаар үнэлсэн байна.

БОТ-ид Улаанбаатарт тусгай зөвшөөрөл авахад харьцангуй хялбар (цаг хугацаа болон төлбөрийн хувьд) байдаг уу гэсэн асуултад 63 хувь нь “Дүгнэхэд хэцүү” гэжээ. Харин “Тийм”, “Үгүй” гэж хариулагсад тус бүр 18 хувь байв. Харин тусгай зөвшөөрөл авахад харьцангуй хялбар болж байгаа юу, эсвэл хэцүү болж байгаа юу гэсэн асуултад 59 хувь нь “Мэдэхгүй” гэсэн бол 35 хувь нь “Хэцүү”, 6 хувь нь “Хялбар болж байгаа” гэж үзсэн байна.


Харьцангуй хэцүү болж байгаа гэж үзсэн оролцогчид “Бүрдүүлэх бичиг баримт их түвэгтэй”, “Цаг хугацаа их зарцуулдаг”, “Олон шат дамжлагатай, хүнд суртал ихтэй” зэргийг дурьджээ. Харьцангуй хялбар болж байгаа гэж хариулсан

хүмүүс зарим үйл ажиллагаа “Цахим хэлбэрт шилжсэн” зэргээр тайлбарлажээ.

ААН-үүд тусгай зөвшөөрөл авахад ямар нэгэн хүндрэлтэй тулгардаг гэж БОТ-дын 65 хувь нь, ААН-үүдийн 78 хувь нь үзсэн бол “Ямар ч асуудал тулгардаггүй” гэж БОТ-дын 6 хувь нь, ААН-үүдийн 22 хувь нь хариулжээ.

“Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргах явцад ААН-үүдэд ямар хүндрэлтэй асуудлууд тулгардаг вэ?”¹⁹ гэсэн асуултад ААН-үүдийн 19 нь “Бүртгэлийн хураамж өндөр”, “Тусгай зөвшөөрөл авах талаар мэдээлэл хангалтгүй” гэж 17 нь хариулсан бол “Төрийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа хангалтгүй” гэж 14 хүн хариулсан. Харин БОТ-дын 8 нь “Тусгай зөвшөөрөл авах талаар мэдээлэл хангалтгүй”, 6 нь “Дүрэм журам болон тавих шаардлагууд ойлгомжгүй”, 4 хүн “Албан бус урамшуулал өндөр” гэж хариулсан байна.

График 3. 2 Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргах үед тулгардаг нийтлэг асуудлууд, хариултын тоогоор



Ер нь ААН-ийг албан болгож бүртгэлжүүлэхэд учирдаг гол бэрхшээлүүдэд төрийн үйлчилгээний хүртээмж, чанар хангалтгүй, хууль, зохицуулалтын талаарх мэдлэг, ойлголт хомс байгааг онцлон дурьдаж байв.

3.2. Бизнесийн орчин

Дэлхийн Банкнаас гаргадаг “Бизнес эрхлэхүй 2015” судалгаанаас үзэхэд Монгол Улс 189 орноос 72 дугаар байрт жагсаж байгаа нь 2014 оныхоосоо 4 байраар, Дэлхийн Банкны 2008 оны судалгаагаар 52 дугаарт эрэмбэлэгдэж байснаасаа 20 байраар тус тус ухарчээ. Энэ нь Монгол Улсын бизнесийн орчин дордож, тогтворгүй байгааг харуулж байна²⁰.

19 Монгол Улсад аж ахуйн зарим үйл ажиллагааг тусгай хуулиар зохицуулдаг бөгөөд эдгээр үйл ажиллагаанд хяналт тавих буюу удирдах эрх бүхий төрийн холбогдох байгууллагаас тусгай зөвшөөрөл, лиценз олгодог. Жишээлбэл, барилга, банк, санхүү, байгаль орчин, боловсрол, түлш, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээ эдгээрт хамрагдана. Ийм тохиолдолд бизнесээ эхлээд бүртгүүлэх бөгөөд дараа нь холбогдох эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсны дараа бүртгэлийн мэдээллийг шинэчилнэ. Дараах вэб-сайтаас үзнэ үү: <http://www.doingbusiness.org/data/exploreeconomies/mongolia/starting-a-business> болон http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=183518.


20 Дараах вэб-сайтаас үзнэ үү: <http://www.doingbusiness.org/data/exploreeconomies/mongolia/>

Санал асуулгад оролцсон гурван бүлгийнхэн Улаанбаатар хотын бизнесийн орчныг 2 жилийн өмнөхтэй харьцуулахад 43,6 хувь нь “Сайжирсан”, 23 хувь нь “Өөрчлөгдөөгүй”, 24 хувь нь “Муудсан”, 9,4 хувь нь “Мэдэхгүй” гэж хариулсан байна.

Харин санал асуулгад оролцсон бүлэг тус бүрээр хандлагыг судалж үзвэл БОТ-дын 58,8 хувь, ААН-үүдийн 41,1 хувь, БДҮҮ-дийн 40 хувь нь “Бизнесийн орчин сайжирсан” гэж тус тус хариулжээ. ААН-ийн 24,4 хувь, БОТ-дын 12 хувь нь “Бизнесийн орчныг муудсан” гэж үзсэн.

Үүний дараагаар санал асуулгад оролцсон ААН-үүдээс Улаанбаатар хотод бизнесийн үйл ажиллагаа явуулахад тулгардаг гол бэрхшээлүүдийг тодруулав.

График 3.3 Улаанбаатар хотын ААН-үүдийн үйл ажиллагаанд тулгардаг голлох хүндрэл, судалгаанд хамрагдсан хүмүүсийн давхардсан тоогоор өгсөн хариултад эзлэх хувиар



Санал асуулгад оролцсон хүмүүсээс хамгийн олонтаа дурьдсан бизнесийн үйл ажиллагаа явуулахад тулгарч буй хүндрэл, бэрхшээл:

- Санхүүжилтийн олдоц (Санал асуулгад оролцсон хүмүүсийн 44 хувь);
- Татвар (40,7 хувь);
- Бизнесийн өрсөлдөөн (37,4 хувь);
- Ур чадвартай ажиллах хүчний олдоц (37,4 хувь);
- Авлига (31,9 хувь);
- Газар (30,8 хувь).

Харин харилцаа холбоо, эрчим хүч, тээвэр гэх мэт дэд бүтцийн асуудлуудын үзүүлэх сөрөг нөлөө төсөөлж байснаас бага байна.

болон <http://www.doingbusiness.org/~media/GIAWB/Doing%20Business/Documents/Annual-Reports/English/DB08-FullReport.pdf>

Барьцаа хөрөнгийн асуудлыг эс тооцвол бизнесийн үйл ажиллагаа явуулахад дампуурлын тухай хууль тогтоомж, зохицуулалтын үзүүлэх үр нөлөө тун бага байдаг буюу уг хууль тогтоомжийг зохих ёсоор төдийлөн хэрэглээгүй, ерөнхийдөө таньж мэдээгүй хэвээр байна. Судалгаанд хамрагдсан гурван бүлгийн оролцогчдын 70-80 хувь нь дараах асуултуудад “Мэдэхгүй” гэж хариулсан:

- Таны үзэж байгаагаар дампуурлын тухай хууль нь жижиг бизнес эрхлэгчдэд үйлчилж чаддаг уу?
- Дампуурлын тухай хууль бодит байдал дээр үр дүнтэй байдаг уу?
- Таны үзэж байгаагаар дампуурлын тухай хууль бүхэлдээ төвөгтэй, хүнд сурталтай байдаг уу?

“Харилцаа холбооны хэрэгсэл, тээвэр, үйлчилгээ болон эзэмшлийн газар олж авахад шинэ, хөгжиж байгаа ЖДҮ-үүдэд үнэ нь ялгавартай байдаг уу?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 11 хувь нь “Тийм”, 30 хувь нь “Үгүй, зарим нь”, 59 хувь нь “Мэдэхгүй” гэж хариулжээ.

Судалгаанд хамрагдсан гурван бүлгийн оролцогчдын 49 хувь нь татвар, хураамжийн тухай хуулиуд, 41 хувь нь тодорхой дэд салбарын тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомж, 25 хувь нь хөдөлмөрийн тухай хуулиудыг ААН-ийн өргөжилт болон үйл ажиллагаанд саад учруулдаг гэж нэрлэсэн байна.


Хүснэгт 3.4 ААН-ийн үйл ажиллагаа, өргөжилтөд саад учруулдаг хууль тогтоомж, зохицуулалт, нийт санал өгсөн хүмүүсийн тоонд эзлэх хувиар

№	Хууль эрх зүй	ААН	БОТ-ид	БДҮҮ-ид
1	Бизнесийн бүртгэл	25,9	11,8	20
2	Тодорхой дэд салбарын тусгай зөвшөөрөл	35	47,1	40
3	Хөдөлмөрийн тухай хуулиуд	27,5	5,9	40
4	Татвар, хураамжийн тухай хуулиуд	55	41,2	50
5	Дотоод худалдааны зохицуулалт	16,2	5,9	-
6	Гадаад худалдааны (экспорт, импорт) зохицуулалт	27,5	23,5	10
7	Хүрээлэн буй орчныг хамгаалах тухай хуулиуд	8,8	11,8	-
8	Хөрөнгө оруулалтын тухай хууль	13,8	47,1	10
9	Шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах тухай хууль	8,8	5,9	10
10	Тендер шалгаруулах журам	1	-	-

ААН-үүдийн хувьд 55 хувь нь татвар, хураамжийн тухай хуулиуд, 35 хувь нь тодорхой дэд салбарын тусгай зөвшөөрлийн журмууд бизнесийн өргөжилтөд саад учруулдаг гэж эрэмбэлсэн. Харин БОТ-дын 41 хувь нь тодорхой дэд салбарын тусгай зөвшөөрлийн журмууд, 41 хувь нь хөрөнгө оруулалтын тухай хуулиуд ихээхэн саад бэрхшээл болдог гэжээ.

“Таны бодлоор ААН-үүд төрийн албан хаагчдаас ямар нэгэн үйлчилгээ авахын тулд албан бус урамшуулал төлөх нь энгийн үзэгдэл үү?” гэсэн асуултад ААН-ийн 45 хувь нь “Энгийн үзэгдэл” гэж хариулсан. Харин ингэж бодож байгаа хүмүүс БОТ-дын дунд цөөн байсан бөгөөд тэдний 18 хувь нь “Энгийн үзэгдэл” гэж үздэг байна. Энгийн үзэгдэл гэж үзэж байгаа БОТ-ид болон ААН-үүд “Тусгай зөвшөөрөл авахын тулд”, “Төрийн байгууллагатай гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэх /тендерт ялах г.м/-ийн тулд” албан бус урамшуулал өгдөг гэсэн 2 хариултыг илүүтэй сонгосон байна. ААН-үүд төрийн хяналт шалгалт эсхүл орон нутаг дахь зохицуулалттай холбогдуулан асуудлаа төвөг багатай шийдэхийн тулд албан бус урамшуулал төлөх нь энгийн үзэгдэл гэж мөн үзжээ.

График 3.4 Таны бодлоор ямар нөхцөлд албан бус урамшуулал (гар цайлгах мөнгө) төлөх хэрэгтэй болдог вэ?*



*Хамгийн олон давтагдсан хариулт, эзлэх хувиар

“Албан бус урамшуулал төлдөг” гэж хариулсан ААН-ийн төлөөллөөс “Жилд 1 удаа төлдөг” гэж 9 оролцогч, “Жилд 2 удаа төлдөг” гэж 11 оролцогч, “Жилд 3-4 удаа төлдөг” гэж 11 оролцогч, “Жилд 5 ба түүнээс олон удаа төлдөг” гэж 7 оролцогч тус тус хариулжээ.

“Хэдий хэмжээний албан бус урамшуулал төлдөг вэ?” гэсэн асуултад ийм урамшуулал төлдөг гэж хариулсан ААН-үүдийн 66 хувь нь “Мэдэхгүй” гэсэн бол 17 хувь нь “Сарын борлуулалтын орлогын 1-5 хувийн хооронд”, 9,8 хувь нь “Сарын борлуулалтын орлогын 1 хувь”, 7,3 хувь нь “Сарын борлуулалтын орлогын 5,1-10 хүртэлх хувийг” өгдөг гэжээ.

Судалгаанд хамрагдсан БОТ-дын 2 нь Засгийн газрын дэмжлэгт хөтөлбөр болон татаастай холбоотой мөнгө олгодог байгууллагад ажиллагч байв. Мөн судалгаанд оролцсон БДҮҮ-ийн 6 нь Засгийн газрын дэмжлэг, татаастай холбоотой зөвлөлгөө өгдөг байгууллагын төлөөлөл байсан.

Хүснэгт 3.5 Засгийн газрын дэмжлэг, татаас авч байсан эсэх

№	Засгийн газрын дэмжлэгт хөтөлбөрүүд	Засгийн газрын дэмжлэг авсан ААН	Засгийн газрын дэмжлэг, хөтөлбөртэй холбоотой мөнгө олгодог төрийн байгууллагын төлөөлөл	Засгийн газрын хөтөлбөртэй холбоотой зөвлөлтөгөө өгдөг БДҮҮ байгууллага
1	ЖДҮ-ийн сан	6	1	6
2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	2	6
3	УИХ-ын гишүүний дэмжлэг	1	1	-
4	Инновацийн сан	-	1	-
5	Цэвэр агаар сан	-	1	1
6	Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан	1	1	1
7	Хөрөнгө оруулалт хөгжлийн сан	-	1	1
8	Шинжлэх ухаан, технологийн сан	-	1	-
9	Хүрээлэн буй орчныг хамгаалах сан	-	1	-
10	Засгийн газрын сан	-	1	-

Судалгаанд оролцсон ААН-үүдээс 6 нь ЖДҮ-ийг дэмжих сангийн, тус бүр нэг нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, УИХ-ын гишүүний дэмжлэг, Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангийн дэмжлэгт хамрагдаж байжээ.

Засгийн газрын дэмжлэг нь ААН-ийн өсөлт болон өрсөлдөх чадварт ямар ач холбогдолтой байдаг тухай асуултад БОТ-дын 82 хувь нь “Мэдэхгүй” гэж хариулсан бөгөөд үлдэх 18 хувь нь эерэг нөлөөлдөг гэж үзсэн. Харин ААН-үүдийн бараг 50 хувь нь эерэг нөлөөлдөг гэсэн бөгөөд 42 хувь нь зарим талаар нөлөөлдөг гэжээ.

Компаниуд бизнесээ хөгжүүлэх болон өргөжүүлэхэд хуулийн ямар нэгэн саад бэрхшээл байдаг уу? (жишээ нь: бизнес эрхлэгч эмэгтэйчүүд болон залуучуудыг хязгаарласан) гэсэн асуултад БОТ-чид болон БДҮҮ-дийн өгсөн хариулт ихээхэн зөрүүтэй байв. Тухайлбал, БОТ-дын 6 хувь нь л “Тийм” гэсэн бол 41 хувь нь “Үгүй”, 53 хувь нь “Мэдэхгүй” гэж хариулсан. Харин БДҮҮ-дийн 20 хувь нь “Тийм”, тус бүр 40 хувь нь “Мэдэхгүй” “Үгүй” гэжээ. Ийнхүү БОТ-ид болон БДҮҮ-дийн бүлгээс эерэг, сөрөг хариулт өгсөн хүмүүсийн эзлэх хувь хэт их байгаа тул тодорхой дүгнэлт хийх боломжгүй байна.

ААН-ийн татварын болон санхүүгийн тайлан өгөхөд хүндрэлтэй байдаг эсэхийг тодруулахад судалгаанд хамрагдагсдын дөнгөж гуравны нэг нь “Төвөгтэй биш” гэсэн. Эндээс харахад тайлан авах үйл явцад тодорхой хэмжээний хүнд суртал байдаг нь тодорхой.

“Татвар төлөлт ашиг алдагдалтай ажилласнаас хамаарч уян хатан тогтоогддог уу?” гэсэн асуултад БОТ-дын 53 хувь (үүний дотор эрэгтэйчүүдийн 38 хувь, эмэгтэйчүүдийн 70 хувь) нь “Үгүй”, 47 хувь (үүний дотор эрэгтэйчүүдийн 63 хувь, эмэгтэйчүүдийн 25 хувь) нь “Мэдэхгүй” гэсэн бол БДҮҮ-дийн 11 хувь нь “Тийм”, 56 хувь нь “Үгүй”, 33 хувь нь “Мэдэхгүй” гэжээ.

ААН-үүд нь татвар төлөхөөс гадна татварын тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөхийн тулд өөр бусад зардал гаргахад хүрдэг. Энэхүү дүгнэлтийг нотолсон хариултыг БОТ-дын 19 хувь нь, БДҮҮ-дийн 50 хувь нь өгсөн. БОТ-дын 38 хувь нь татварын тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөхийн тулд өөр бусад зардал гаргадаггүй гэж хариулсан нь сонирхол татаж байна.

3.3. Бизнесийн үйлчилгээний хүртээмж ба чанар

Улсын бүртгэлд бүртгүүлж албан ёсны үйл ажиллагаа явуулахыг эрмэлзэж байгаа ААН-үүдийг дэмжих зорилготой бизнесийн үйлчилгээ үзүүлдэг зохих тогтолцоо байдаг гэж БОТ-дын 53 хувь нь үзэж байхад ААН-үүдийн 72 хувь нь үйлчилгээний ийм тогтолцоо байдаг талаар “Мэдэхгүй” гэж хариулсан. Энэ нь аж ахуй эрхлэлтийг албан ёсны болгох үйл явцад дэмжлэг үзүүлдэг төрийн холбогдох агентлаг, хувийн хэвшлийн зохих үйлчилгээ үзүүлэгчдийн талаар санал асуулгад оролцсон гурван бүлгийн төлөөлөгчдийн мэдлэг ихээхэн ялгаатай байгааг харуулж байна.

ААН-үүд мэргэжлийн холбоодын гишүүддээ үзүүлдэг үйлчилгээнүүдээс зөвлөлгөө өгөх үйлчилгээг “Сайн”, нягтлан бодох бүртгэл, хуулийн зөвлөгөө, өмгөөлөл хамгааллын үйлчилгээг “Маш муу” гэж дүгнэсэн бол бусдыг нь “Муу” гэж үнэлсэн. Энэ нь мэргэжлийн холбоод төрөл бүрийн хөтөлбөр, үйлчилгээ санал болгохдоо гишүүдийнхээ эрэлт хэрэгцээнд нийцсэн эсвэл өндөр чанартай үйлчилгээ үзүүлж чадахгүй байгааг харуулж байна. БДҮҮ-ид эдгээр үйлчилгээнээс олон төрлийг нь мөн санал болгож ажилладаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй юм.

Хүснэгт 3.6 БДҮҮ-дийн санал болгодог бизнесийн үйлчилгээний төрөл, үйлчилгээ авсан ААН-ийн тоогоор


Үйлчилгээний төрөл	Нягтлан бодох бүртгэл	Хуулийн зөвлөгөө	Бизнес төлөвлөгөө бэлтгэх	Зах зээлийн судалгаа	Бизнес инкубатор, зөвлөгөө өгөх	Бизнесийн удирдлагын сургалт	Бизнесийн ерөнхий зөвлөгөө, мэдээлэл авах	Мэдээллийн технологийн сургалт компьютерээр бичих чадвар	Техникийн ажилчдын сургалт	Хүний нөөцийн зөвлөгөө	Технологийн нөөцийг тодорхойлох	Зээл авах бичиг баримт бүрдүүлэх	Арилжааны зээл	Бичил санхүүгийн зээл	Бизнесийн даатгал
Үйлчилгээ авсан ААН-ийн тоо	5	3	7	5	6	3	4	2	4	4	3	3	5	5	5

Эх үүсвэр: Санал асуулгад оролцогчдын хариултаас

Улаанбаатар хотод байдаг бизнесийг дэмжих байгууллагуудад бизнесийн инновацийг дэмжих төв, бизнес инкубатор, нийслэлийн эдийн засгийн хөгжлийн газар, нийслэлийн гэр²¹ хорооллын хөгжлийг дэмжих газар болон нийслэлийн ЖДҮ эрхлэгчдийг дэмжих газар зэргийг нэрлэсэн.

ААН-үүд улсын бүртгэлд бүртгүүлж албан ёсны үйл ажиллагаа явуулах шийдвэр гаргахад нөлөөлж болох, бизнесийг дэмжих хамгийн чухал үйлчилгээ гэж судалгаанд оролцогчдын 50 гаруй хувь нь нягтлан бодох бүртгэл тооцоо, хууль эрх зүйн зөвлөгөө, бизнес төлөвлөгөөг боловсруулах, зах зээлийн судалгааг нэрлэсэн байна. Бас эдгээр үйлчилгээ нь хүртээмжтэй буюу боломжийн байжээ. Нөгөө талаас удирдлагын сургалт, ганцаарчилсан болон ерөнхий зөвлөгөө хүртээмжтэй, боломжийн байсан ч эрэлт багатай байв. Ер нь бизнес эрхлэгчид эдгээр үйлчилгээг хүсэж байгаагаас илүү давамгайлж байгаа хэмээн мэдээлсэн байна.

График 3. 5 Улсын бүртгэлд бүртгүүлж албан ёсны үйл ажиллагаа явуулахад ААН-д ямар үйлчилгээ чухал вэ?



Харин БОТ-ид бизнесийг дэмжигч агентлагууд үндэсний, бүс нутгийн ба орон нутгийн түвшинд үр дүн муутай ажилладаг гэж үзэж байв. Хэдийгээр ийм бодолтой байгаа ч БОТ-ид дараах 2 асуултад илт нааштай хариулт өгчээ:

- Шинэ, жижиг, өргөжиж буй бизнесийг дэмжих зорилготой худалдаа арилжаа, нягтлан бодох бүртгэлийн болон бусад албан ёсны үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд байдаг уу?
- Нэг цонхны үйлчилгээнээс²² хууль тогтоомжийн талаар мэдээлэл болон зөвлөгөө авч болдог уу?

Нэг цонхны болон хууль эрх зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээний талаар БОТ-ид илүү мэдээлэл, ойлголттой байгаа нь хариултуудаас харагдаж байв.

21 Гэр нь монголчуудын уламжлалт сууц юм.

22 “Нэг цонхны үйлчилгээ”-г орон нутгийн засаг захиргаанаас үзүүлж байгаа хөдөлмөр, нийгмийн төрөл бүрийн үйлчилгээг иргэдэд нэг газарт шууд үзүүлж байх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын санаачилгаар 2007 онд нэвтрүүлсэн. Нэмэлт мэдээллийг дараах вэб-сайтаас авна уу: <http://www.legalinfo.mn/annex/details/5858?lawid=9168>, Монгол хэл дээр.

3.4. Хөдөлмөр эрхлэлтийн асуудлууд ба сургалт

Хөдөлмөр эрхлэлт болон сургалтын асуудлаар санал асуулгад хамрагдсан гурван бүлгийнхний ялгаатай үүрэг, хуримтлуулсан туршлагыг судалж шинжлэх зорилгоор ААН-үүд, БОТ-ид, БДҮҮ-дээс ялгаатай ба нийтлэг зарим асуулт асуусан.

Хүснэгт 3.7 Бичгээр байгуулсан хөдөлмөрийн гэрээтэй ажиллагчид, нийт ажиллагчдад эзлэх хувиар

ААН	Ажилтантайгаа бичгээр хөдөлмөрийн гэрээ байгуулсан үү?				Нийт
	Тийм, бүгдтэй нь	Тийм, заримтай нь	Үгүй, нэгэнтэй нь ч	Мэдэхгүй	
Бүртгэлтэй ААН	30	16	17	2	65
Бүртгэлгүй ААН	2	3	18	1	24
Нийт	32	19	35	3	89

Бүртгэгдсэн ААН-үүдийн талаас илүү нь нийт ажилтантайгаа бичгээр албан ёсны хөдөлмөрийн гэрээ байгуулсан бол дөрөвний нэг орчим нь заримтай нь хөдөлмөрийн гэрээ байгуулсан гэжээ. Харин бүртгэгдээгүй 24 ААН-ийн дөнгөж 2 нь л нийт ажилтантайгаа бичгээр хөдөлмөрийн гэрээ байгуулсан, 3 нь зарим ажилтантайгаа хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна. Бүртгэгдээгүй ААН-үүдийн дийлэнх (80%) нь ажиллагчдынхаа нэгэнтэй нь ч хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй гэжээ. Тиймээс бизнесийн бүртгэл, албан ёсны хөдөлмөр эрхлэлтийн хооронд тодорхой хамаарал байгаа нь илэрхий.

Тэгвэл БОТ-дын 47 хувь нь албан ёсны бүртгэлтэй ААН-үүд бүх ажилтнуудтайгаа бичгээр хөдөлмөрийн гэрээ хийдэг гэсэн бол 6 хувь нь хөдөлмөрийн гэрээ байгуулахад аль ч байгууллагад түвэгтэй гэжээ.

Бичгээр хөдөлмөрийн гэрээ байгуулснаар ажилтнуудад ямар ашигтай вэ? гэсэн асуултад “Нийгмийн даатгал төлөхөд”, “Жил бүр ээлжийн амралтын мөнгө авахад”, “Өвчний улмаас тэтгэмж авахад” “Жирэмсний ба амаржсаны тэтгэмж авахад” гэсэн 4 хариултыг голчлон сонгожээ (график 3.6).

График 3.6 Хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулснаар ажилтны хүртэх ашиг тус



Эх сурвалж: Санал асуулгад оролцогчдын хариултаас

“ААН-д ажиллагчидтай холбоотой ямар нэгэн хүндрэлтэй асуудал тулгардаг уу?” гэсэн асуултад судалгаанд оролцсон ААН-үүдийн 48 хувь, БОТ-дын 71 хувь нь, БДҮҮ-дийн 80 хувь нь “Тийм” гэж хариулсан. ААН-д ажиллагчидтай холбоотойгоор тулгардаг гэж дараах хүндрэлийг голлон нэрлэсэн:

- Ажиллагчдын мэргэжлийн ур чадвар;
- Ажиллах хүчний олдоц;
- Удаа дараагийн өвчлөл, ажил таслалт, ажилтны ёс зүй, ажиллагчдын сахилга гэх мэт ажиллах хүчтэй шууд холбоотой асуудлууд.

Хүснэгт 3.8 ААН-д ажиллагчидтай холбоотой үүсдэг гол хүндрэл, судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн тоонд эзлэх хувиар

№	Хүндрэл	ААН	БДҮҮ-ид	БОТ-ид	Дундаж
1	Хөдөлмөр эрхлэлтийн зохицуулалт	12,8	10	23,5	15,4
2	Ажиллах хүчний олдоц	58,7	30	41,2	43,3
3	Ажиллагчдын ур чадвар	67,4	70	29,4	55,6
4	Хөдөлмөрийн маргаан	19,6	-	23,5	21,6
5	Ажил хаялт	21,7	20	11,8	18,0
6	Цалингийн доод хэмжээ	30,4	20	11,8	20,7
7	Нийгмийн даатгалын шимтгэл	15,2	40	23,5	26,2
8	Ажиллагчдын өвчлөл, ажил таслалт, ёс зүй, сахилга	39,1	40	35,3	38,1
9	Бусад	13,0	0	5,9	7,0

Эх үүсвэр: Санал асуулгад оролцогчдын хариултаас

Монгол Улсад ААН-үүдэд тулгарч байгаа гол хүндрэл нь ажиллах хүчний олдоц, ажилтны ур чадвар юм. “Чадварлаг ажилтан олж ажилд авахад хэцүү” гэж ААН-үүдийн 59 хувь, БОТ-дын 30 хувь, БДҮҮ-дийн 41 хувь нь хариулсан байна.

Судалгаанд хамрагдсан бүртгэлтэй ААН-үүдийн 40 хувь нь “Ажилтнууддаа ажлын байран дээрх сургалтаас гадна албан ёсны сургалтад хамруулдаг” гэсэн бол бүртгэлгүй буюу албан бус ААН-үүдийн ердөө 9 хувь нь л сургалтад хамруулдаг гэж хариулжээ. Эндээс бүртгэлтэй ААН-үүд ажиллах хүчнийхээ чадавхийг нэмэгдүүлэхэд илүү анхаардаг болох нь харагдаж байна.

Хүснэгт 3.9 Ажилтнууддаа ажлын байран дээрх сургалтаас гадна албан ёсны сургалт санал болгодог эсэх, хувиар


ААН	Ажилтнууддаа ажлын байран дээрх сургалтаас гадна албан ёсны сургалт санал болгодог уу?			Нийт
	Тийм	Үгүй	Мэдэхгүй	
Бүртгэлтэй ААН	40%	57%	3%	100%
Бүртгэлгүй ААН	9%	81%	10%	100%
Нийт	32%	63%	5%	100%

ААН-үүд ажилтнууддаа ажлын байран дээрх сургалтаас гадна албан ёсны сургалтад хамруулдаг эсэхэд БОТ-дын өгсөн хариулт ААН-үүдийнхтэй ойролцоо байв: бүртгэлтэй олонхи ААН албан ёсны сургалт зохион байгуулдаг гэж БОТ-дын 18 хувь нь, бүртгэлтэй зарим ААН албан ёсны сургалт зохион байгуулдаг гэж 35 хувь нь тус тус хариулсан бол 47 хувь нь мэдэхгүй гэсэн буюу хариулт өгөөгүй байна.

Улаанбаатар хот дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд (МСҮТ) чадвартай ажилчдыг бэлтгэж чадаж байна уу? гэсэн асуултад ААН-үүдийн 51 хувь, БОТ-дын 47 хувь, БДҮҮ-дийн 40 хувь нь тус тус “Мэдэхгүй” гэж хариулжээ.

Судалгаанд хамрагдсан ААН болон БОТ-дын гуравны нэг гаруй нь ААН-үүд бүх ажиллагчдаа нийгмийн даатгалд хамруулдаг, мөн гуравны нэг орчим нь нийгмийн даатгалд ямар нэгэн хэмжээгээр хамруулдаг гэж дүгнэсэн байна.

График 3.7 Ажиллагчдаа нийгмийн даатгалд хамруулсан байдал, нийгмийн даатгалд хамрагдсан ажиллагчдын эзлэх хувиар



Сүүлийн 3 жилд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн тохиолдол 1 удаа гарсан гэж судалгаанд хамрагдсан ААН-үүдийн дөрөвний нэг нь, 2-5 удаа гарсан гэж 10 хувь нь тус тус хариулсан бол 40 хувь нь мэдэхгүй гэжээ. Харин дээрх тохиолдолд нийгмийн даатгалын сангаас хөнгөлөлт болон тэтгэмж авсан гэж 16 ААН хариулсан бол 16 нь тэтгэмж аваагүй гэж хариулсан байна. Мөн сүүлийн 3 жилд жирэмсний амралтаа авч нийгмийн даатгалаас тэтгэмж авсан тохиолдол “1 удаа” гарсан гэж ААН-үүдийн 30 хувь нь, “2-5 удаа” гэж 11 хувь нь тус тус хариулсан бол зөвхөн 3 ААН “5-аас дээш удаа” гэж хариулжээ.

Сүүлийн 3 жилд ажлаас халагдсан ажилтан нийгмийн даатгалын сангаас ажлаас халагдсаны тэтгэмж авсан тохиолдол гарсан уу? гэсэн асуултад 4 ААН “Тийм”, 49 ААН “Үгүй”, 23 ААН “Мэдэхгүй” гэжээ. Нийгмийн даатгалын сангаас цөөн тооны ажилтан тэтгэмж авсан нь ийм тэтгэмж авах эрхийн талаар мэдлэг хангалтгүй эсхүл уг эрхээ хэрхэн хэрэгжүүлэх талаар мэдээлэл хомс байсантай зарим талаар холбоотой байж болох юм.

Ажиллагчдаа нийгмийн даатгалд хамруулахад болон тэтгэмж авахад шаардлагатай байгаа бичиг баримт бүрдүүлэхэд дэмжлэг, үйлчилгээ хэрэгтэй эсэхийг тодруулахад ААН-үүдийн бараг 40 хувь нь ийм дэмжлэг, үйлчилгээ хэрэгтэй гэжээ. Дараах гол шалтгааны улмаас ААН-үүд нийт ажилтнуудаа эсвэл заримыг нь нийгмийн даатгалд хамруулж чадахгүй байна:

(а) “Бага орлоготой ААН-д дарамт болдог”;

(б) “Компани дөнгөж эхлэх шатанд яваа”;

(в) ”Даатгуулахад ААН болон ажиллагчид их мөнгө төлдөг боловч буцааж авах ашиг нь бага”. Эдгээр хариулт ажил олгогч, бизнес эрхлэгчдийн мэдлэг ихээхэн хомс байгааг, эсвэл нийгмийн даатгалын тогтолцоонд арилгах шаардлагатай хийдэгдэл байгааг харуулж байна.

Ажиллагчдад хамгийн чухал хэрэгтэй байдаг хууль нь хөдөлмөрийн тухай хууль юм. Гэтэл хөдөлмөрийн тухай хууль ажиллагчдын эрх талаасаа боловсруулагдсан, хэрэгжүүлэхэд төвөгтэй гэж ААН-үүдийн 51 хувь нь үзжээ. Үүнтэй харьцуулахад БОТ-дын 71 нь энэ хууль ойлгомжтой гэдэгт итгэлтэй аж.

Бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ААН-ийн хэмжээ буюу том, жижгээс нь хамааруулан зарим нэг хуулийн үйлчлэлээс чөлөөлдөг үү? гэсэн асуултад БОТ-дын 50 хувь нь “Мэдэхгүй”, 25 хувь нь “Үгүй”, 25 хувь нь “Тийм” гэж тус тус хариулжээ.

3.5. Санхүү

Ерөнхийдөө албан ч бай, албан бус ч бай ялгаагүй, үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдэд тулгардаг хамгийн том бэрхшээл бол санхүүгийн асуудал юм. ЖДҮ-ийг дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй ихэнхи төсөл хөтөлбөрүүд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн байдаг. Тухайлбал, гаалийн болон НӨАТ-аас ЖДҮ-ийн тоног төхөөрөмжийг чөлөөлөх, зээлийн батлан даалтын санд хамруулах, ЖДҮ-ийн хөнгөлөлттэй зээл зэрэг нь бичил бизнесийг дэмжих зорилготой юм.

Дор дурьдсан асуултуудад БОТ-дын дийлэнхи нь “Үгүй” гэж хариулсан бол БДҮҮ-дийн дийлэнх нь “Тийм” гэж хариулсан нь бизнес дэмжих үйлчилгээний бүтэц дэх олон янзын бүлгүүдийн мэдлэг, мэдээллийн хүртээмж дэх илт ялгааг дахин харуулж байна:

- Өсөж буй бизнес эрхлэгчдэд санхүүгийн үйлчилгээний талаар мэдээлэл түгээх үр өгөөжтэй арга хэрэгсэл байна уу?
- Шинэ болон өсөж буй, үүний дотор үйл ажиллагаагаа дөнгөж эхэлж байгаа компаниудыг дэмжих санхүүгийн нөөц, урамшуулал болон татаас байдаг уу?
- Санхүүгийн байгууллагууд үйлдвэрлэл, ялангуяа ЖДҮ эрхлэгчдэд зээл олгохыг дэмжсэн бодлого, зохицуулалтын урамшуулал хангалттай байгаа юу?

Судалгаанд оролцогчид ЖДҮ-г зориулсан банкны зээлийн санал бэлтгэдэг дэмжлэг үзүүлэх механизм байгааг, мөн бичил зээлийн байгууллага ашиг тустай зуучлах үүрэг гүйцэтгэж байгааг тэмдэглэв.

БОТ-дын ихэнх нь дараах асуултуудад “Мэдэхгүй” гэсэн хариулт өгсөн:

(а) ЖДҮ эрхлэгч банкинд барьцаа тавихад эрсдлийг нь хувааж үүрэх тогтолцоо²³ байдаг уу?

(б) Санхүүгийн болон зээлийн даатгалын бүтээгдэхүүн хангалттай байдаг уу? (в) ЖДҮ-үүд экспортлох үедээ зээлийн баталгаа авдаг уу?

Харин БДҮҮ-дийн 50 хувь нь ЖДҮ эрхлэгч банкинд барьцаа тавихад эрсдлийг нь хувааж үүрэх тогтолцоо байдаг, 40 хувь нь санхүүгийн болон даатгалын бүтээгдэхүүн хангалттай байдаг, ЖДҮ-чид бүтээгдэхүүн экспортлох үедээ зээлийн баталгаа авдаг гэж хариулсан.

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 54 хувь нь банкнаас зээл авах хүсэлт гаргасан бөгөөд тэдний 76 хувь нь өргөдлийнхөө дагуу зээл авсан, үүний дотор 88 хувь нь арилжааны банкнаас зээл авчээ. Үлдэж буй ААН-үүдийн 25 хувь нь ББСБ, 15 хувь нь бичил санхүүгийн байгууллага, гадаад эх үүсвэр, хувь хүн найз нөхөд, ЖДҮ-ийг дэмжих сан зэргээс зээл авсан байна.

Зээлийн хүсэлт гаргасан боловч зээл авч чадаагүй гол шалтгааныг тодруулахад тэдний 65 хувь нь зээлийн барьцаа хөрөнгө хангалтгүй, 28 хувь нь арилжааны банк хүнд сурталтай, үйлчилгээний чанар нь муу, 18 хувь нь банкны ажилтныг танихгүй, 16 хувь нь ААН бүртгэгдээгүй, 8 хувь нь бизнес төлөвлөгөө муу, 8 хувь нь ТББ-д зээл олгодоггүй, 12 хувь нь мэдэхгүй буюу тодорхой шалтгааныг банкнаас мэдэгдээгүй зэрэг шалтгааныг бизнес эрхлэгчид дурьджээ.

Нөгөө талаас, ААН хүссэн зээлээ авч чаддаггүй шалтгааныг барьцаа хангалтгүй байдгаас болдог гэж санал асуулгад оролцсон, бизнесийг дэмжих санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн 80 хувь нь, хүсэлт гаргах материалаа дутуу бүрдүүлдэг гэж 50 хувь нь, банкны хүнд суртал болон үйлчилгээний чанар муугаас болдог гэж 10 хувь нь хариулсан.

Зээлдэх хүсэлт гаргаагүй ААН-үүдийн 56 хувь нь зээлийн хүү өндөр, буюу зээлийн барьцаа хөрөнгөгүй, 27 хувь нь зээл авахад дэмжих үйлчилгээ байхгүй, 18 хувь нь ААН бүртгэгдээгүй, зээл авах мэдээлэл дутмаг, 15 хувь нь санхүүгийн байгууллагуудыг мэддэггүй, 12 хувь нь санхүүгийн өөр эх үүсвэр сонгосон гэжээ.

Санхүүгийн байгууллагынхны үзэж байгаагаар ААН-үүд зээлийн хүсэлт гаргахгүй байгаа гол шалтгаан нь зээлийн барьцаа хөрөнгөгүй, зээлийн талаархи мэдээлэл хангалтгүй, зээлийн хүү маш өндөр, дэмжих үйлчилгээ хангалтгүй байгаа явдал аж.

Ямартай ч зээлийн хүсэлт гаргахад “Ерөнхийдөө нилээн хэцүү” гэж ААН-үүдийн 49 хувь нь, санхүүгийн байгууллагуудын 22 хувь нь үзсэн бол “Зээл олгож буй байгууллагаас хамааралтай, заримдаа хэцүү, заримдаа хялбар” гэж ААН-үүдийн 35 хувь, санхүүгийн байгууллагуудын 67 хувь нь хариулсан. Харин “Ерөнхийдөө нилээн хялбар” гэж ААН-үүдийн 13 хувь, санхүүгийн

23 Зээлийн батлан даалтын сан нь бизнес эрхлэгчид боломж олгох шууд эрсдэл хуваалцах тогтолцоо юм. Дараах вэб-сайтаас үзнэ үү: <http://www.lgf.mn>

байгууллагуудын 11 хувь нь үзжээ.

Мөн судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 83 хувьд нь нэмэлт санхүүгийн дэмжлэг хэрэгтэй байгаа бөгөөд тэдний 47 хувь нь арилжааны банкнаас, 18 хувь нь бизнесийн хамтрагчаасаа, 16 хувь нь лизингийн үйлчилгээгээр, 9 хувь нь гэр бүл найз нөхдөөсөө, 8 хувь нь хувиараа мөнгө зээлдүүлэгч нараас, 2 хувь нь өөрийн хөрөнгөнөөс нэмэлт санхүүжилт хийхээр төлөвлөж байна гэжээ.

Нэмэлт санхүүжилт хэрэгтэй байгаа ААН-үүдийн 79 хувь нь бизнесээ өргөжүүлэхэд зориулан хөрөнгө оруулалт хийхэд, 15 хувь нь бэлэн мөнгөний эргэлтийг нэмэгдүүлэхэд, 4 хувь нь бизнесээ албан ёсны бүртгэлтэй болгоход тус тус уг нэмэлт хөрөнгийг зарцуулахаар төлөвлөсөн байна. БДҮҮ-ид хувьд ААН-үүд санхүүгийн байгууллагаас авсан нэмэлт хөрөнгийн 90 хувийг бизнесээ өргөжүүлэх хөрөнгө оруулалтад ашигладаг гэжээ.

3.6. Үл хөдлөх хөрөнгө болон газар ашиглалт

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 43 хувь нь газрын гэрчилгээтэй байсан. Газрын гэрчилгээтэй ААН-үүдийн 89 хувь нь бүртгүүлсэн ААН байв. Газрын гэрчилгээтэй тул “Зээл авахад хялбар” гэж 84 хувь нь, “Үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхэд зориулан хөрөнгө оруулалт хийхэд эерэг нөлөөтэй” гэж 40 хувь нь, “Удаан хугацааны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулахад эерэг нөлөө үзүүлдэг” гэж 20 орчим хувь нь хариулжээ. Харин БОТ-дын хувьд газрын гэрчилгээтэй бол зээл авахад хялбар байдаг гэж 63 хувь нь хариулжээ.

График 3.8 Газрын гэрчилгээ авсан байдал (Бүртгэлтэй ба бүртгэлгүй ААН-үүд)



Газрын гэрчилгээ авахаар өргөдөл гаргасан боловч тухайн газраа авч чадаагүй ААН-үүд 67 хувийг эзэлж байв. Тэдний 70 хувь нь газраа авч чадаагүй гол шалтгааныг “Санаанд нийцсэн үл хөдлөх хөрөнгө өндөр үнэтэй”, 22 хувь нь “Шаардлагад нийцсэн талбай дутмаг” гэжээ. Мөн ААН-үүд бүртгэлгүй, албан бус урамшуулал төлөхөд бэлэн бус гэх мэт хариултууд нилээд олон давтагджээ. Харин БОТ-ид ААН-үүд тохиромжтой байрлалд газар авч чадахгүй байгаа гол шалтгааныг газрын үнэ маш өндөр байгаатай холбон үзэж байв.

3.7. Гадаад худалдааны харилцаа

Судалгаанд хамрагдсан ААН-үүд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 67,1 хувийг Улаанбаатар хотод, 23,7 хувийг аймаг, орон нутагт борлуулдаг бол 4,2 хувийг шууд экспортод, 5 хувийг зуучлагчаар дамжуулан экспортод гаргадаг байна. Гадаад зах зээлд бүтээгдхүүнээ борлуулдаг 8 ААН байгаагаас БНХАУ-д 6 ААН, ОХУ-д 5 ААН, Өмнөд Солонгост 3 ААН, Япон, Англи зэрэг улсуудад тус тус 1 ААН бүтээгдхүүн экспортолдог гэжээ. Эдгээр ААН дунджаар нийт үйлдвэрлэсэн бүтээгдхүүнийхээ 10-30 хувийг л экспортод гаргадаг байв.

Шууд импортоор худалдан авалт хийдэг ААН-үүдэд тулгардаг гол асуудалд дараах хүчин зүйлийг нэрлэж байв:

- Үнийн хэлбэлзэл, төлбөрийн үйл явц (53,7%);
- Бүтээгдхүүний чанар (48,8%);
- Нийлүүлэлтийн тасралтгүй байдал (39%);
- Импортлох үйл явц хүндрэлтэй (37%).

Гадаад худалдааны нөхцлийг тодруулах зорилгоор БОТ-ид болон БДҮҮ-дээс 10 асуулт асууж үр дүнг нэгтгэв (хүснэгт 3.10).

Хүснэгт 3.10 Гадаад худалдааны нөхцөл байдлын талаарх үнэлгээ, судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн тоонд эзлэх хувиар

Асуулт	БОТ-ид			БДҮҮ-ид		
	Тийм	Үгүй	Мэдэхгүй	Тийм	Үгүй	Мэдэхгүй
Экспортлогчид худалдааны үйл явц, төлбөр, үүрэг болон татварын талаар хангалттай мэдээлэлтэй байдаг уу?	11,8	29,4	58,8	10	30	60
Гаалийн ажилчид бүх албан ёсны худалдааны хэлэлцээр болон утга санааг мэдэж байдаг уу?	5,9	29,4	64,7	-	30	70
Бараа бүтээгдэхүүн импортлоход гаалийн үйл явц ил тод, хялбар байдаг уу?	11,8	35,3	52,9	-	20	80
Бараа бүтээгдэхүүн экспортлох үйл явц ил тод, хялбар байдаг уу?	-	35,3	64,7	-	-	-
Гарал үүслийн гэрчилгээ болон бусад шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэхэд удаан бөгөөд зардал ихтэй байдаг уу?	35,3	17,6	47,1	33,3	-	66,7
Бараа бүтээгдэхүүн экспортолж импортлоход цаг хугацаа их зарцуулдаг уу?	52,9	5,9	41,2	50	-	50
Бүтээгдхүүний стандарт болон гарал үүслийн гэрчилгээ нь гол экспортолж буй бүтээгдхүүнээ хамгаалах хэрэгсэл гэж харж байна уу?	35,3	17,6	47,1	10	10	80

Дээрх 7 асуултад ихэнх нь мэдэхгүй гэж хариулсан нь уг судалгаанд хамрагдсан байгууллагуудын бусад ажилтан илүү мэргэжсэн байдлаар ярилцлага өгөх боломжтой байсантай эсхүл гадаад худалдааны талаар нарийвчилсан мэдлэг ерөнхийдөө хомс байгаатай холбоотой байж болох юм.

Ямар төрлийн ААН-үүд бараа болон үйлчилгээ экспортлож, импортлодог вэ? гэсэн асуултад БОТ-дын 41 хувь нь зөвхөн бүртгэгдсэн ААН-үүд, 18 хувь нь бүх төрлийн ААН-үүд, 12 хувь нь бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй ААН-үүд адилхан экспортлож импортлодог гэжээ. Бүртгэгдээгүй ААН-үүдэд бараа болон үйлчилгээ экспортлож, импортлоход маш их хүндрэлтэй байдаг гэсэн. Гэтэл БДҮҮ-дийн 60 хувь “Мэдэхгүй”, үлдэх 40 хувь нь бүх төрлийн ААН-үүд экспортлож импортлодог, гэхдээ бүртгэгдээгүй ААН-үүдэд маш их хүндрэлтэй гэжээ.

БОТ-дын 65 хувь нь, ААН-үүдийн 60 хувь нь бүртгэгдээгүй ААН-үүд Монгол Улсын Засгийн газрын худалдан авах ажиллагаанд болон барилга угсралтын ажил гүйцэтгэхэд үндсэндээ оролцох боломжгүй байдаг гэж үзжээ. БОТ-дын үзэж байгаагаар Засгийн газар ААН-ээр гэрээт ажил/тендер гүйцэтгүүлэхдээ уг гэрээ түүний бизнесийн үйл ажиллагаатай холбоотой байх ёстой гэсэн гол шаардлага тавьдаг аж.

График 3.9 Засгийн газрын худалдан авах ажиллагаанд оролцох үед ААН-ээс шаардагдах зүйл, хувиар



Засгийн газрын сонгон шалгаруулалт нь үйл ажиллагаагаа эхэлж байгаа компаниудыг илүү дэмжих зорилготой байдаг уу гэсэн асуултад 65% нь “Үгүй” гэж хариулсан байв. Шинээр байгуулагдсан ААН-үүд зах зээлд чөлөөтэй нэвтэрч чадахгүй гэж БОТ-дын 71 хувь нь, БДҮҮ-дийн 30 хувь нь хариулсан.

ААН-үүдийн хувьд бүртгүүлсний дараа зах зээлд нэвтэрч ашиг тус хүртэх боломжтой гэж үзэж илүү өөдрөг бодолтой байв.

3.8. Бизнесийн хөгжил (инноваци, хөрөнгө оруулалт)

Санал асуулгад оролцсон бүртгэлтэй ААН-үүдийн 70% нь, бүртгэлгүй ААН-үүдийн 35% нь нийт ашгаа хамгийн түрүүнд дахин хөрөнгө оруулалтад зарцуулдаг гэж хариулсан. Харин ямар төрлийн ААН-үүд шинэ бүтээгдэхүүн болон үйлчилгээг зах зээлд нийлүүлдэг вэ гэсэн асуултад бүртгэгдсэн ААН-үүд гэж 77% нь, бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй ААН-үүд адилхан гэж хариулжээ.

График 3.11 ААН-үүд сүүлийн 2 жилд нийт ашгаа зарцуулсан байдал



ААН-үүдийн 54 нь өнгөрсөн 2 жилд ашгаа дахин хөрөнгө оруулалтад зарцуулсан, 47 нь хэрэглээндээ зарцуулсан, 3 нь хадгаламжид хадгалуулсан гэжээ. ААН-үүдээс “Өнгөрсөн жил ашгийнхаа хэдэн хувийг хөрөнгө оруулалтад зарцуулсан бэ? гэсэн асуултад ашгийнхаа 100 хувийг гэж 6 хувь нь, 50-аас дээш хувийг гэж 63 хувь нь, 50 хүртэлх хувийг гэж 31 хувь нь хариулжээ.

Санал асуулгад оролцсон ААН-үүдээс сүүлийн 3 жилд зах зээлд шинэ бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээ нийлүүлсэн байдлыг нь тодруулахад 3-аас дээш гэж 52 хувь нь, 3 төрлийн гэж 23 хувь нь, 2 төрлийн гэж 25 хувь нь хариулав. Бүтээгдэхүүний шинэчлэл талаас нь авч үзвэл Монголын ААН-үүд бүртгэлийн байдлаасаа үл хамааран нилээд санаачлагатай ажилладаг бололтой байна.

Санал асуулгад оролцогчид ААН-ийг бүртгэж албан болгох үйл явцыг хөнгөвчлөх бизнесийн үйлчилгээний шинэ саналууд болон хамгийн түрүүнд сайжруулах ёстой гурван зүйл хэмээн дурьдсаныг дараах хүснэгтэд нэгтгэв.

Хүснэгт 3. 11 Аж ахуй эрхлэлт дэх албан бус байдлыг даван туулахын тулд хамгийн түрүүнд сайжруулах ёстой гэж БОТ-ид, БДҮҮ-дээс санал болгосон асуудлууд

Эхний ээлжинд сайжруулах	Удаах ээлжинд сайжруулах	3 дахь ээлжинд сайжруулах
- Бүртгэлийн үйл ажиллагааг илүү хялбар болгох. - Дарааллыг багасгах. - Нэг цонхны үйлчилгээ бий болгох. - Төрийн байгууллагын үйлчилгээний чанарыг сайжруулах. - Шинэ аж ахуйн нэгж эхний ээлжинд тендерт сонгон шалгаруулалтад оролцох боломж бий болгох. - Төрийн дэмжлэгийн бодлого.	- Бүртгэлийн талаарх мэдээллийг сайжруулах. - Хүнд суртлыг арилгах. - Татварын уян хатан, урамшуулалтай бодлого бий болгох. - Цахим хэлбэрт оруулах.	- Бүртгүүлэхэд шаардлагатай бичиг баримтыг цөөхөн болгох буюу багцлах. - Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг шинээр байгуулагдаж буй ААН-үүдэд зориулж тодорхой шалгууртайгаар бий болгох. - Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, татвар болон НД-ын үйл ажилагааг илүү хялбаршуулах. - Төлөвлөгөө /хөтөлбөр/ гаргаж хэрэгжүүлэх. - Хялбар цахимжуулах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: СУДАЛГАА ХИЙХИЙН
ӨМНӨ ДЭВШҮҮЛСЭН ТААМАГЛАЛУУД
БАТЛАГДСАН ЭСЭХ

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: СУДАЛГАА ХИЙХИЙН ӨМНӨ ДЭВШҮҮЛСЭН ТААМАГЛАЛУУД БАТЛАГДСАН ЭСЭХ

Энэхүү бүлэгт судалгааг хийж гүйцэтгэхийн өмнө албан хэлбэрээр болон албан бус хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулахад нөлөөлж буй хүчин зүйлүүдийн талаар дэвшүүлсэн таамаглалууд судалгааны үр дүнд хэрхэн нотлогдож байгааг авч үзсэн. Судалгааны өгөгдөлд хийсэн задлан шинжилгээ нь санал асуулгын үр дүнд дэвшүүлсэн таамаглалуудыг баталгаажуулж байгаа, эсвэл тэдгээрийг цаашид судлах шаардлагатайг харуулж байна.

4.1. Ерөнхий таамаглал

Монгол Улсын албан бус хэвшил нь албан хэвшилээс илүү хурдан тэлж байна.

Зах зээлийн эдийн засагт шилжин, төрийн зарим өмчийг хувьчилснаар эрх зүй, зохицуулалтын зохих орчин бүрдээгүй ч гэсэн иргэд бизнесийн үйл ажиллагааг тогтмол явуулах боломж бүрдсэн юм. Энэ нь албан бус хэвшил хөгжих үндэс суурь болсон. Тухайлбал 2012-2013 онд нийт ажиллагчдын тоо 4,4 хувиар өссөн байхад албан бус хэвшилд ажиллагчдын тоо 14,6 хувиар өссөн нь энэхүү жирийн бус үзэгдэл өнөөдөр ч үргэлжилсээр байгааг харуулж байна²⁴.

Албан бус хэлбэрээр бизнесийн үйл ажиллагаагаа эхлэх нь албан хэлбэрээр эхэлснээс илүү хялбар.

Албан хэлбэрээр аж ахуйн үйл ажиллагаагаа эхлэх нь бизнес бүртгүүлэхэд зарцуулах цаг зав, мөнгө зэрэг зардлыг тооцохгүйгээр ерөнхийдөө мэргэжлийн хяналт шалгалт, зохицуулалт, татвар хураамж, нийгмийн даатгалын шимтгэл, санхүүгийн тайлан гэх мэт олон амаргүй шаардлагыг араасаа дагуулдаг. ААН-үүдийн нэрлэсэн гол бэрхшээл, хүндрэл нь:

- (а) Бүртгэлийн дүрэм журмын талаархи мэдээлэл дутмаг байдал;
- (б) Бүртгэлийн албанд таньдаг хүн байхгүй;
- (в) Гэрчилгээ бэлэн болгох хугацаа нь тодорхойгүй (Төрийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоо сул гэсэн бэрхшээлийг судалгаанд хамрагдсан төрийн байгууллагын төлөөлөгчид нэрлэсэн).

Монгол Улсад зарим ААН бүртгэлгүй, холбогдох хуулийн дагуу олгодог зөвшөөрөл буюу тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаагаа явуулдаг, мөн татвар төлдөггүй, ажиллагчидтайгаа хөдөлмөр эрхлэлтийн аман гэрээ хийдэг.

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 26 хувь нь бүртгэлгүй байв. Бүртгэлгүй эдгээр ААН-ийн бараг 80 хувь нь ажиллагчидтайгаа хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй байсан.

Бизнесээ бүртгүүлснээр их албан татвар төлдөг эсэх нь нотлогдоогүй: бизнесээ албан хэлбэрээр эхэлсэн хүмүүсийн ердөө 30 хувь нь л албан татвар өндөр төлдөг гэжээ. Энэ нь бүртгэлгүй зарим ААН өөр төрлийн татвар төлдөг (олон ААН Засгийн газарт төлдөг албан бус төлбөр буураагүй гэсэн), эсвэл бүртгэлтэй зарим ААН татвар төлөхөөс зайлсхийдэг (олон ААН бүртгүүлснээс хойш нийгэмд хандивлах хувь нэмэр буурсан гэсэн)-ийг мөн харуулж байна.

Дүгнэж хэлэхэд анхны таамаглалыг хэсэгчлэн нотлогдсон гэж үзэж болно. Бүртгэлгүй ААН-үүдийн төлөв байдлыг илүү нарийвчлан судлах шаардлага гарч байна.

Албан ёсны бүртгэлтэй нилээд ААН албан ёсоор тайлан бүртгэлдээ тусгадаггүй, татвар төлдөггүй албан бус үйл ажиллагаа явуулдаг.

Энэхүү таамаглал нь төсөөлөл хэвээр байна; судалгааны үр дүн нь дээр дурьдсан мэдэгдлийг нотолж чадаагүй.

Бизнесийн орчны төлөв байдал нь бизнес эрхлэх үйл ажиллагаагаа албан ёсны болгох талаар ААН-ээс гаргах шийдвэрт нөлөөлдөг. Энэхүү шийдвэр нь эргээд ААН-үүдийн харьцангуй өрсөлдөх чадварт ч, зохист хөдөлмөр эрхлэлт, орлого бий болгосны дагалдах ашигт ч шууд хамааралтай.

Судалгаанд дэвшүүлсэн энэхүү гол таамаглал түүний үр дүнгээр хэсэгчлэн нотлогдсон. Бүртгэх үйл явц нь бизнесийн орчны нэг асуудал мөн. Энэ үйл явцын талаарх судалгааны үр дүн нэг утгатай биш байв. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 60 хувь нь бүртгэх үйл явцад сэтгэл хангалуун байгаагаа илэрхийллээ. Гэсэн хэдий ч шинэ бизнес эхлэхэд тодорхой зохицуулалтын улмаас бизнесийн ажиллагаа, өсөлт хөгжилтөд саад, бэрхшээл учирч байгааг дурьдсан байна (олон удаа дурьдсан хүндрэл бэрхшээлийн тоонд тусгай зөвшөөрөл, гадаад худалдаа, хөдөлмөр эрхлэлтийн зохицуулалт орсон. Харин бизнесийн бүртгэл нь өөрөө энэ жагсаалтын сүүлд нь орсон байв).

Хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй албан ААН-үүдийг дэмжихүйц урамшууллын тогтолцоо байгаа эсэх нь бизнесийн орчны бас нэг асуудал юм. Албан ёсны бүртгэлтэй болсноор олох ашиг тус, бизнест үзүүлэх бусад нөлөөллийн талаар асуухад 42 хувь нь өөрсдийн бизнесийн үйл ажиллагаа илүү найдвартай болсныг мэдэрсэн гэж хариулав. Судалгаанд оролцсон ААН-үүдийн 26 орчим хувь нь буюу харьцангуй цөөн тооны ААН бизнест эерэг нөлөөтэй гэж үзжээ. ААН-ийн эрх зүйт байдал

Засгийн газрын тендерт оролцох бололцоо олгож, зохион байгуулалттай зах зээлээс зээл авахад тусалсан гэх зэрэг бусад давуу талыг мөн дурьдсан. Бүртгэлтэй ААН-үүд бүртгэлгүйгээсээ илүүтэйгээр газар өмчлөх, ашгийг дахин хөрөнгө оруулалтад зарцуулах сонирхолтой байдгаа мэдээлсэн. Хэдийгээр хоорондын хамаарал их биш байгаа ч эдгээр хувьсагч нь өсөлтөд баримжаалсан ААН-ийн өрсөлдөх чадварт илэрхий хувь нэмэр оруулна.

4.2. Бизнесийн орчны хүчин зүйлүүд ба аж ахуй эрхлэлтийг албан хэлбэрт шилжүүлэх үйл явцын хоорондох хамаарлын талаар дэвшүүлсэн таамаглалууд

Бүртгэх үйл явц цаг хугацаа, зардал их зарцуулдаг зэрэг хүндрэлтэй.

ААН-ийг бүртгэх үйл явцыг илэрхийлдэг үзүүлэлтүүд нь албан хэлбэрээр бизнес эрхлэх шийдвэрт эерэг нөлөөлж байна. Бүртгэлийн гэрчилгээг албан ёсоор 3 өдөрт багтаан олгож байхаар тогтоосон байхад практик амьдралд дунджаар 6,5 өдөр зарцуулж байгаа хэдий ч бүртгэлийн албаны үйл ажиллагааг ААН-үүд боломжийн гэж үздэг. Үүний зэрэгцээ бүртгэлийн албад дүрэм журмаа сайтар танилцуулдаг, ажилтнууд нь хувийн туслалцаа үзүүлдэг байхыг, мөн гэрчилгээ бэлэн болгох хугацаагаа илүү тодорхой болгохыг тэд хүсэж байв.

Татварын зохицуулалт, нийгмийн даатгалын шимтгэл болон татварын дарамт зэрэг нь албан хэлбэрт шилжихэд сөргөөр нөлөөлдөг.

Эдгээр хүчин зүйлийн улмаас зөвхөн зарим ААН албан ёсоор бүртгүүлэхээс татгалздаг байна. ААН-үүдийн 30 хувь нь бүртгүүлсний дараа илүү өндөр татвар төлөх шаардлагатай болсон гэсэн бол 33 хувь нь үгүй гэжээ. Түүнчлэн ААН-үүдийн 36 хувь нь бүртгүүлсний дараа ажиллагчдын нийгмийн даатгал төлөх үүрэг хүлээдэг гэдгийг үгүйсгэсэн бол 27 хувь нь үгүйсгээгүй байна.

Албан бус хөдөлмөр эрхлэгч олон иргэн Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу сайн дураараа нийгмийн даатгалд хамрагдаж, нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн доод хэмжээнээс тооцож төлдөг байна. Харин өндөр тэтгэвэр тогтоолгохын тулд тэд тэтгэврийн насаа ойртоход буюу сүүлийн 5 жилд маш өндөр орлогоос нийгмийн даатгалын шимтгэл төлдөг.

Эцэст нь хэлэхэд албан татварын болон нийгмийн даатгалын хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилт нь бизнесээ албан хэлбэрт шилжүүлэх шийдвэрт их биш ч, ямар нэг хэмжээгээр нөлөөлдөг байна.

Засгийн газрын тусламж, татаас, дэмжлэг.

Маш цөөхөн хэсэг нь бүртгүүлж албан хэлбэрээр ажиллах болсноор Засгийн газрын тусламж, татаас, дэмжлэгт хамрагдах боломжтой болно

гэж хариулж байсан бол үлдсэн хэсэг нь албан хэлбэрт шилжсэн ч ямар нэгэн дэмжлэгт хамрагдаж чадахгүй гэж байв.

Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа.

Ийм хамтын ажиллагаа сул байгааг БОТ-дын хамгийн гол бэрхшээл гэж дурьдсан.

Хяналт шалгалт, түүний давтамж.

Судалгаанд хамрагдсан зарим хүмүүс үүнийг хүндрэл учруулагч хүчин зүйл гэж үзсэн боловч энэ нь албан хэлбэрт шилжих эсэх талаар бизнес эрхлэгч сонголт хийхэд ерөнхийдөө нөлөөлөл багатай байна.

Бодлогын яриа хэлэлцээ хийх боломж, оролцоо.

Дахин хэлэхэд, судалгаанаас үзэхэд энэ хүчин зүйл нь албан хэлбэрт шилжих эсэх талаар бизнес эрхлэгч сонголт хийхэд бага зэрэг нөлөө үзүүлсэн байна. Бизнесийн асуудлуудыг ач холбогдлоор нь эрэмбэлэх, нэмэлт татвар хэр дарамттайг нотлох, бизнесийг дэмжих зарим төрлийн үйлчилгээ үзүүлдэг эсэх, хөдөлмөрийн тухай хууль компаниудад хэр ойлгомжтой зэрэг асуудлаар тодорхой ААН болон Засгийн газрын агентлагийн өгсөн хариултууд зөрүүтэй байсан явдал судалгааны үр дүнгээс нийтлэг харагдсан нэг чиг хандлага байв. Түүнчлэн бизнесийн өрсөлдөх чадварт Засгийн газрын дэмжлэгт хөтөлбөрүүдийн үзүүлэх нөлөөний талаар асуухад 82 хувь нь мэдэхгүй гэсэн.

4.3. ААН-ийн өрсөлдөх чадвар ба аж ахуй эрхлэлтийг албан хэлбэрт шилжүүлэх үйл явцын хоорондох хамаарлын талаар дэвшүүлсэн таамаглалууд

Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар ба үнэ.

Албан ёсоор бүртгүүлснээр бүтээгдхүүний нэр, хаяг шошго, сав баглаа, даатгал, техникийн болон нийгмийн стандартын зохих шаардлага хангагдах учраас бүтээгдхүүн буюу үйлчилгээний өрсөлдөх чадвар нэмэгдэнэ. Харин үнийг зах зээлийн хүчин зүйлүүд тодорхойлох нь ойлгомжтой. Харин бүртгэлтэй ААН-үүд ихэнх тохиолдолд илүү чанартай бүтээгдхүүнийг өндөр үнээр санал болгох боломжтой юм.

Судалгааны үр дүн ямар нэг хэмжээгээр энэ таамаглалыг нотолсон бөгөөд өрсөлдөх чадварын шалгуур үзүүлэлтийн талаар албан бус ААН-үүдээс илүүтэй тайлагнан тайлбарлаж буй албан ААН-үүд цөөн байгааг харуулсан.

Зах зээлд нэвтрэх боломж.

Бүртгүүлж албан хэлбэрт шилжин үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн хэрээр хамтрагч байгууллагуудтай бичгээр гэрээ байгуулж, банкны дансаар төлбөр тооцоо хийх зайлшгүй шаардлагатай болдог. Албан хэлбэрт шилжсэнээр зах зээл, хэрэглэгчдэд нэвтрэх боломжтой болно гэдэгтэй арай олон ААН санал нэг байв. Гэхдээ энэ байдал нь зах зээлд нэвтрэх талаар ямар ч нөлөө байхгүй гэж хариулсан БОТ-ид болон БДҮҮ-дийн ихэнх хэсгийн санаа бодолтой зөрчилдөж байлаа.

Экспортлох, импортлох бололцоо.

Бизнесээ бүртгүүлснээр бараа импортлох, экспортлох илүү боломжтой болно гэснийг судалгаанд оролцогчдын бараг 77 хувь нь хүлээн зөвшөөрөөгүй. Бараа импортлох, экспортлох нь бүртгэлгүй ААН-д хүндрэлтэй байж болох боловч, энэ нь бололцоотой байдаг ажээ.

Засгийн газрын тендерт оролцох боломж.

Зөвхөн бүртгэлтэй ААН Засгийн газрын тендерт оролцох боломжтой байдаг тул судалгаанд хамрагдсан БОТ-ид болон ААН-үүдийн аль алиных нь 60 гаруй хувь бүртгэлтэй болоход шууд нөлөөлдөг хэмээн хариулсан. Түүнчлэн 2013 оноос эхлэн жижиг ААН-үүд Засгийн газрын тендерт оролцох нөхцөл бүрдсэн төдийгүй Засгийн газрын Худалдан авах ажиллагааны газраас тендерийг цахим хэлбэрээр зарладаг болсон нь нөхцөл байдлыг улам сайжруулсан байна.

Олон улсын хөрөнгө оруулалтын хүртээмж сайжрах болно.

Олон улсын хөрөнгө оруулагчид хууль эрх зүй, нийгмийн бүх стандартад нийцсэн албан ёсны бүртгэлтэй ААН-д хөрөнгө оруулах сонирхолтой байна. Гэхдээ судалгааны үр дүн үүнийг шууд баталж чадаагүй.

Даатгалд хамрагдах.

Санал асуулгад оролцогчдын ойролцоогоор гуравны хоёр нь даатгалд хамрагдах боломж өргөжсөн тул энэ нь бизнесээ бүртгүүлэх шийдвэрт төдийлөн нөлөөлдөггүй гэж үзсэн.

Тохиромжтой байрлалд газар өмчилж авах чадвар.

Судалгаанд оролцогчдын 80 гаруй хувь нь бүртгэлтэй ААН газар өмчилж авахад хялбар байдаг гэдэгт эргэлзэж байлаа. Энэ нь Улаанбаатар хотод үл хөдлөх хөрөнгийн үнэ өндөр байгаа бие даасан хүчин зүйлийн улмаас ийм байж болох юм. Газрын гэрчилгээтэй ААН-үүдийн 89 хувь нь бүртгэгдсэн ААН байсан гэдгийг энэхүү судалгаа харуулсан. Түүнчлэн газрын гэрчилгээ эзэмшсэнээр зээл авахад илүү хялбар болсон, үйлдвэрлэлээ өргөжүүлэх хөрөнгө оруулалт хийхэд эерэг нөлөөлсөн, урт хугацааны худалдан авах гэрээ байгуулж баталгаажуулахад тустай байсан гэж судалгаанд хамрагдсан олон хүн үзэж байв.

Мэргэшсэн хүний нөөцтэй болох.

Бизнесээ бүртгүүлснээр мэргэшсэн ажиллах хүч хөлсөлж ажиллуулах боломж нэмэгдэнэ гэдэгтэй санал асуулгад оролцогчдын дийлэнх нь санал нэгдээгүй. Түүнчлэн чадвартай ажиллах хүч хомс байгаа нь бизнесийн салбарынхны хувьд асуудал болоод байгааг компани бүртгэлтэй, бүртгэлгүйгээс үл хамааран “Чадварлаг ажилтан олж ажилд авахад хэцүү” гэж ААН-ийн 59 хувь, БОТ-дын 30 хувь, БДҮҮ-дийн 41 хувь нь хариулснаас харж болно.

Гэхдээ ажилтнууд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах боломж, бололцоо нь ААН-ийн албан буюу албан бус байдлаас нилээд хамаардаг байж болох байна. Судалгаанд хамрагдсан бүртгэлтэй ААН-үүдийн 40 хувь нь “Ажилтнуудаа ажлын байран дээрх сургалтаас гадна албан ёсны сургалтад хамруулдаг” гэсэн бол бүртгэлгүй буюу албан бус ААН-үүдийн ердөө 9 хувь нь л сургалтад хамруулдаг гэж хариулжээ.

Засгийн газрын тусламж, татаас.

Судалгаанд хамрагдсан бүлгийнхний зөвхөн 39 хувь нь албан болсноор Засгийн газрын дэмжлэгт хөтөлбөрүүдэд хамрагдах боломжтой болно гэж хариулж байсан бол үлдэх 61 хувь нь ийм боломжтой болж чадахгүй гэж үзжээ. Магадгүй энэ ойлголт Засгийн газрын дэмжлэг авах нь ямар ч тохиолдолд маш хэцүү байдаг гэж зарим хэсэг нь үзэж байгаагай холбоотой байж болох юм.

ААН-ийн нэр хүнд өсөх.

Энэ хэсэгт тайлбарласан олон хүчин зүйл албан ААН-ийн өрсөлдөх чадварыг үнэхээр нэмэгдүүлдэг гэвэл тэдгээр нь ердийн нөхцөлд компанийн нэр хүндийг мөн эргэлзээгүйгээр өсгөх билээ.

Ирээдүйд үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж.

Зарчмын хувьд ААН-үүд улсын бүртгэлд бүртгүүлснээр үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд шаардагдах нөөц ба зах зээлд нэвтрэх боломжтой болдог. ААН-ийн тамга, данс зэрэг нь хэрэглэгчид болон түншүүдэд итгэл төрүүлэх чухал хүчин зүйл мөн бол хууль ёсны байх нь гэрээ байгуулахад зарим талаар албан ёсны баталгаа болж өгдөг. Өмнө дурьдсанчлан зарим асуудал ийнхүү хэсэгчлэн нотлогдож байна. Бизнесээ өргөжүүлэх хэтийн төлөвийн хувьд бүртгэлтэй ААН-үүд ашгаа дахин хөрөнгө оруулалтад зарцуулах илүү сонирхолтой байдаг (бүртгэлгүй аж ахуйн нэгжүүдийн дунд ердөө 35 хувь байсантай харьцуулахад дахин хөрөнгө оруулалтад ашгаа зарцуулах сонирхолтой ААН-үүдийн эзлэх хувь 70 байсан) нь, мөн бүртгэлтэй компаниуд бүртгэлгүйгээсээ илүү олон төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг нь нотлогдсон. Иймэрхүү үр дүн нь ААН-ийн цар хэмжээтэй холбоотой байж болох бөгөөд гэхдээ энэ нь зохих ёсоор шалгаж үзэх асуудал юм.

4.4. Албан хэлбэрт үйл ажиллагаагаа шилжүүлэхэд бизнесийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ хэр хамааралтай байгаа тухай таамаглал

Бизнесийг дэмжих төрөл бүрийн үйлчилгээ нь аж ахуй эрхлэлтийг албан бус хэлбэрээс албан хэлбэрт шилжүүлэхэд тус дөхөм үзүүлдэг.

ААН-ийг бүртгүүлэх, албан хэлбэрт шилжүүлэхэд тус дөхөм үзүүлдэг чухал ач холбогдолтой бизнесийг дэмжих үйлчилгээг судалгаанд хамрагдсан бүлгийн төлөөлөгчид дараах дэс дарааллаар дурьдсан: Нягтлан бодох бүртгэл, хууль эрх зүйн зөвлөгөө, бизнес төлөвлөгөө боловсруулалт, зах зээлийн судалгаа, техникийн ажилтнуудын сургалт, мэдээллийн технологийн сургалт зэрэг юм.

Одоо үзүүлж байгаа бизнесийг дэмжих үйлчилгээний ихэнх нь зааварчлага зөвлөмж өгөх, бизнес инкубаторт бойжуулах, бизнес төлөвлөгөө бэлтгэх, зах зээлийн судалгаа хийхтэй холбоотой байна. Судалгаанд хамрагдсан ААН-үүд нягтлан бодох бүртгэл, тооцоо хөглөх үйлчилгээг цөөн тооны байгууллага санал болгодог, мөн үйлчилгээний чанар нь маш тааруу байдаг гэсэн.

**ТАВДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ ҮР
ДҮНД ҮНДЭСЛЭН ГАРГАСАН БОДЛОГЫН
ЗӨВЛӨМЖ**

ТАВДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ ҮР ДҮНД ҮНДЭСЛЭН ГАРГАСАН БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

Зөвлөмж 1: Бичил бизнес эрхлэгчид, ЖДҮ-т ээлтэй албан татварын орчин бий болгох.

- Албан татвар, хөдөлмөрийн өнөөгийн хууль тогтоомж, тусгай зөвшөөрлийн тухай үндсэн ойлголт, гарч буй хүндрэл бэрхшээлийг судлах, түүнчлэн тэдгээрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх. Судалгаанд оролцогчид бизнесийн өргөжилт, хөгжилд учирч буй гол саад тогтор хэмээн эдгээр хүчин зүйлийг заасан.
- ААН-ийн бүртгэлийн гэрчилгээ авахад зарцуулах хугацааг багасгаж хуулиар тогтоосон 3 өдөрт аль болох ойртуулах арга замыг олох (Энэ судалгаанд дурьдсанаар бүртгүүлэхэд зарцуулах хугацаа дунджаар 6,5 өдөр байв). Улсын бүртгэлд ААН-ийг бүртгэх, тусгай зөвшөөрөл олгохтой холбогдуулан зохицуулалт ойлгомжгүй, дүрэм журам хэтэрхий төвөгтэй гэх саад бэрхшээлийг олонтаа дурьдсан байгаа тул бүртгэл, тусгай зөвшөөрлийн асуудлыг бизнесийн орчны гол шинэчлэл гэж үзэх хэрэгтэй. Судалгаанд оролцогчдын 45 орчим хувь нь албан бус урамшуулал (гар цайлгах мөнгө) төлөх нь нийтлэг практик болсон гэж үзсэн бол зарим хэсэг нь банкинд данс нээхэд хүндрэлтэй гэж байв.
- ААН-ийн үйл ажиллагаа, өсөлтөд саад тогтор болдог зохицуулалтын тоонд татвар, хураамжийг судалгаанд оролцогчдын 55 хувь нь дурьдсан. Энэ асуудлаар цаашид үнэлгээ хийж, шинэчлэл хийх шаардлагатай. Аль болох хүнд суртлын саад тогторгүй, дагаж мөрдөхөд хийдэгдэл багатай байхаар татварын тогтолцоог хялбаршуулбал зохино. Татварын хувь хэмжээ тогтооход ашигладаг борлуулалтын жишиг тодорхойлохын тулд үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын талбай, цахилгаан эрчим хүчний хэрэглээ гэх мэт бодитой үзүүлэлтийг хялбаршуулсан тогтолцоондоо хэрэглэж болно. Жижиг үйлдвэрийг дэмжихэд чиглэгдсэн татварын шинэтгэл нь ААН-ийн орлогын албан татварын хувь хэмжээг бууруулах, үл хөдлөх хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг хурдавчилсан аргаар тооцоолох, ерөнхий болон зорилтот хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлт, санхүүгийн хөшүүрэг хэрэглэх зэрэг арга хэрэгслийг хамарч болох юм.
- Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ын өнөөгийн босгыг өндөрсгөх нь зүйтэй байж болох юм. Монгол Улсад импортолсон болон үйлдвэрлэсэн, борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний албан татвар тооцох үнэлгээний 10 хувиар НӨАТ-ыг ногдуулдаг. Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа импортолсон болон экспортолсон этгээд, түүнчлэн бараа үйлдвэрлэсэн буюу борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн иргэн, хуулийн этгээд НӨАТ төлөгч байна гэж хуульд заасан. Татвар төлөгч

нь татвар ногдох борлуулалтын орлогын хэмжээ 10,0 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн бол НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх шаардлагатай байдаг. Энэ босгоос доогуур орлоготой компаниуд сайн дураараа НӨАТ төлөгчөөр бүртгүүлж болох сонголт бий. Энэхүү илтгэлийг бичиж байх үед Монгол Улсын УИХ нь НӨАТ-ын босгыг өндөрсгөж 200 сая төгрөгт хүргэх эсэх тухай маргаан өрнөж байв. Өнөөгийн босгыг ийнхүү өндөрсгөх нь НӨАТ төлөгчөөр бүртгүүлэхэд ЖДҮ, бизнесээ дөнгөж эхэлж буй ААН-үүдэд учирч буй хүнд суртлын дарамтыг ихээхэн багасгаж, албан хэвшил дэх бизнесийн үйл ажиллагаанд ихээхэн хувь нэмэр оруулах болно.

- Судалгаанд оролцогчдын зарим нь албан татвар «ашигт суурилсан» гэж тэмдэглэсэн. Өөрөөр хэлбэл ЖДҮ ашигтай ажиллаж байгаа эсэхээс хамаарч татварын хэмжээг уян хатан тогтоохгүй байгаа гэсэн. Энэ талаар хийх шинэтгэл нь дотооддоо эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх ЖДҮ-ийн чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байвал зохино.

Зөвлөмж 2: ЖДҮ-т чиглэгдсэн санхүүгийн урамшууллыг өргөжүүлэх.

- Зээлийн батлан даалтын санг сурталчлах, үйл ажиллагааг нь өргөжүүлж сайжруулах. ААН-үүд зээлийн батлан даалтын санд хэрхэн хамрагдах талаар мэдээлэлгүйгээс гадна холбогдох албаны хүмүүс үйлчилгээ нь хангалтгүй, хамрагдах боломж хязгаарлагдмал мэтээр ярьж байв.
- Санхүүгийн байгууллагын нийлүүлж буй бүтээгдэхүүнийг нэн ялангуяа бичил бизнест хүртээмжтэй ба нийцэмжтэй болгох талаар санхүүгийн салбарынхантай хамтран ажиллах.
- Санхүүгийн байгууллагын үйлчилгээний талаархи мэдээллийг ЖДҮ-т үр өгөөжтэй түгээх.
- ЖДҮ илүү боломжийн хүүтэй зээл авах «барьцаа» гэх мэт зээлийн эерэг түүхийг ашиглаж, зээлдүүлэгч өөр өөр байгууллагаас илүү өрсөлдөөнтэй болзол хайж чадах шинэлэг арга замыг дэмжих.
- ЖДҮ-ийн удирдлагын ур чадварыг нэн ялангуяа санхүүгийн хүрээнд дээшлүүлэх зардал багатай сургалтыг өргөжүүлэх.

Зөвлөмж 3: Засгийн газрын тендерт жижиг компани оролцох бололцоо олгох.

- Бүртгүүлж албан хэлбэрээр үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардал (өөрөөр хэлбэл, татварын үүрэг)-ыг олж болох ашиг тустай нь харьцуулснаар албан үйл ажиллагаа явуулах болсны давуу талыг харуулж болно. Ийм давуу талын тоонд Засгийн газрын байгууллагатай худалдан авах ажиллагааны гэрээ байгуулах давуу эрх хамрагдаж болох юм.
- Зөвхөн бүртгэлтэй ААН Засгийн газрын тендерт оролцох боломжтой бөгөөд энэ нь ААН-ээ бүртгүүлж албан хэлбэрээр үйл ажиллагаа явуулах тухай шийдвэр гаргахад шууд, эерэг нөлөө үзүүлнэ. Тендерт оролцох талаар Засгийн газрын Худалдан авах ажиллагааны газраас жижиг үйлдвэрүүдэд илүүтэй дэмжлэг, туслалцаа үзүүлдэг болох нь албан хэлбэрээр бизнес эрхлэхийг цаашид хөхиүлэн дэмжиж урамшуулах ач холбогдолтой юм.

- Засгийн газрын тендерт ЖДҮ оролцоход дэмжлэг үзүүлэх. Худалдан авах ажиллагааны багцыг хэд хэдэн жижиг тендер болгож хуваах нь уг үйл явцад оролцох жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих бололцоо олгоно.

Зөвлөмж 4: Ижил төстэй үйлдвэртэй туршлагаасаа хуваалцах замаар суралцах, сургалтад хамрагдах зардал багатай сонголт хийх өргөн боломжоор ЖДҮ-үүдийг хангах.

- Сургалтад хамрагдах, зардал багатай сонголт хийх өргөн боломжоор хангах замаар ЖДҮ-ийн өсөлтийг жолоодож чадахуйц хүмүүний нөөц сургаж бэлтгэх хүч чармайлтыг нэмэгдүүлэх. Бизнесийг дэмжих үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд одоогийн байдлаар үйлчилгээний төрөл нь ч, чанар нь ч шаардлага хангахгүй сонголт санал болгож байна. Тухайлбал, бүртгэл тооцоо, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ нь бизнесийн үйл ажиллагааг албан хэлбэрт шилжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хамгийн чухал арга зам гэж судалгаанд хамрагдагсад үзсэн. Гэвч ийм үйлчилгээ ерөнхийдөө хомс, мөн үйлчилгээ байгаа ч тэдгээр нь чанарын хувьд муу байдаг аж. Албан хэлбэрт шилжих, бизнесээ өргөжүүлэхэд дөхөм үзүүлж чадахуйц зохих, хүртээмжтэй сургалтад хамрагдах сонголттой байх нь чухал хэрэгцээ мөн.
- Албан хэлбэрт шилжихийг дэмжих өөр нэг урамшуулал болгож Засгийн газар экспортын зах зээлд гаргах бүтээгдэхүүний стандарт, эсхүл бүтээгдэхүүний загварын талаар сургалт зохион байгуулж болох юм.

Зөвлөмж 5: Хөдөлмөртэй холбоотой бүх хуулийг компаниудад ойлгомжтой, дагаж мөрдөх бололцоотой болгож шинэчлэх.

- Бүх ажилтныг хөдөлмөр эрхлэлтийн гэрээтэй болгоход хүчин чармайлтаа чиглүүлэх, ажилтан бүр бичгээр байгуулсан гэрээтэй байхын ач холбогдолд гол анхаарлаа хандуулж, компаниудын дунд мэдлэг дээшлүүлэх үйл ажиллагааг бусад олон асуудлаас онцгойлон үзэж явуулах.
- Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэх үйл ажиллагаа ид явагдаж байгаа тул хөдөлмөрийн бүх хуулиудын уялдаа зохицуулалтад холбогдох асуудлуудыг шийдвэрлэх бололцоотой юм. Бодлого боловсруулагчид өнөөгийн дагаж мөрдөж буй хуулийн болон боловсруулж бэлтгэсэн хуулийн төслийн үр нөлөөллийн үнэлгээг зохих ёсоор хийх хэрэгтэй байна.
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн өндөр насны тэтгэвэр тогтоох тооцоотой холбогдох зүйл заалтад тэтгэвэр тогтоолгох хөдөлмөрийн хөлсийг шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх аль дуртай дараалсан 5 жилээр бус харин хөдөлмөр эрхэлж шимтгэл төлсөн бүх хугацаагаар нь тооцдог байх тухай нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй. Албан бус хөдөлмөр эрхлэгч олон иргэн Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу сайн дураараа нийгмийн даатгалд хамрагдаж, нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн доод хэмжээнээс тооцож төлдөг байна. Харин өндөр тэтгэвэр тогтоолгохын тулд тэд тэтгэврийн насаа ойртоход буюу сүүлийн 5 жилд маш өндөр орлогоос нийгмийн даатгалын шимтгэл төлдөг.

Зөвлөмж 6: Экспортын зах зээлд нэвтрэх жижиг компаниудын чадварыг нэмэгдүүлэхэд туслах.

- Цахим нэхэмжлэл болон Засгийн газрын цахим гүйлгээг идэвхижүүлэхийн тулд бизнес эрхлэгчдийн цахим паспорт, үнэмлэхийг дэмжих.
- Гадаад худалдааны үйл явцад гардаг саатлыг багасгах үүднээс мэдүүлэх, боловсруулалт хийх баримт бичгүүдийг цахим мэдээлэл солилцох системд суулгаж өгөх.
- Экспорт, импортын зах зээлтэй холбоотой маш чухал мэдээллийг бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй түгээх. Гаалийн албан тушаалтан худалдааны бүх хэлэлцээр, тэдгээрийн нөхцөл, болзлыг бүрэн мэдэж байх шаардлагатай.
- экспортын зах зээлд нэвтрэх ЖДҮ-ийн чадварыг дээшлүүлэхийн тулд экспортын дүрэм журам болон үйл явцын талаарх зардал багатай сургалтад хамрагдах боломжоор хангах.

Зөвлөмж 7: Төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, харилцан зохицуулалтыг сайжруулах.

- Өргөдөл гаргах явцад бизнес эрхлэгчдээс гаргуулан авч буй бичиг цаасны давхардлыг багасгах. Одоогийн байдлаар олон яам, агентлаг давхардсан мэдээлэл ирүүлэхийг шаарддаг. Энэ нь ААН-үүдэд илүүц нэмэлт дарамт учруулж байгаа төдийгүй уг мэдээллийг боловсруулах албан тушаалтны зарцуулах цаг зав, бусад нөөцийг барна. Иймд, жишээлбэл цахим технологи илүүтэй ашиглах замаар Засгийн газрын байгууллага хоорондын мэдээлэл солилцоог сайжруулах нь нэг тэргүүлэх чиглэл байж болно. Мөн төрийн байгууллагын голлох бус үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх боломжтой.

Зөвлөмж 8: Төрийн үйлчилгээний ил тод байдал, үр ашгийг нэмэгдүүлэх.

- Төрийн үйлчилгээний байгууллагуудын дунд шинэ хэм хэмжээ, норм болон зан үйлийг урамшуулан дэмжих, үр чадвар, бүтээмж, үр ашигт суурилсан цалингийн тогтолцоог багтаадаг гүйцэтгэлийн менежмент нэвтрүүлэх. Бүтээмжийн ашиг тусыг байгууллагадаа хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдад илүү урамшуулал хэрэгтэй.
- Төрийн албан хаагчдын мэргэжлийн сургалтын шаталсан бүтэц бий болгох. Сургалтад хамрагдах, ажил мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг авах илүү боломжоор хангах үндсэн дээр анхдагч түвшний төрийн албан хаагчид тогтвортой хөдөлмөр эрхлэхийг урамшуулах шаардлагатай байна.
- Бизнес эрхлэгчид болон төрийн албан хаагчдын харилцан итгэлцэл, харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх зорилгоор мэдээлэл солилцох, яриа хэлэлцээ хийх чуулган зарлан хуралдуулдаг болох. Судалгаанд хамрагдсан энэ хоёр бүлгийн хоорондох ойлголт, хариултын зөрүүтэй байдал нь нийтлэг ойлголт, тохиролцоо бий болгох шаардлагатай байгааг харуулж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. ЭЗБӨЧСТ, МонАОЭНХ, ОУХБ. “Албан ёсны аж ахуй эрхлэлт ба өрсөлдөх чадварын судалгаа”, Олон Улсын Хөдөлмөрийн Товчоо, 2014
2. ОУХБ: Албан бус байдлыг хэмжихүй: Албан бус хэвшил ба албан хөдөлмөр эрхлэлтийн талаарх статистикийн шинэ гарын авлага (Олон Улсын Хөдөлмөрийн Товчоо, Женев, 2013)
3. ОУХБ: Тогтвортой аж ахуйн нэгжийг дэмжих тухай дүгнэлт (ОУХБХ, 96 дугаар чуулган, Женев, 2007). Тогтвортой аж ахуйн нэгжид Ээлтэй Орчин бүрдүүлэх талаарх ОУХБ-ын хөтөлбөр (EUSE)-ийг дараах вэб-сайтаас үзнэ үү: http://eese-toolkit.itcilo.org/index.php?option=com_content&view=article&id=94&Itemid=240&lang=en.
4. ОУХБ: Зохист хөдөлмөр ба албан бус эдийн засаг. Олон Улсын Хөдөлмөрийн Бага хуралд тавьсан Ерөнхий захирлын илтгэл. (Олон Улсын Хөдөлмөрийн Товчоо, Женев, 2002).
5. ОУХБ: Орон нутгийн засгийн хөгжил ба зохист хөдөлмөрийн судалгааны эмхтгэл (Олон Улсын Хөдөлмөрийн Товчоо, Манила, 2006).
<http://www.mongolbank.mn/documents/tovhimol/group8/01.pdf>
6. Монгол Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 1 дүгээр тогтоолын хавсралт, “Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”
7. Монгол Улсын Их Хурал: Монгол Улсын 2013 оны макро эдийн засгийн хүлээгдэж буй гүйцэтгэл, 2014 оны хандлага, Илтгэл (Монгол хэл дээр), <http://www.parliament.mn/files/download/45734/>
8. Монгол банк. Сүүдрийн эдийн засаг, Судалгааны ажил, Товхимол-8. Улаанбаатар, 2013, х. 22.
9. ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2014 оны 1 дүгээр сар
10. ҮСХ, Монгол Улсын статистикийн эмхтгэл, 2013 он
11. ҮСХ, Ажиллах хүчний судалгаа, 2013 он
12. ҮСХ, Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, 2009. <http://web.nso.mn/AAZMS/web/detail/29>
13. Дэлхийн Банк. Бизнес эрхлэхүй 2014, Илтгэл
<http://www.doingbusiness.org/data/exploreeconomies/mongolia/starting-a-business>
14. Дэлхийн Банк. Бизнес эрхлэхүй 2008, Илтгэл
<http://www.doingbusiness.org/~media/GIAWB/Doing%20Business/Documents/Annual-Reports/English/DB08-FullReport.pdf>

ХАВСРАЛТ: А, Б

ХАВСРАЛТ А: НЭМЭЛТ ХҮСНЭГТҮҮД

Нэмэлт хүснэгт 1 – Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн ААН, байгууллагын тоо, хариуцлагын хэлбэрээр

Эх сурвалж: YCX

Хариуцлагын хэлбэр	2008	2009	2010	2011	2012
Компани	43130	46893	55996	53142	74335
Төрийн өмчит үйлдвэрийн газар	651	660	557	260	315
Хоршоо	2595	2681	2563	1755	2821
Нөхөрлөл	3174	3304	3303	2051	2460
Төсөвт байгууллага	4044	4047	4410	3959	3982
Төрийн бус байгууллага	6858	6908	6915	5879	6307
Бусад (хувийн цэцэрлэг, сургууль гэх мэт)	83	81	78	363	320
Нийт	60535	64574	73822	67409	90540

Нэмэлт хүснэгт 2 – Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн ААН, байгууллагын тоо, хариуцлагын хэлбэрээр

Салбар	2008	2009	2010	2011	2012
Нийт	60535	64 574	73 822	67 409	90 540
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загасны аж ахуй, ан агнуур	2638	2 947	3 170	3 514	4 766
Уул уурхай, олборлох үйлдвэр	695	722	808	513	691
Боловсруулах үйлдвэр	4141	4 510	4 912	5 853	7 425
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	276	280	267	239	280
Барилга	2372	2 611	3 057	4 226	5 431
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоцикл, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ	27113	28 685	36 297	26 504	40 331
Зочид буудал, зоогийн газар	2040	2 155	2 228	2 344	2 967
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	2003	2 157	2 344	3 182	4 039
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	1129	1 859	1 208	2 167	2 545
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	4253	4 481	5 000	6 543	8 083
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	1572	1 594	1 662	1 428	2 258
Боловсролын салбарын үйл ажиллагаа	2341	2 396	2 528	3 016	3 186
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	2548	2 636	2 678	2 770	2 993
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	7408	7 535	7 654	5 093	5 526
Бусад	6	6	9	17	19

Эх сурвалж: YCX

Нэмэлт хүснэгт 3 - Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэгчдийн тоо, эдийн засгийн салбараар

№	Салбар	2011 он		2012 он		2013 он		Өөрчлөлт	
		Хүний тоо	Бүтэц, хувь	Хүний тоо	Бүтэц, хувь	Хүний тоо	Бүтэц, хувь	2012/2011	2013/2012
1	Уул уурхай, олборлолт	6,762	5.0	6,133	3.5	4,688	2.3	-9.3	-23.6
2	Боловсруулах үйлдвэрлэл	21,925	16.2	27,436	15.7	29,853	14.9	25.1	8.8
3	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	0	0.0	76	0.0	0	0.0	100.0	-100.0
4	Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент	1,268	0.9	691	0.4	1,169	0.6	-45.5	69.2
5	Барилга	10,069	7.5	10,090	5.8	13,148	6.6	0.2	30.3
6	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээ	52,671	39.0	77,399	44.4	84,433	42.2	46.9	9.1
7	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	28,250	20.9	29,987	17.2	38,823	19.4	6.1	29.5
8	Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	2,876	2.1	5,261	3.0	6,140	3.1	82.9	16.7
9	Мэдээлэл, холбоо	787	0.6	1,627	0.9	2,195	1.1	106.7	34.9
10	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	220	0.2	212	0.1	703	0.4	-3.5	231.5
11	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	173	0.1	159	0.1	43	0.0	-8.2	-72.9
12	Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	905	0.7	1,081	0.6	1,808	0.9	19.5	67.2
13	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	710	0.5	1,298	0.7	832	0.4	82.9	-35.9
14	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын үйл ажиллагаа	385	0.3	323	0.2	109	0.1	-15.9	-66.3
15	Боловсрол	577	0.4	711	0.4	827	0.4	23.3	16.4
16	Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	146	0.1	907	0.5	841	0.4	519.4	-7.2
17	Урлаг, үзвэр, тоглоом наадам	843	0.6	944	0.5	1,771	0.9	11.9	87.7
18	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5,595	4.1	9,496	5.4	12,172	6.1	69.7	28.2
19	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	761	0.6	645	0.4	422	0.2	-15.3	-34.6
20	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	47	0.0	0	0.0	0	0.0	-100.0	
Нийт дүн		134,972	100.0	174,476	100.0	199,978	100.0	29.3	14.6

Эх сурвалж: ҮСХ, Ажиллах хүчний судалгаа, 2013

ХАВСРАЛТ Б: САНАЛ АСУУЛГЫН ХУУДАС

Хавсралт Б-1. ААН-үүдээс авах санал асуулгын хуудас

А. Байгууллага буюу судалгаанд оролцогчийн тухай

Судалгаанд оролцогч			
Албан тушаал	☐ Эзэмшигч ☐ Менежер	☐ Бусад, тодорхой бичнэ үү.....	
Хүйс	☐ Эмэгтэй	☐ Эрэгтэй	
Холбоо барих	Гар утас:	Электрон шуудан:	
Хэзээнээс эхлэн доорх байгууллагад ажиллаж эхэлсэн бэ?	☐ < 1 жил ☐ ≥ 1 – 3 жил	☐ 3 – 5 жил ☐ > 5 жил	
Байгууллагын нэр			
Хаяг	Гудамж:		
	Хороо		
Дүүрэг			
Холбоо барих	Утасны дугаар:	Электрон шуудан:	
Хэзээнээс үйл ажиллагаа эхэлсэн бэ?	☐ 1 жил ☐ ≥ 1 – 3 жил	☐ 3 – 5 жил ☐ > 5 жил	
Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэр.	☐ Бүртгэгдээгүй ☐ Хязгаарлагдмал хариуцлагатай компани. (ХХК) ☐ Хувь нийлүүлсэн компани. (ХК)	☐ Хоршоолол ☐ Нөхөрлөл ☐ Төрийн өмчит хувьцаат компани (ТӨХк).	
Хэзээнээс бүртгэгдсэн бэ?	☐ < 1 жил ☐ 1-3 жил	☐ > 3 жил	
Нийт ажилчдын тоо	☐ 1-4 ☐ 5-9	☐ 10-19 ☐ >20	
Ажилчдын хүйсийн харьцаа	% Эрэгтэй		% Эмэгтэй

Нэг жилийн эргэлтийн хөрөнгийн хэмжээ	☐ ≤10 сая Төгрөг ☐ 10.1-100 сая төгрөг	☐ 100-250 сая төгрөг ☐ 250 саяас-1 тэрбум	☐ >1 тэрбум төгрөг
Бусад салбартай холбоотой байдал	☐ Барилга ☐ Тавилгын үйлдвэрлэл ☐ Нэхмэл, Сүлжмэл үйлдвэрлэл ☐ Барилгын материал үйлдвэрлэл	☐ Худалдаа ба борлуулалт ☐ Тээвэр (бараа, хүн) ☐ Оёдол, нэхмэл ☐ Бусад, тодорхой бичнэ үү.....	
Таны бизнесийн үйл ажиллагаа хаана явагддаг вэ?	☐ Гэртээ (өөрийн ажлын өрөөнд) ☐ Гэртээ (тусгаарласан ажлын өрөөнд) ☐ Тогтмол компанийн ажлын байран дээр	☐ Зах дээр ☐ Явуулын хэлбэрээр ☐ Бусад	

В. Бизнесийн бүртгэл буюу Албажуулалт

1. Танай аж ахуй нэгж бүртгэгдсэн үү?		
☐ Тийм ☐ Үгүй(Хэрвээ үгүй бол шууд 3-р асуултанд хариулна уу?)		
2. Хэрвээ тийм бол бүртгэлийн гэрчилгээ авах хүсэлтээ хэрхэн гаргасан бэ?	☐ Шууд бүртгэлийн албанд хандсан ☐ Цахим бүртгэлийн хэлбэрээр ☐ Зуучлагчаар / зуучлагч байгууллагаар ☐ Нээлттэй хаалганы өдрөөр ☐ Мэдэхгүй ☐ Бусад, тодорхой бичнэ үү	
3. Хэрвээ тийм бол бүртгэлийн гэрчилгээгээ авахын тулд хэдэн өдөр зарцуулсан бэ?	☐ <Ажлын 1 өдөр ☐ Ажлын 1-3 өдөр ☐ Ажлын 4-10 өдөр ☐ >Ажлын 10 өдөр	
4. Хэрвээ тийм бол бүртгэлийн албаны үйл ажиллагааг хэрхэн үнэлж дүгнэж байна вэ?	☐ Маш сайн ☐ Сайн ☐ Муу	☐ Маш муу ☐ Мэдэхгүй

5. Хэрвээ тийм бол танд бүртгүүлэхэд хүндрэлтэй асуудал тулгарч байсан уу?

☐ тийм

☐ үгүй(хэрвээ үгүй бол 7-р асуултанд хариулна уу.)

6. Хэрвээ тийм бол бүртгэлийн явцад танд тулгарч байсан голлох гурван асуудлыг тодорхойлно уу? Өөрийн туршлагаас.

(Гурван хариулт сонгож болно. Хамгийн чухлыг нь 1-ээс эхэлж 3 хүртэл эрэмблэж тэмдэглэнэ үү)

☐ _ Бүртгэлийн журмын талаар мэдээлэл дутмаг.

☐ _ Дүрэм журам болон тавих шаардлагууд нь ойлгомжгүй.

☐ _ Банкинд данс нээлгэх нь түвэгтэй.

☐ _ Өөрийн хөрөнгийн доод хэмжээ хэтэрхий өндөр.

☐ _ Бүртгэлийн хураамж өндөр

☐ _ Албан бус урамшуулал /гар цайлгах/ өндөр

☐ _ Бүртгэлийн албанд таньдаг хүн байхгүй.

☐ _ Гэрчилгээ бэлэн болгох хугацаа нь тодорхойгүй.

☐ _ Төрийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоо сул.

☐ _ Бусад, тодорхой бичнэ үү:

.....

7. Бизнесийн гэрчилгээний нөлөө:

Аж ахуйн нэгжээ бүртгүүлсэний дараа Танд ямар нөлөө үзүүлсэн гэж бодож байна вэ?

(Олон хариулт сонгож болно)

☐ Бизнесийн үйл ажиллагаа илүү найдвартай болсон мэт санагдсан

☐ Төрийн албаныханд төлдөг албан бус урамшуулал /гар цайлгах/ буурсан.

☐ Төрийн албаныхан шалгалт болон бусад шалтгаанаар ирэх нь ихэссэн. (мэргэжлийн хяналт, шалгалт)

☐ Илүү өндөр татвар төлөх шаардлагатай болсон.

☐ Хандивын хүсэлт илүү олон ирэх болсон. /нийгмийн үйл ажиллагаа, бусад/

☐ Ажилчдын нийгмийн даатгал төлөх үүрэг хүлээсэн.

☐ Бусад:

8. Аж ахуй нэгжээ бүртгүүлсэнээр эдгээр боломжуудаас алинд нь илүү оролцох боломжтой болсон бэ? (Олон хариулт сонгох боломжтой)	☐ Төрөөс дэмжиж байгаа хөтөлбөрт хамрагдах ☐ Банкнаас зээл авах ☐ Аж ахуйн нэгжээ даатгалд хамрагдуулах ☐ Мэргэжшсэн чадварлаг ажилтан ажилд авах ☐ Өөрийн хэрэгцээнд тохирсон газрыг ашиглах боломж ☐ Зах зээл, хэрэглэгчдэд нэвтрэх ☐ Бараа бүтээгдэхүүн экспортлох, импортлох боломж ☐ Бодлогын хэлэлцүүлэгт өөрийн ашиг сонирхолыг илэрхийлэх. ☐ Бусад:
9. Танай аж ахуй нэгж ямар төрлийн татвар төлдөг вэ? (Олон хариулт сонгож болно.)	☐ Орлогын албан татвар ☐ Нэмэгдсэн өртгийн татвар ☐ Орлогын хэмжээг тодорхойлох боломжгүй, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд ноогдуулах “Хүн амын орлогын албан татвар”. ☐ Бусад, тодорхой бичнэ үү ☐ Татвар төлөөгүй
10. Албан хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулахад бүртгэлийн гэрчилгээнээс гадна тусгай зөвшөөрөл танд хэрэгтэй юу? ☐ тийм ☐ үгүй(Хэрвээ үгүй бол шууд 14-р асуултанд хариулна уу)	
11. Хэрвээ тийм бол ямар тусгай зөвшөөрөл хэрэг болсон бэ?	☐ Санхүү болон эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой. ☐ Хүрээлэн буй орчныг хамгаалахтай холбоотой ☐ Дэд бүтэцтэй холбоотой ☐ Худалдаа болон үйлдвэрлэлтэй холбоотой ☐ Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын ☐ Эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаатай холбоотой ☐ Шинжлэх ухаан болон боловсролын салбартай холбоотой ☐ Мэдэхгүй ☐ Бусад, тодорхой бичнэ үү.....

12. Хэрвээ тийм бол тусгай зөвшөөрөл авах явцад ямар нэгэн хүндрэлтэй асуудал гарч байсан уу?

☐ тийм

☐ үгүй(хэрвээ үгүй бол шууд 14-р асуултанд хариулна уу.)

13. Хэрвээ тийм бол тусгай зөвшөөрөл авах явцад ямар хүндрэлтэй асуудалтай тулгарсан бэ?

(Олон хариулт сонгож болно)

☐ Тусгай зөвшөөрөл авах талаар мэдээлэл хангалтгүй.

☐ Дүрэм журам болон шаардлага нь хүндрэлтэй.

☐ Төлбөр өндөр.

☐ Албан бус урамшуулал /гар цайлгах мөнгө/ өндөр

☐ Холбогдох албанд таньдаг хүн байхгүй.

☐ Тусгай зөвшөөрлийн бэлэн болох хугацаа нь тодорхойгүй.

☐ Төрийн байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа хангалтгүй.

☐ Бусад, тодорхой бичнэ үү:

.....

D. Бизнесийн орчинг тодорхойлох

14. Өнөөдрийн бизнесийн орчинг 2 жилийн өмнөхтэй харьцуулбал хэрхэн үнэлж дүгнэж байна вэ?

(зөвхөн нэг хариулт)

☐ Маш их сайжирсан

☐ Сайжирсан

☐ Муудсан

☐ Маш их муудсан

☐ Өөрчлөгдөөгүй

☐ Мэдэхгүй

15. Доорхи жагсаалтаас танай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тулгардаг гол асуудлуудыг бидэнд хэлнэ үү.

(Таны бизнесийн үйл ажиллагаанд тулгардаг асуудлаас зөвхөн ноцтой гэж үзсэн асуудлуудыг сонгоно уу?) /Олон хариулт сонгох боломжтой/

Бизнес эрхлэхэд тулгардаг асуудлууд	Хүндрэлтэй асуудлууд✓
1. Харилцаа холбоо	☐
2. Эрчим хүч	☐
3. Тээвэр	☐
4. Газар	☐
5. Татвар	☐
6. Бизнесийн бүртгэл болон зөвшөөрөл	☐
7. Дампуурлын хууль журмууд	☐
8. Төрийн ажилчдын уялдаагүй ажиллагаа	☐
9. Дүрэм журмын уялдаагүй байдал	☐
10. Хуул журмын хэрэгжилт	☐
11. Авилга, хээл хахууль	☐
12. Баталгаатай байдал	☐
13. Бизнесийн өрсөлдөөн	☐
14. Түүхий эдийн олдоц хүрэлцээ	☐
15. Санхүүжилтийн олдоц	☐
16. Зах зээлд нэвтрэх боломж	☐
17. Технологи олж авах боломж	☐
18. Бизнесийн мэдээллийн олдоц	☐
19. Чадварлаг ажиллах хүчний олдоц	☐
20. Хөдөлмөрийн хууль дүрэм	☐
21. Ажилчдын нийгмийн даатгал	☐
22. Үйлдвэрлэлтэй холбоотой техникийн асуудал	☐
23. Бусад, тодорхой бичнэ үү.....	☐

16. Ямар хууль/дүрэм нь Танай аж ахуйн нэгжийн өргөжилтөд болон үйл ажиллагаанд томоохон саад болдог вэ?(Олон хариулт сонгож болно)
- ☐ Бизнесийн бүртгэлтэй холбоотой журмууд.
 - ☐ Тодорхой дэд салбарын тусгай зөвшөөрлийн журмууд.
 - ☐ Хөдөлмөрийн хуулиуд, /цалин хөлсний болон нийгмийн даатгалын/
 - ☐ Татварын журмууд
 - ☐ Дотоодын худалдааны хууль журмууд
 - ☐ Хил дамнасан худалдааны журмууд /экспорт ба импорт/
 - ☐ Хүрээлэн буй орчиныг хамгаалахтай холбоотой журмууд
 - ☐ Хөрөнгө оруулалтын тухай журам. /аж үйлдвэрийн бүс, гадаадын хөрөнгө оруулалт г.м/
 - ☐ Шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах хууль, журмууд.
 - ☐ Бусад, тодорхой бичнэ үү:
17. Таны бодлоор аж ахуй нэгжүүд төрийн албан хаагчаар ямар нэгэн юм хийлгэхийн тулд албан бус урамшуулал /гар цайлгах мөнгө/ төлөх нь энгийн үзэгдэл үү?
- ☐ Тийм
 - ☐ Үгүй(Хэрвээ үгүй бол, шууд 21-р асуултанд хариулна уу.)
 - ☐ Мэдэхгүй
18. Хэрэв тийм бол доорхи тохиолдлуудаас алинд нь албан бус төлбөр төлөх хэрэг гарч байсан бэ? (Олон хариулт сонгож болно.)
- ☐ Бүртгэлийн гэрчилгээ авахын тулд
 - ☐ Тусгай зөвшөөрөл авахын тулд
 - ☐ Төрийн байгууллагатай гэрээт ажил гүйцэтгэхийн тулд /тендер/
 - ☐ Аюулгүй байдлаа хангахын тулд /үймээн самуун, зохион байгуулалттай гэмт хэрэг, г.м/
 - ☐ Нийтийн үйлчилгээний үндсэн сүлжээнд хамрагдахын тулд /цахилгаан, утас, г.м/
 - ☐ Дотоодын хяналт, шалгалт, хуулийн байгууллагатай тохиролцохын тулд.
 - ☐ Дотоодын хууль журмыг мөрдөхөөс зайлсхийхийн тулд
 - ☐ Бусад тохиолдолд, тодорхой бичнэ үү.....
19. Хэрвээ тийм бол танай аж ахуйн нэгж жилд ойролцоогоор хэдэн удаа албан бус төлбөр төлдөг вэ? (зөвхөн 1 хариулт сонгоно уу)
- ☐ 1 удаа
 - ☐ 2удаа
 - ☐ 3 – 4удаа
 - ☐ ≥ 5 удаа
 - ☐ Сар бүр
20. Таны тооцоолж байгаагаар сард ойролцоогоор хэдий хэмжээний төлбөр төлдөг вэ? (зөвхөн нэг хариулт сонгоно уу)
- ☐ мэдэхгүй
 - ☐ <сарын нийт борлуулалтын 1%
 - ☐ Сард борлуулсан хэмжээний 1 – 5%-ийн хооронд
 - ☐ 5.1-10% хооронд
 - ☐ >сард борлуулсан бүтээгдэхүүний 10%

21. Та засгийн газраас дэмжлэг эсвэл татаас авж байсан уу?	☐ Тийм ☐ Үгүй ☐ Мэдэхгүй	
22. Хэрвээ тийм бол төрөөс ямар дэмжлэг татаас авч байсан бэ? (Олон хариулт сонгож болно)	☐ Жижиг дунд үйлдвэрийн сан ☐ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан ☐ УИХ-ын гишүүний дэмжлэг ☐ Инновацийн сан ☐ Цэвэр агаар сан ☐ Мэргэжил боловсрол сургалтын сан ☐ Хөрөнгө оруулалт хөгжлийн сан ☐ ШУ, технологийн сан ☐ Хүрээлэн буй орчиныг хамгаалах сан ☐ Засгийн газрын сангаас ☐ Бусад, тодорхой бичнэ үү.....	
23. Хэрвээ тийм бол засгийн газрын дэмжлэг, татаас нь таны аж ахуйн нэгжийн өрсөлдөх чадвар, өсөлтөнд хэрхэн нөлөөснийг дүгнэнэ үү? /Зөвхөн нэг хариулт/	☐ Өндөр ач холбогдолтой ☐ Нөлөөлсөн ☐ Нөлөөлөөгүй ☐ Чухал нөлөөлөөгүй ☐ Мэдэхгүй	

D. Бизнесийн үйлчилгээ

24. Аж ахуй нэгжүүдийг албан болгож бүртгэлжүүлэхэд нь дэмжлэг үзүүлдэг сүлжээ байдаг уу? /бүртгэлийн мэдээлэл г.м/

- ☐ тийм
☐ үгүй
☐ мэдэхгүй

25. Доорхи бизнесийн үйлчилгээнүүдээс танай аж ахуйн нэгжийг албан болгоход аль нь чухал/ чухал байсан бэ? Таны мэдэж байгаагаар эдгээрийг биелүүлэхэд бэлэн байгаа эсвэл боломжтой юу? Тийм бол зөв тэмдэг тавина уу?

	Бизнесийн үйлчилгээ	Албан болгоход чухал	Бэлэн	Боломжтой
A.	Нягтлан бодох бүртгэл	☐	☐	☐
B.	Хуулийн зөвлөгөө	☐	☐	☐

C.	Бизнесийн төлөвлөгөө бэлтгэх	☐	☐	☐
D.	Зах зээлийн судалгаа	☐	☐	☐
E.	Бизнес инкубатор, зөвлөгөө өгөх, бэлтгэх	☐	☐	☐
F.	Бизнесийн удирдлагын сургалт.	☐	☐	☐
G.	Бизнесийн ерөнхий зөвлөгөө болон мэдээлэл авах.	☐	☐	☐
H.	Мэдээллийн технологийн сургалт, компьютерээр бичих чадвар.	☐	☐	☐
I.	Техникийн ажилчдын сургалт	☐	☐	☐
J.	Технологийн дэмжлэгийг тодорхойлох	☐	☐	☐
K.	Бусад, Тодорхой бичнэ үү	☐	☐	☐

26. Хэрвээ бэлэн эсвэл боломжтой бол үйлчилгээний чанарыг 0-4 оноогоор дүгнэнэ үү?

0 = мэдэхгүй 1 = маш сайн 2 = сайн 3 = муу 4 = маш муу

Бизнесийн үйлчилгээ		Чанар?				
		0	1	2	3	4
A.	Нягтлан бодох бүртгэл	☐	☐	☐	☐	☐
B.	Хуулийн зөвлөгөө	☐	☐	☐	☐	☐
C.	Бизнесийн төлөвлөгөө бэлтгэх	☐	☐	☐	☐	☐
D.	Зах зээлийн судалгаа	☐	☐	☐	☐	☐
E.	Бизнес инкубатор, зөвлөгөө өгөх, бэлтгэх	☐	☐	☐	☐	☐
F.	Бизнесийн удирдлагын сургалт	☐	☐	☐	☐	☐
G.	Бизнесийн ерөнхий зөвлөгөө болон мэдээлэл авах	☐	☐	☐	☐	☐
H.	Мэдээллийн технологийн сургалт компьютерээр бичих чадвар.	☐	☐	☐	☐	☐
I.	Техникийн ажилчдын сургалт	☐	☐	☐	☐	☐

J	Технологийн дэмжлэгийг тодорхойлох	☐	☐	☐	☐	☐
K	Бусад, тодорхой бичнэ ҮҮ.....	☐	☐	☐	☐	☐

27. Танай аж ахуйн нэгж ямар нэгэн мэргэжлийн танхим эсвэл холбооны гишүүн үү? /жишээ нь: ХАҮТ, холбоод/

☐ тийм

☐ Үгүй(Хэрвээ үгүй бол шууд 30-р асуултад хариулна уу?)

28. Хэрвээ тийм бол байгууллагуудыг нь тодорхой бичнэ үү.....

29. Хэрвээ тийм бол тэрхүү гишүүн байгууллагаасаа ямар төрлийн үйлчилгээ авдаг вэ? Үйлчилгээний чанарын түвшинг тодорхойлно уу? (доорхи үнэлгээнд тулгуурлан үйлчилгээний чанарын түвшинг үнэлнэ үү.)

0 = мэдэхгүй 1 = маш сайн 2 = сайн 3 = муу 4 = маш муу

Үйлчилгээний төрлүүд	0	1	2	3	4
Өмгөөлөл, хамгаалал (лобби)	☐	☐	☐	☐	☐
Нягтлан бодох бүртгэл	☐	☐	☐	☐	☐
Хуулийн зөвлөгөө	☐	☐	☐	☐	☐
Бизнесийн төлөвлөгөө бэлтгэх	☐	☐	☐	☐	☐
Зах зээлийн судалгаа	☐	☐	☐	☐	☐
Бизнес инкубатор, зөвлөгөө өгөх, бэлтгэх	☐	☐	☐	☐	☐
Бизнесийн удирдлагын сургалт	☐	☐	☐	☐	☐
Бизнесийн ерөнхий зөвлөгөө болон мэдээлэл авах	☐	☐	☐	☐	☐
Мэдээллийн технологийн сургалт болонх мэдээлэл авах	☐	☐	☐	☐	☐
Техникийн ажилчдын сургалт	☐	☐	☐	☐	☐
Технологийн дэмжлэгийг тодорхойлох	☐	☐	☐	☐	☐

Е. Хөдөлмөрийн асуудлууд болон сургалт

31. Танай байгууллага ажилтнуудтайгаа бичгээр хөдөлмөрийн гэрээ хийдэг үү?	☐ Тийм, бүгдэнтэй нь ☐ Тийм, тэдний заримтай нь ☐ Үгүй, хэнтэй ч хийгээгүй ☐ Мэдэхгүй
--	--

32. Хэрвээ тийм бол гэрээ байгуулснаар
ажилчдад ямар ашигтай вэ?
(Олон хариулт сонгож болно)

- ☐ Нийгмийн даатгал төлөхөд
- ☐ Жил бүрийн амралтын мөнгө авахад
- ☐ Өвчний улмаас тэтгэмж авахад
- ☐ Жирэмсний тэтгэмж авахад.
- ☐ Урьдчилан мэдээлэл өгч байж ажлаас чөлөөлөх
- ☐ Хөдөлмөрийн хуулиар онцгой тохиолдолд нөхөн олговор олгодог. (гэнэт ажлаас халагдсан үед г.м)
- ☐ Бусад, тодорхой бичнэ үү.....
- ☐ Мэдэхгүй

33. Танд ажилчидтай холбоотой ямар нэгэн хүндрэлтэй асуудал байдаг уу?

- ☐ Тийм
- ☐ Үгүй(Хэрвээ үгүй бол шууд 34-р асуултанд хариулна уу.)

34. Хэрвээ тийм бол дараах
асуудлуудаас ямар асуудалтай нь
тулгардаг вэ?

- ☐ Хөдөлмөрийн хууль, журам
- ☐ Ажиллах хүчний олдоц
- ☐ Ажилчдын чадвар
- ☐ Ажилчдын маргаан
- ☐ Ажил хаялт
- ☐ Цалингийн доод хэмжээ
- ☐ Нийгмийн даатгалын зардал
- ☐ Ажилчдын ёс зүй (байнгын өвчтэй байх, байнгын таслалт, ажилчдын ёс зүй, сахилга батгүй байдал)
- ☐ Бусад:.....

35. Танай байгууллагын хувьд өөрийн шаардлагад нийцсэн ажилтан шинээр
авахад харьцангуй хялбар байдаг уу?

- ☐ Тийм
- ☐ Үгүй
- ☐ Мэдэхгүй

